



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.09.22 № A-1/732
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Монголбанк Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 2026 онд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулан Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүний бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцүүлж, олон нийтэд танилцуулан, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт ^{1/34} хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525031919

БАТЛАВ.

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад Улсын Их Хурал төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлахаар, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн барихаар тус тус заасны дагуу төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Монголбанкнаас боловсрууллаа.

Төрөөс 2026 онд баримтлах мөнгөний бодлого инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах, санхүүгийн системийн эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж, дотоод эдийн засагт ирэх аливаа шокийн сөрөг нөлөөг бууруулах, дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэхээр тогтоолын төсөлд тусгасан болно.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь үндсэн чиглэлийг батлах, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг даалгах агуулга бүхий 2 заалттай бөгөөд тогтоолын хавсралтын төсөлд Монголбанкнаас хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд нийт 10 бүлэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгана.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд дотоод эдийн засагт ирэх аливаа сөрөг шокийн нөлөөг бууруулах, эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, банкны салбар бэхжих, санхүүгийн хүртээмж нэмэгдэх, санхүүгийн захын дэд бүтэц, түүний институт бэхжихэд дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Төсөл нь Монгол Улсын бусад хуультай хэрхэн уялдах, цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

Төрөөс мөнгөний бодлогын талаар
2026 онд баримтлах үндсэн чиглэлийн тухай

Төрөөс 2026 онд баримтлах мөнгөний бодлого инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах, санхүүгийн системийн эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж, дотоод эдийн засагт ирэх аливаа шокийн сөрөг нөлөөг бууруулах, дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворжиж байгаа ч геополитийн нөхцөл байдал, худалдааны дайн, өндөр тарифын бодлого, цаг агаарын гамшигт үзэгдэл зэргээс шалтгаалсан гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал өндөр хэвээр үргэлжилж байгаа энэ үед инфляцийг зорилтот түвшинд хүргэж бууруулах нь төв банкны хувьд сорилт болж байна. Монголбанк 2026 онд инфляцыг 6 ± 2 хувийн орчимд тогтворжуулах мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх бөгөөд 2027 оноос эхлэн инфляцийн зорилтын голчийг 5 хувь болгон бууруулах бодлогын чиглэлийг баримтлахаар мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгав.

Монголбанк Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан үндсэн зорилт, чиг үүргийн хүрээнд мөнгөний болон макро зохистой бодлого, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн зах, институтийн хөгжлийг бэхжүүлэх гэсэн гурван чиглэлийн 10 үйл ажиллагааны зорилттойгоор төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсрууллаа.

Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, эдийн засгийн тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх зорилгоор эдийн засаг, санхүүгийн зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах, төв банкны бодлого шийдвэрийг хүртээмжтэй хүргэх замаар инфляцын зорилтыг дунд хугацаанд бууруулж, инфляцыг зорилтот интервалд тогтворжуулна. Төв банк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална. Мөн макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах хүрээнд банкны зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлэх ажлыг үргэлжлүүлэн банкны өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ. Мөн Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндэсний бодлогыг шинэчлэхээр тусгав. Түүнчлэн банк, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Гурав дахь чиглэлийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, Стэйблкойн-ний талаар судлах, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалтын өөрчлөлтөд нийцүүлэн банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан холбогдох хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор холбогдох судалгааг хийх бөгөөд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл, шаардлагыг судалж, зээлдэгчийн хэрэгцээ, салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай уялдуулан боловсруулсан бөгөөд төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдаж, хэрэгжсэнээр Монголбанкнаас баримталж байгаа бодлого дунд хугацаанд үр дүнд хүрч, цаашлаад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтууд биелэх суурь нөхцөлүүд бүрдэх ач холбогдолтой.

Монголбанк мөнгөний бодлогын төслийг боловсруулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулан саналыг авч, Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцүүлэн, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Засгийн газарт танилцуулахаар хүргүүлсэн болно.



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2025 он

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ, АРГА ХЭРЭГСЭЛ

Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулах нь иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляц, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Макро зохистой бодлогын хүрээнд банкны системийн хэмжээнд мөрдүүлэх зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, түүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратеги баримталж байна. Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгдөг. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад хүчин зүйлс, нийт эрэлт, нийлүүлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Мөнгөний бодлогын тайланд тусган улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилттой нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн эдийн засгийн төлөвийн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын хүү болон бусад хэрэгслүүдийн өөрчлөлт нь банк хоорондын захын хүүг өөрчлөн, хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнээр дамжин инфляц, түүний ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлнө. Иймээс бодлогын хэрэгслийн өөрчлөлт нь эцсийн зорилт болох инфляц, эдийн засгийн идэвхжилд тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкнуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Бодлогын хүүний коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ	5
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	8
ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА	60
I. ИНФЛЯЦ	60
II. БОДИТ СЕКТОР	61
2.1. Нийт нийлүүлэлт.....	61
2.2. Нийт эрэлт	64
III. УЛСЫН ТӨСӨВ.....	64
IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	67
4.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв	67
4.2. Инфляцын төлөв	68
4.3. Төсвийн бодлогын төлөв.....	70
4.4. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүдийн төлөв	70
4.5. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв	75
4.6. Инфляцын гол эрсдэлд суурилсан хувилбар төсөөлөл.....	76
V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	79
5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	79
5.2. Орон сууцны зээлийн хөтөлбөр	81
5.3. Мөнгөний зах, хүүний түвшин.....	83
5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш.....	85
VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗЭЭЛ.....	86
6.1. Төлбөрийн тэнцэл.....	86
6.2. Хөрөнгө оруулалтын позиц	89
6.3. Монгол Улсын гадаад өр.....	90

VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	91
7.1. Санхүүгийн салбар	91
7.2. Банк бус санхүүгийн салбар	93
7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв	98
7.4. Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүд	106
СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	111

Шигтгээний жагсаалт

Шигтгээ 1. Япон улсын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн схем	39
Шигтгээ 2. Уур амьсгалын өөрчлөлтийн шинжилгээ, стресс тестийн үр дүн	62
Шигтгээ 3. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээ	72
Шигтгээ 4. “СТОУС 9” стандартын хэрэгжилт	92
Шигтгээ 5. Банкны зохистой засаглалын түүхэн хөгжил ба шинэчлэлийн үе шат	103
Шигтгээ 6. Дэлхийн санхүүгийн зуучлалын шилжилт, түүний манай эдийн засагт үзүүлэх нөлөө	108

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. АМАРБАЯСГАЛАН

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Цахим шилжилт, олон улсын худалдаа, харилцаанд гарч буй өөрчлөлт, түүний нөлөөгөөр олон улсын мөнгө, санхүүгийн тогтолцооны хувьсан өөрчлөгдөж буй орчинд макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1. Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:

1.1. Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын одоогийн голч зорилт болох 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

1.2. Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцсэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.4. Төв банкны бодлого, шийдвэрийг хүртээмжтэй хүргэх, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Банкны өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

2.2. Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндэсний бодлогыг шинэчилнэ.

2.3. Банк, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Цахим шилжилтийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, “Стэйблкойн”-ийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судалж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан холбогдох хуульд хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.3. Бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл, шаардлагыг судалж, зээлдэгчийн хэрэгцээ, салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2026 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Цахим шилжилт, олон улсын худалдаа, харилцаанд гарч буй өөрчлөлт, түүний нөлөөгөөр олон улсын мөнгө, санхүүгийн тогтолцооны хувьсан өөрчлөгдөж буй орчинд макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд тохиосон хүндрэлүүдийг Монгол Улс амжилттай даван туулж, эдийн засаг алгуур сэргэн, харьцангуй тогтворжоод байна. Энэ оны эхний хагаст эдийн засаг 5.6 хувиар өссөний талаас илүү хувийг хөдөө аж ахуйн салбарын сэргэлт тайлбарлаж байна. Тодруулбал, оны эхний хагаст цаг агаарын нөхцөл байдал харьцангуй таатай байснаар өнгөрсөн оны зудын нөлөө арилан, хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар өслөө. Түүнчлэн, төмөр зам, орон сууцны барилгын ажил нэмэгдэн барилгын салбар 25.2 хувиар, үйлчилгээний салбар 4.5 хувиар өссөн нь оны эхний хагаст нийт өсөлтийн багагүй хэсгийг бүрдүүлээ. Ийнхүү эдийн засаг харьцангуй тогтвортой байгаа ч гадаад эдийн засгийн орчинд тодорхой бус байдал өндөр, суурь эрсдэлүүд хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засагт үүсэж буй шокын давтамж нэмэгдэн, тодорхой бус байдал өндөр түвшинд хадгалагдаж байна. Тухайлбал, 2020 оноос хойш Ковид-19 цар тахал, геополитикийн хурцадмал байдал, худалдааны дайн, өндөр тариф зэрэг олон төрлийн сорилтуудтай дэлхий нийтээр нүүр тулгарлаа. Эдгээр шокууд нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлээд зогсохгүй, санхүү, эдийн засгийн тогтвортой байдал, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалд сөргөөр нөлөөлөв. Түүнчлэн, энэ онд АНУ-ын засаг, захиргааны тарифын бодлого нь геополитикийн стратегийн нэг хэсэг болж, гадаад орчин хурдтай өөрчлөгдөж буй нөхцөлд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уян хатан байдлаар хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Төв банкууд инфляцыг тогтворжуулах болон эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилтуудыг тэнцвэржүүлэх хүндхэн сорилттой тулгарч байна. Ковид-19 цар тахал глобал нийлүүлэлтийн гинжин хэлхээний эмзэг байдлыг тодоор харуулж, нийлүүлэлтийн саатлаас үүдэн түүхий эд болон хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ эрчтэй өсч, дэлхий нийтээр инфляц зорилтот түвшнээсээ давсан. Сүүлийн 1 жил гаруй хугацаанд үнийн өсөлт алгуур намжин, инфляц Төв банкуудын зорилтот түвшин рүү бууж байгаа хэдий ч худалдааны дайн, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, цаг агаарын гамшигт үзэгдэл зэрэг олон хүчин зүйлс цаашид инфляцын түвшинг ахин нэмэгдүүлж болзошгүй байна. Иймээс Олон Улсын Төлбөр Тооцооны банкнаас нийлүүлэлтийн шок цаашид харьцангуй өндөр давтамжтай, удаан хугацаанд үргэлжилж болзошгүй болохыг сануулсан байна.¹ Инфляцыг өдөөсөн эдгээр шокууд нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг хязгаарлах хүчин зүйл болж байгаа нь Төв банкны хувьд эдийн засгийн өсөлт бага орчинд инфляцын эрчийг хэрхэн сааруулж, тогтворжуулах нь сорилт болж байна.

¹ Annual Economic Report 2025. Bank for International Settlements, 29 June 2025

Гадаад орчны тодорхой бус байдал өндөр, нийлүүлэлтийн шок ихтэй үед инфляцын хүлээлтийг оновчтой удирдах нь нэн чухал билээ.² Эдийн засаг, санхүүгийн зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах замаар инфляцын зорилтыг дунд хугацаанд бууруулж, цаашлаад нам, тогтвортой инфляцын орчинг бүрдүүлэх нь иргэд, өрх гэрийн худалдан авах чадварыг дээшлүүлэх, бодит орлогыг хамгаалах, тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх суурь нөхцөл болно. Иймээс Монголбанк инфляцыг 2027 оноос эхлэн 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай)³ орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгалаа. Түүнчлэн, Төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа нь бодлогын үр нөлөөг сайжруулж, санхүүгийн зах зээл, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой тул бодлогын шийдвэрүүдээ хүртээмжтэйгээр хүргэж, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, амьжиргааны өртгийн өсөлт, геополитикийн хурцадмал байдал зэрэг хүндрэлүүдээс шалтгаалж олон улсын мөнгө, санхүүгийн тогтолцоо хурдацтай хувьсан өөрчлөгдөн, бодлогын шинэ сорилтуудтай дэлхий нийтээр тулгарсаар байна. Энэхүү сорилтын үед Төв банкууд мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлэхийн тулд бодлогын чиг баримжаа, харилцан уялдааг дахин эргэж харах, тогтвортой байдлыг хангах шинэ гарц, шийдлийг эрэлхийлэх шаардлагыг үүсгэж байгаа билээ.² Түүхий эдийн зах зээлээс өндөр хамааралтай, гадаад шоконд өртөмтгий, жижиг, нээлттэй эдийн засагтай манай улсын хувьд эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хангах, бизнес, санхүүгийн мөчлөгийн хэлбэлзлийг бууруулах нь томоохон сорилт болсоор байна. Ялангуяа, Төв банкны мөнгөний болон макро зохистой бодлогууд нь эдийн засагт үүссэн шокийн шинж чанараас хамаарч оновчтой хослох нь нэн чухал билээ. Иймд, бодлогын “Нэгдсэн тогтолцоог” бүрдүүлэх хүрээнд Монголбанк макро эдийн засгийн болон санхүүгийн бодлогуудын харилцан уялдааг ханган, Макро-санхүүгийн харилцан нөлөө болон санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Төв банкууд бодлогын хүүгээ бууруулж байгаа боловч өндөр түвшинд хадгалсан хэвээр байна. Цар тахлын дараа хөгжингүй орны Төв банкууд бодлогын хүүгээ сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд байгаагүй өндөр түвшинд хүргэсэн. Бодлогын хүү 2024 оны сүүлийн хагасаас алгуур буурч эхэлсэн хэдий ч цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өндөр түвшинд байна. Энэхүү дэлхий нийтээрх мөнгөний бодлогын чангарсан төлөв Монгол улсын зээлийн өртгийг өсгөж, төсвийн дарамт болон өрийн үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, Монголын эрдэс бүтээгдэхүүний эрэлт буурч, ялангуяа БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил суларвал экспортын орлого огцом буурч, төлбөрийн тэнцлийн алдагдал болон гадаад санхүүжилтийн зөрүү нэмэгдэх эрсдэлтэй. Иймд, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш гадаад шокийг шингээж, эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй, уян хатан тогтох зарчмыг тууштай баримтлах шаардлага

² Монголбанкнаас зохион байгуулсан “Дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын өндөр түвшний хурал, 2025 он.

³ 2026 онд 6 хувийн (+/-2 нэгж хувийн инвервалд) орчимд тогтворжуулах

хэвээр байна. Төгрөгийн ханш макро суурь нөхцөлтэй нийцтэй тогтож, эдийн засагт шок шингээгчийн үүргээ гүйцэтгэснээр аливаа цочролын үед хурдан тохиргоо хийгдэх боломжийг олгохын зэрэгцээ экспорт болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг дэмжих юм.

Геополитикийн нөхцөл байдал, АНУ-ын тарифын бодлого, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв болон түүхий эдийн зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөө нь манай улсын гадаад эрэлт, экспортын орлогыг бууруулах дам нөлөөг үзүүлж эхлээд байна. Иймээс Монгол улсын хувьд шинэ түншлэл болон бүс нутгийн хэлэлцээрийг эрэлхийлэн, хувьсан өөрчлөгдөж буй энэхүү цаг үед өртгийн сүлжээнд оролцох байр сууриа нарийвчлан тодорхойлох, олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь нэн чухал болоод байна.⁴

Банкны эрсдэл даах чадамжийг бэхжүүлж, хяналт шалгалтын арга хэрэгслийг сайжруулах хүрээнд Монголбанк өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг банкны хүлээгдэж буй эрсдэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох үнэлгээний аргачлалууд, холбогдох зохицуулалт, арга хэрэгслийг Базелын стандартын Бүлэг 2-ын хүрээнд нэвтрүүлээд байна. Цаашид эдгээр аргачлал, зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэж буй аливаа хүндрэл дутагдлыг арилгах, банкуудад мөрдөгдөж ирсэн бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, хууль тогтоомж, журам, зөвлөмжтэй уялдуулж боловсронгуй болгох шаардлага бий болоод буйг харгалзан үзэж өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын шаардлагын хувь хэмжээг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, банкуудад нөөц өөрийн хөрөнгийг бүрдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгалаа.

Монгол Улсын дараагийн ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд ФАТФ-ын шаардлагын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлд суурилсан үнэлгээг хийх, салбараар эрсдэлийн түвшинг тогтоох ажлыг зохион байгуулна. Тус үнэлгээний үр дүнд суурилан МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлын түвшинг тодорхойлох, оролцогч талуудын цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, МУТСТ үндэсний бодлого, стратеги, санхүүжүүлэх арга хэмжээг шинэчлэхээр төлөвлөж байна.

Технологийн шинэчлэл, цахим шилжилтийн эрин үед санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, төлбөр тооцооны дэвшилтэт арга хэрэгслүүд хурдтай нэвтэрч, төв банкны үйл ажиллагаа ч дижитал шилжилтэд хөл нийлүүлэн бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь чухал болоод байна.⁴ Тухайлбал, төв банкны үйл ажиллагаанд орчин үеийн технологи, хиймэл оюун ухааныг ашигласнаар мэдээлэл боловсруулах, шинжлэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох, ажилчдын бүтээмжийг сайжруулах боломжтой. Нэг талаас хиймэл оюун ухааны хөгжил, дижитал шилжилт нь үйлдвэрлэлийг дэмжих чухал хүчин зүйл боловч ажлын байрыг бууруулах байдлаар хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлт бий болгох эрсдэлтэйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч байна. Манай орны хувьд дижитал шилжилт амжилттай явагдаж байгаа ч хөдөө орон нутаг дахь дэд

⁴ Монголбанкнаас зохион байгуулсан “Дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын өндөр түвшний хурал, 2025 он.

бүтцийн ялгаа, ур чадварын дутагдал, хиймэл оюун ухааны ёс зүй, зохицуулалтын орчны тодорхой бус байдал зэрэг нь гол сорилт болж байна. Мөн ирээдүйн боловсролыг шинэчлэх, ажиллах хүчнийг дижитал шилжилтэд бэлтгэж, шинэ ур чадварт сургах нь чухал болоод байна.⁵

Монголбанк “Монгол Улсын Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичигт тулгуурлан холбогдох эрх зүйн орчин, хяналтын тогтолцоог хөгжүүлж, инноваци шингэсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд бодлого, зохицуулалтын аливаа давхардал үүсэхээс сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн хууль, журамд шаардлагатай өөрчлөлт оруулах, зохицуулалтыг тодорхой болгох, олон нийтийн ойлголтыг сайжруулах арга хэмжээг авахаар тусгалаа.

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл Монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд тохиосон хүндрэлүүдийг амжилттай даван туулж, эдийн засгийн өсөлт харьцангуй тогтворжин, инфляц дунд хугацаанд Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлтэй байна. Гэвч экспортын гол зах зээл болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын үргэлжилсэн хүндрэл, дэлхийн зах зээл дээр гангийн буурч буй эрэлт зэрэг нь Монгол Улсын экспортолж буй нүүрсний үнэд сөргөөр нөлөөлөх замаар төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж байгаа нь гадаад, дотоод тэнцвэр алдагдах нөхцөлийг бий болгож болзошгүй байна. Түүнчлэн, дэлхийн эдийн засагт сүүлийн саруудад тарифын бодлого, түүнийг дагасан тодорхой бус байдал нэмэгдэж, нийлүүлэлтийн болон олон улсын худалдааны доголдол, түүнээс үүдэлтэй хуваагдал үүсээд байна. Цаашид нефтийн нийлүүлэлтийн тасалдал үүсэх, цаг агаарын нөхцөл муудан өвөлжилт хүндрэх, өвлийн улиралд эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдал бий болох зэрэг нь инфляцыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг сааруулж болзошгүй байна.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаа нь дотоод эдийн засагт ирэх аливаа сөрөг шокийн нөлөөг бууруулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

⁵ Монголбанкнаас зохион байгуулсан “Дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт олон улсын өндөр түвшний хурал, 2025 он.

1. МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:


ЗОРИЛТ 1.1

Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг дунд хугацаанд 5 хувийн (+/-2 нэгж хувийн интервалтай) орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын одоогийн голч зорилт болох 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

Үндэслэл

Төв банкны тухай хуульд мөнгөний бодлогын үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах буюу үнийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон. Өргөн хэрэглээний барааны үнийн хэлбэлзлийг бууруулж, инфляцыг урьдчилан тодорхойлсон зорилтот интервалын орчимд тогтворжуулах нь зах зээлийн тодорхой бус байдлыг бууруулан иргэд, бизнес эрхлэгчдийн хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг хялбаршуулж, улмаар дунд, урт хугацаанд макро эдийн засгийн өсөлт тогтвортой байх чухал суурь нөхцөл болдог. Мөн инфляц бага, тогтвортой түвшинд байх нь иргэдийн худалдан авах чадвар, бодит орлогыг хамгаалах, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхой бус байдлыг бууруулж улмаар ажил эрхлэлтийг бууруулах нөлөөтэй. Энэ нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжиж, улс орны тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлдэг.


Зураг 1. Инфляц



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Манай улсын хувьд 2024 оны дунд үед 4.6 хувьд хүрч буураад байсан инфляцын түвшин төсвийн тэлэлт, хөдөлмөрийн бүтээмжээс давсан цалингийн өндөр өсөлт, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ нэмэгдсэнээс шалтгаалан 2025 оны 2-р сард 9.6 хувьд хүрч эрчтэй нэмэгдээд байв. Гадаад, дотоод тэнцвэр алдагдсан, тодорхой бус байдал өндөр үед Монголбанк инфляцыг зорилтын түвшинд хүргэж бууруулах бодлогыг баримтлан ажилласан. Мөнгөний бодлогын төлөв чангарсан, худалдааны түнш орнуудын үнийн түвшин буурч, тогтворжсоноос инфляц сүүлийн 5-н сар дараалан алгуур буурч, 2025 оны 7 дугаар сарын байдлаар инфляцын зорилтот интервалын дээд хязгаар руу дөхөж 8.1 хувьд хүрээд байна.

Зураг 2. Хэрэглээний сагсны бараа, бүтээгдэхүүний тоо, жилийн өсөлтөөр



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк


Мөнгөний бодлогын хэрэгслүүд нь эдийн засаг дахь дотоод эрэлтийн бүрдэл хэсгүүдэд буюу эрэлтийн шалтгаантай инфляцад нөлөө үзүүлдэг. Харин нийлүүлэлтийн болон зардлын шинжтэй инфляцад мөнгөний бодлого шууд нөлөө үзүүлэхгүй хэдий ч тэдгээрийн дам нөлөөг багасгах, инфляцын хүлээлтийг тогтворжуулахад хариу үйлдэл үзүүлэх шаардлага үүсдэг. Хөгжингүй орнуудын инфляцын хүлээлт тогтворжин, буурах хандлага үргэлжилж Төв банкуудын зорилтот түвшний орчим ирээд байна. Энэ нь гадаад хүү буурах нөхцөл бүрдүүлж байна. Гэхдээ тарифын бодлого эрчимжиж, худалдааны дайн, геополитикийн хуваагдал гүнзгийрч болзошгүй байгаа нь олон улсад тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, улс орнуудад томоохон сорилт болж байна. Иймээс Монголбанк дотоод эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, эрэлт, нийлүүлэлтийн

шинжтэй хүчин зүйлсийн нөлөөлөл, гадаад эдийн засгийн нөхцөл болон эдгээрийн цаашдын төлөвийн талаарх одоогийн боломжит бүхий л мэдээллийг мөнгөний бодлогын шийдвэр гаргахад ашиглаж байна.

Мөнгөний бодлогын шийдвэр тодорхой хугацааны дараа бодит эдийн засагт нөлөөлдөг тул Төв банк инфляцын зорилтыг дунд хугацаанд тодорхойлдог. Ингэснээр богино хугацаанд гарах түр зуурын хүчин зүйлсийн (жишээ нь: дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, улирлын шинжтэй нийлүүлэлтийн доголдол гэх мэт) нөлөөг даван туулах, хэт мэдрэмтгий хариу арга хэмжээ авахаас сэргийлэх боломж бүрдэнэ. Түүнчлэн инфляцын дунд хугацааны зорилт нь өрх, аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн хүлээлтийг тогтвортой байлгаж, үнэ, цалин, хөрөнгө оруулалтын шийдвэрээ зөв гаргахад нь дэмжлэг болдог. Нөгөө талаар дунд хугацааны зорилт нь Төв банканд үнийн тогтвортой байдлаас гадна бодит эдийн засгийн идэвхжилийг харгалзах боломж олгох юм. Иймээс Монголбанк инфляцын зорилтоо дунд хугацаанд тодорхойлж, бодлогоо энэ хүрээнд чиглүүлнэ.

Хөгжиж буй орнуудын эдийн засаг богино хугацаанд бүтцийн өөрчлөлтөнд ордог учраас хүчин зүйлс салбар дамжин шилжих шаардлагатай болно. Үүнтэй уялдуулан эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлого нь инфляцын зорилтыг цэгэн голчтой, интервал утгаар тогтоосноор илүү үр дүнтэй байдаг⁶. Тиймээс Монголбанк инфляцын дунд хугацааны зорилтыг 5+/-2 хувийн орчимд тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын 2025, 2026 оны голч зорилт болох 6+/-2 хувийг 2027 оноос 5+/-2 хувь болгон бууруулна.

Зураг 3. Инфляц, бүрэлдэхүүн хэсгээр



Эх сурвалж: YCX, Монголбанк

1. Mishkin, F. S. (2008). *Does Inflation Targeting Matter?* International Journal of Central Banking, 4(2), 29–82. <https://www.ijcb.org/journal/ijcb08q2a2.pdf>
2. International Monetary Fund (2018). *The Case for Flexible Inflation Targeting*. IMF Working Paper WP/18/8. <https://www.imf.org/en/Publications/WP/Issues/2018/01/26/The-Case-for-Flexible-Inflation-Targeting-45531>

Гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт суларч, орлого буурах үед эдийн засгийн идэвхжил хумигдаж, төгрөгийн ханш сулрах дарамттай тулгардаг. Үүний улмаас импортын бараа, шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, инфляцын дарамт гадаад сувгаар дамжин нэмэгдэх эрсдэлтэй. Тиймээс ханшийн огцом хэлбэлзлээс зайлсхийх, валютын нөөцийг оновчтой ашиглах, мөн төгрөгийн бодит өгөөжийг хадгалах зэргээр төгрөгт итгэх итгэлийг хадгалах нь бодлогын гол хэрэгсэл болно.

Стратеги

1. **Инфляцыг өдөөж буй хүчин зүйлс, шокууд, тэдгээрийн үргэлжлэх хугацаа болон ирээдүйд үүсэж болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлж бодлого боловсруулах.** Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүү нь зээл, хүү, ханш, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импортод нөлөөлөх замаар эдийн засгийн идэвхжилийг эрэлт талаас удирдаж, инфляцад нөлөөлнө. Харин нийлүүлэлт, зардлын шалтгаантай үнийн өсөлтийн үед түүний дам нөлөө, хүлээлтэд үзүүлэх нөлөөнөөс хамаарч мөнгөний бодлогын хариу үйлдэл үзүүлнэ.
2. **Инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах зорилгоор мөнгөний бодлогын төлөвийг өөрчилнө.** Түр зуурын эсвэл байнгын шинжтэй инфляцад нөлөөлж буй хүчин зүйлсийг зөв таниж, дунд хугацаанд инфляцыг тогтворжуулах бодлого баримтлана. Учир нь түр зуурын, улирлын шинж чанартай үнийн өсөлтөд бодлогын хариу арга хэмжээ авах нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх, хүлээлтийг буруу удирдах эрсдэлтэй. Тиймээс инфляцад нөлөөлж буй хүчин зүйлийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, шокын шалтгаан зэргийг харгалзаж, тооцоо судалгаанд үндэслэн ирээдүйд чиглэсэн шийдвэр гаргана.
3. **Тодорхой бус байдал, эдийн засгийн эрсдэлийг харгалзан үзэж мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.** Инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж мөнгөний бодлогын шийдвэр гаргахаас гадна ерөнхий макро эдийн засагт учирч болзошгүй хүндрэл, шокуудыг мөнгөний бодлогын шийдвэр гаргалтдаа харгалзан үзнэ.

Мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах боломжгүй инфляцын хэлбэлзлийг бууруулахад эдийн засгийн бусад агентуудын үүрэг чухал юм. Тиймээс дунд, урт хугацаанд инфляцыг нам, тогтвортой түвшинд барихад дараах арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал:

- Эдийн засгийг олон тулгууртай болгон төрөлжүүлэх. Ингэснээр валютын ханшийн савлагааг тогтворжуулах, инфляцад шилжих нөлөөллийг бууруулах зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлнэ;
- Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах хүчний ур чадварыг нэмэгдүүлэх. Энэ нь цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөөг бууруулна;
- Төсвийн сахилга бат, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн хэт халалт, уналтын мөчлөг дагасан бодлогоос зайлсхийх;
- Гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулах;

- Нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг сайжруулах. Энэ нь барааны түр хугацааны хомсдолоос үүдсэн үнийн өсөлтөөс сэргийлэхэд тусална;
- Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга батыг сайжруулахад чиглэсэн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх. Ингэснээр иргэдийн хэрэглэх, хуримтлуулах зан төлөвт эергээр нөлөөлнө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, хараат бусаар, хамтын зарчимд тулгуурлан гаргана. Мөнгөний бодлогын хороог жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулах бөгөөд хурлын товыг оны эхэнд зарлана. Хорооноос гарсан шийдвэр эдийн засагт оролцогчдын үйл хөдлөлд нөлөөлөх замаар эрэлт, ханш, инфляцын хүлээлтийг удирдахад чухал ач холбогдолтой юм.
- Мөнгөний бодлого боловсруулж шийдвэр гаргах үйл явцыг сайжруулж, бодлогын шийдвэрийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд:
 - Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн харилцан хамаарал, мөнгөний бодлогын шилжих сувгийн талаарх судалгааг өргөжүүлэх;
 - Эдийн засгийн шинжилгээ, төсөөлөл, учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлоход шаардлагатай тоон болон чанарын мэдээллийн баазыг өргөтгөх;
 - Төсөөлөл, симуляци хийх шинжилгээний загваруудыг сайжруулж, хөгжүүлэх;
 - Олон улсын байгууллагууд, төв банкууд, судалгааны байгууллагуудтай хамтран шинжилгээ, тооцоолол дээр ажилладаг экспертүүдийн ур чадварыг дээшлүүлэх;

ЗОРИЛТ 1.2

Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Түүхий эдийн зах зээлээс хамааралтай, жижиг нээлттэй эдийн засагтай манай улсын хувьд гадаад эдийн засгийн орчны нөлөө өндөр тул макро эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг зэрэг хангах нь томоохон сорилт болсоор байна. Өөрөөр хэлбэл, гадаад орчны таатай нөхцөл бүрдсэн үед эдийн засаг, санхүүгийн системд хэт халалт үүсэхээс сэргийлж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, нөгөөтэйгүүр эдийн засагт сөрөг шокууд зэрэг тулгарсан үед макро эдийн засгийн уналгаас сэргийлэх, тогтворжуулах байдлаар бизнесийн мөчлөгийн далайцыг бууруулж, урт хугацааны тогтвортой хөгжилд

дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Энэ нь бодлого боловсруулагчдын зүгээс макро эдийн засгийн болон санхүүгийн бодлогуудыг хослуулан ашиглах шаардлагыг бий болгож байна.

Дэлхийн санхүү, эдийн засгийн 2008-2009 оны хямрал нь нийт санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг тодотгож өгсөн. Улмаар тухайн хямралаас хойш дийлэнх улс орнууд макро зохистой бодлогын тогтолцоог хөгжүүлж, тохиромжтой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байгаа нь тодорхой үр дүнд хүрээд байна. Тухайлбал, Ковид-19 цар тахлын үед дэлхий даяар банкны системд эрсдэл үүсэж, бодит эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрсэн тул Европын холбооны орнууд “Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц сан”⁷-ийн хэмжээг бууруулж, зээл олголтыг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжих арга хэмжээ авсан байна. Энэхүү мөчлөг сөрсөн бодлого нь Европын банкны системийн зээл олголтыг 2020 оны 2 дугаар улирлаас идэвхжүүлж, нийт активт эзлэх зээлийн хэмжээг дунджаар 5.6 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлжээ (Özlem болон бусад, 2023).

Манай улсын хувьд 2018 онд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх, үүргийг Монголбанканд олгосон. Улмаар Монголбанк нь санхүүгийн системийн мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.


Бизнесийн зээл олголт, үл хөдлөх хөрөнгийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалан богино хугацаанд унаад байсан Монгол Улсын санхүүгийн мөчлөг 2024 оны 2 дугаар улирлаас эерэг утгатай болж, санхүүгийн мөчлөг өрнөлийн үед шилжээд байна. Банкны салбараас 2025 оны эхний хагаст 32.8 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өсөж, эхний хагас жилийн нэрлэсэн ДНБ-ий 79.4 хувьтай тэнцэж байна.

Зээл олголт нэмэгдэж, санхүүгийн систем тэлэх нь аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа, эдийн засгийн өсөлтийг дэмжих эерэг нөлөөтэй боловч иргэдийн хэрэглээний зээл хэт ихээр нэмэгдэх нь өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлж, санхүүгийн системийн эмзэг байдлыг бий болгохын зэрэгцээ хэрэглээний импортыг дэмжиж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах сөрөг үр дагавартай байдаг. Цалин, тэтгэврийн орлого 2023 оноос хурдтай нэмэгдэж эхэлснээр хэрэглээний зээл эрчимтэй өсөж, улмаар тухайн оны нийт зээлийн өсөлтийг хэрэглээний зээлийн өсөлт голлон тайлбарлаж байв. Харин эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн болон банкны салбараас олгох хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах чиглэлд Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын арга хэмжээг чангаруулсанаар хэрэглээний зээлийн өсөлт саарч, бизнесийн зээлийн өсөлт сэргэх хандлагатай байна. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар

⁷ Countercyclical capital buffer (CCyB) - Макро зохистой бодлогын үндсэн арга хэрэгсэл бөгөөд дэлхийн 92 улсад ашигладаг.

банкны салбарын нийт зээл жилийн 27.0 хувиар өссөний 6.1 нэгж хувийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлж байна.


Зураг 4. Бизнесийн болон санхүүгийн мөчлөг Зураг 5. Банкны зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын зээлийн долларжилтын хэмжээ сүүлийн жилүүдэд бууран тогтвортой бага түвшинд хадгалагдаж, 2025 оны 6 дугаар сарын байдлаар 6.2 хувьд хүрээд байна. Эх үүсвэрийн долларжилтын хувьд 2022 оны ханшийн огцом сулралтын үед 36.5 хувьд хүрч байсан бол 2023 оноос эхлэн экспорт, төлбөрийн тэнцэл сайжирч, ГВУН нэмэгдсэнээр гадаад валютын ханш тогтворжиж, үүнийг даган банкны системийн эх үүсвэрийн долларжилт үргэлжлэн буурч байна. Тодруулбал, 2025 оны 6 дугаар сарын эцэст эх үүсвэрийн долларжилт 21.8 хувьд хүрлээ.

Зураг 6. Зээл, хадгаламжийн долларжилт Зураг 7. Банкуудын валютын хадгаламжийн хүү болон гадаад суурь хүү



Эх сурвалж: Монголбанк

Гадаад зах зээлд эрсдэлгүй хүүгийн түвшин буурч байгаа нь хөрөнгийн гадагшлах урсгалыг сааруулах, валютын ханшинд ирэх дарамтыг сулруулах хүлээлттэй байна.

Монгол Улсын арилжааны банкнуудын зарлаж буй ам.долларын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (4.0%) нь ам.долларын эрсдэлгүй хүү болох АНУ-ын ЗГ-ын 5 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж (4.0%)-тэй ижил түвшинд, АНУ-ын Холбооны Нөөцийн Банкны бодлогын хүү (4.25%-4.50%)-нээс бага зэрэг доогуур түвшинд байна.

Дэлхий дахинд үүсээд буй геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдал, томоохон гүрнүүд хоорондын худалдааны дайн зэрэг нь манай улсын экспортын гол түнш орон болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх, улмаар дэлхийн түүхий эдийн зах зээлд сөрөг шок, үнийн савлагааг бий болгож, түүхий эдийн эрэлт буурах эрсдэлийг дагуулж байна. Иймд ирэх онд гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянах, банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь чухал хэвээр байна.

Стратеги

Монголбанк нь макро зохистой бодлогыг тодорхойлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээний цогц загварыг сайжруулж, үр дүнг бодлогын шийдвэр гаргалтанд ашиглана.
- Макро, санхүүгийн бодлогын нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэн, үр дүнг зах зээлд оролцогчдод мэдээлж, хүлээлтийг удирдах арга хэмжээнд ашиглаж эхэлнэ.
- Санхүүгийн системд үүсэж буй эрсдэлүүдийн шинжилгээ, хяналтыг сайжруулан, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэрийг гаргахдаа мөнгөний, ханшийн болон макро зохистой бодлогын харилцан үйлчлэлийг харгалзан үзнэ.
- Макро, санхүүгийн бодлогуудын арга хэрэгслүүдийн үр нөлөө, харилцан хамаарлыг тодорхойлох шинжилгээний цогц арга зүйг хөгжүүлнэ.

ЗОРИЛТ 1.3

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцсэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

Үндэслэл

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй уян хатан байдлаар хэлбэлзэх нь макро эдийн засгийн дотоод, гадаад тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, нээлттэй, чөлөөт хөрөнгийн урсгалтай⁸, мөнгөний бодлогоо бие даан хэрэгжүүлдэг улсын хувьд валютын ханшийг

⁸ ОУВС-ын 2013 онд боловсруулсан Хөрөнгийн дансны нээлттэй байдлын индексийн (Capital Account Openness Index) тооцооллоор Монгол Улс 0.73 байсан бол хөгжингүй орнуудын дундаж нь 0.68 байжээ (IMF, Capital Account Openness Dataset, 2013).

тогтмол барих гэж оролдох нь урт хугацаандаа гадаад валютын нөөцийг шавхаж, гадаад төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэл дагуулдаг. Мөн манай улсын эдийн засаг эрдэс бүтээгдэхүүний олон улсын зах зээл дээрх үнийн өөрчлөлтөд хэт мэдрэг байдаг тул төлбөрийн тэнцлийн сөрөг шок үүсэх үед уян хатан валютын ханш нь гадаад шокийг өөртөө шингээн, эдийн засгийн бодит сектор, ажил эрхлэлтэд үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлэх механизм болдог бөгөөд эдийн засгийг шинэ нөхцөл байдалд хурдан дасан зохицоход дэмжлэг үзүүлж, эдийн засгийн тэнцвэр богино хугацаанд хангагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ ханшийн уян хатан байдал нь гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулж, дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахад чухал нөлөөтэй.

Түүнчлэн, макро эдийн засгийн үзүүлэлтүүд тогтвортой байсан ч валютын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бүрдүүлж буй оролцогчдын хэмжээ, тэдгээрийн үйл ажиллагааны улирлын онцлог, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээ бага зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан богино хугацаанд валютын зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом хэлбэлзэх боломжтой. Энэ нь зах зээлд түр зуурын шинжтэй цочрол үүсгэж, улмаар зах зээлд оролцогчдын хүлээлт, үйл хөдлөлд нөлөөлөх замаар цочролын хэмжээг дэвэргэх сөрөг нөлөө гарч болзошгүй байдаг. Иймд уг эрсдэлийг бууруулах үүднээс Монголбанк уян хатан ханшийн бодлого баримтлахын зэрэгцээ богино хугацаанд үргэлжлэх шинжтэй эрэлт нийлүүлэлтийн зөрүү үүсэх тохиолдолд түр зуурын хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор зах зээлд оролцох хэрэгцээ үүсдэг.

Эрдэс бүтээгдэхүүний экспортод суурилсан эдийн засагтай манай орны хувьд уян хатан валютын ханшийн бодлогыг баримтлахдаа валютын ханшийн огцом хэлбэлзлийг бууруулахын зэрэгцээ экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Ингэснээр гадаад орчны тодорхойгүй байдлаас үүдсэн эрсдэлийг бууруулж, дотоод санхүүгийн зах зээлийн тогтвортой үйл ажиллагааг хамгаалах замаар урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг.

Стратеги

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг хангаж, валютын захад ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор оролцоно.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого нь гадаад зах зээлд бий болсон аливаа сөрөг цочролын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлэх, экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг хамгаалахад чиглэдэг.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ханшийн хэлбэлзэл зах зээлд үүсэж улмаар санхүүгийн тогтвортой байдал алдагдахаас сэргийлэх үүднээс гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанк тухай бүр захад оролцоно.
- Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг тогтвортой хадгалах, нийт нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэр татах ажлыг зохион байгуулна.
- Валютын захын оролцогчдын хүлээж буй ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 1.4

Төв банкны бодлого, шийдвэрийг хүртээмжтэй хүргэх, хүлээлтийг удирдахад чиглэсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа нь орчин үед мөнгөний бодлогын нэг хэрэгсэл болон хөгжсөн бөгөөд бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээл болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжихэд чухал үүрэгтэй.

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь төв банкны үндсэн зорилт болон гаргасан шийдвэр, түүний үндэслэл болох эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвийн талаарх мэдээллийг санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, бусад бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийт зэрэг оролцогч талуудад түгээх үйл ажиллагаа юм.

Мэдээллийг үр дүнтэй түгээснээр олон нийтийн хүлээлтийг удирдаж, зах зээл дээрх тодорхой бус байдлыг бууруулж мөнгөний бодлогын шийдвэрийг эдийн засагт илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Олон улсын судалгааны үр дүнгүүд олон нийттэй харилцах харилцаа нь төв банкны бодлогын шийдвэрийн урьдчилан таамаглагдахуйц байдлыг дээшлүүлж, зах зээлийн хэлбэлзлийг бууруулж, инфляцын хүлээлтийг тогтворжуулахад чухал хувь нэмэр оруулдаг болохыг харуулдаг.

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь мөнгөний бодлогын шилжих сувгуудын нөлөөллийг нэмэгдүүлж, улмаар бодлогын дохио нь урт хугацаатай хүүгийн түвшин, инфляцын хүлээлтэд богино хугацаанд нөлөөлөх боломжийг нэмэгдүүлдэг. Мөн олон нийттэй харилцах харилцаагаар дамжуулан мэдээллийн тэгш бус байдал болон эрсдэлийн премиум буурах, зах зээл илүү үр ашигтай ажиллах боломж бүрддэг зэрэг эерэг нөлөөтэй байна. Түүнчлэн, олон нийттэй харилцах харилцаагаар дамжуулан зах

зээлийн хүлээлтийг илүү үр дүнтэй удирдсанаар инфляцын үр дүнг сайжруулах, мөн зах зээлийн хүлээлтийг бодлогын зорилготой нийцүүлэх боломжийг олгодог. Үүнээс гадна, олон нийтийн итгэл, байгууллагын нэр хүнд, хууль ёсны байдлыг нэмэгдүүлэхэд мөн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Мультимедиа болон социал медиа зэрэг шинэлэг харилцааны хэрэгсэл ашиглах нь иргэдийн насны онцлогт тохирсон ялгаатай мэдээллийн хэрэгслийг ашиглах боломжийг олгож, улмаар олон нийттэй харилцах харилцааны хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна. Хүртээмжтэй, ойлгомжтой, тууштай олон нийттэй харилцах нь төв банкны бодлогын зорилтыг дэмжихийн зэрэгцээ, түүний хараат бус байдлыг бататгахад хувь нэмэр оруулна.

Стратеги

Монголбанк олон нийттэй харилцах харилцаагаа хөгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтална:

- Төв банкуудын олон нийттэй харилцах харилцааг олон улсын сайн туршлагуудыг дотоодын зах зээлийн онцлогт нийцүүлж нэвтрүүлнэ.
- Олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, түгээх сувгуудыг хөгжүүлэхдээ зах зээлд оролцогч талуудын нас жендер, санхүү эдийн засгийн суурь мэдлэг, зан төлөвийн онцлогт нийцүүлнэ.
- Орчин үеийн технологийн дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх замаар мэдээлэл түгээх хурд, хамрах хүртээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Мэдээллийн агуулга, чанарыг сайжруулах тал дээр хийх ажлууд:

- Төв банкнаас олон нийтэд түгээх мэдээллийн чанар, агуулгыг тогтмол сайжруулах институт, процессийн шинэчлэлтүүдийг хийнэ.
- Эдийн засгийн шинжилгээ, төсөөллийн чанарт үнэлгээ хийж, сайжруулалтуудыг тогтмол хийнэ.
- Мөнгөний бодлогын шинжилгээ хийдэг загваруудыг үнэлж, тогтмол сайжруулна.
- Мөнгөний бодлогын мэдэгдлийн формат, агуулгыг тогтмол сайжруулна.
- Мөнгөний бодлогын тайлангийн бүтэц, агуулгыг тогтмол сайжруулна.
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийнэ;
- Төв банкны дотоод мэдээллийн урсгалыг оновчтой болгох сайжруулалтуудыг нэвтрүүлнэ.

Мэдээлэл түгээх сувгуудын шинэчлэлт:

- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичгүүдэд үнэлэлт шинэчлэлт хийнэ;
- Төв банкнаас мэдээлэл түгээх сувгуудыг тасралтгүй хөгжүүлнэ;

- Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлын зохион байгуулалтыг тогтмол сайжруулна;
- Төв банкнаас нийтэлдэг статистик мэдээллүүдийг хуваарийн дагуу олон нийтэд түгээж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нийгмийн цахим сүлжээг ашиглана;
- Орон нутагт мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлнэ;
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудтай тогтмол уулзалт, сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангана;
- Олон улсын байгууллагуудаас Төв банкны олон нийттэй харилцах харилцааны чиглэлд өгсөн зөвлөмжийн дагуу олон нийттэй харилцах үйл ажиллагааг боловсронгуй болгоно;
- Төв банкны IАРОС индексийг сайжруулах олон нийттэй харилцах харилцааны өөрчлөлт, шинэчлэлтүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 2.1

Банкны өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор дэлхийн улс орны төв банк, хяналт шалгалтын зохицуулагч байгууллагуудаас өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоон банканд мөрдүүлж, холбогдох хяналт шалгалтын арга хэмжээний тогтолцоог бүрдүүлдэг. Ингэснээр банк аливаа эрсдэлийг даахад хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө, хөрвөх чадвартай хөрөнгийг бүрдүүлж, системийн хэмжээний эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох хүрээнд олон улсад мөрдөгддөг ерөнхий зарчмууд, сайн жишгийг Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан Базелийн цуврал стандартуудад тодорхойлсон байдаг бөгөөд улс орны төв банкнууд, зохицуулагч байгууллагууд өөрийн орны банкны салбарын онцлогтой нийцүүлэн дунд болон урт хугацаанд хэсэгчлэн эсхүл бүрэн нэвтрүүлсэн байдаг.

Манай улсын хувьд банкны тухай хууль тогтоомжид заасны дагуу Монголбанк нь банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулж, холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хүлээдэг. Энэ үүргийн хүрээнд, Монголбанк банкны эрсдэл даах чадамжийг бэхжүүлэх, хяналт шалгалтын арга хэрэгслийг сайжруулах зорилтуудыг бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлсээр ирсэн. Тухайлбал, сүүлийн жилүүдэд банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг банкны эрсдэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох зорилт бүхий Базел стандартын Бүлэг 2-ын үнэлгээний аргачлалуудыг туршилтын байдлаар нэвтрүүлж, холбогдох журмын төсөл, арга хэрэгслийг боловсруулан ажиллалаа. Цаашид эдгээр аргачлалуудыг бүрэн нэвтрүүлэхэд банканд мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон холбогдох бусад хууль тогтоомж, журам, зөвлөмжтэй уялдуулах нь нэн чухал байна.

Түүнчлэн, одоо мөрдөгдөж буй зохицуулалттай холбоотойгоор банкны Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шаардлага нь нийт өөрийн хөрөнгийн шаардлагаас давах, улмаар банк Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө бүрдүүлэх сэдэл, шаардлага үүсэхгүй байх нөхцөл байдал үүсээд байгаа нь холбогдох эрх зүйн зохицуулалт, журам зааварт өөрчлөлт оруулж, шинэчлэх шаардлагыг үүсгэж байна.

Одоо мөрдөгдөж буй зохистой харьцааны журамд банкны Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн актив (ЭЖА)-ын зохистой харьцааны доод хэмжээг 9 хувь, Нийт өөрийн хөрөнгө, ЭЖА-ын зохистой харьцааны доод хэмжээг 12 хувиар тогтоосон байдаг. Үүнээс гадна эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг банкнуудын системийн ач холбогдолтой эсэхээс шалтгаалан 2-4 хувийн хооронд тогтоодог. Гэвч нөөц интервалыг зөвхөн Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөр бүрдүүлэхээр зохицуулсан. Энэ нь Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөр бүрдүүлэх шаардлагатай харьцаа үзүүлэлтийг 11-13 хувьд хүргэж, системд нөлөө бүхий банкны хувьд нийт өөрийн хөрөнгийн шаардлага болох 12 хувиас өндөр гарахаар байна. Улмаар банкны зүгээс Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг төвлөрүүлэх сонирхол, ач холбогдол буурах, татан төвлөрүүлсэн тохиолдолд, эх үүсвэрийн зардал нэмэгдэх, нэг болон нийт өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүд ижил байх гэх зэрэг дутагдлууд одоо мөрдөгдөж буй зохицуулалтад илрээд байна.

Банк Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэх нь нийт өөрийн хөрөнгийн бүтцийг баяжуулж, банкны тогтвортой үйл ажиллагаа алдагдах нөхцөлд буюу банкны төлбөрийн чадвар алдагдаж, албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үед хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамаарах хэрэгслүүд нь эх үүсвэрийн зардал багатай бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх зэрэг зэрэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Үүний зэрэгцээ, Монголбанкнаас туршилтын байдлаар нэвтрүүлж буй Базел стандартын Бүлэг 2-ын хүрээнд банкнуудад тогтоох нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага нь нийт өөрийн хөрөнгийн шаардлага дээр нэмэгдэх тул нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод шаардлагыг олон улсын стандарт болон Монгол Улстай төстэй бусад хөгжиж буй улс орны банкны системд хэрэгжиж буй шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан шинэчлэн тогтоох шаардлага үүсээд байна.

Иймд, Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэрэгцээ, ач холбогдол, үр ашгийг тусгасан байдлаар өөрийн хөрөнгийн шаардлагын хувь хэмжээг шинэчлэн тогтоох, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийвчлан тодорхойлох, хөрвөх чадварын шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэх нь нэн чухал байна.

Стратеги

- Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа холбоог сайжруулж, олон улсын стандарттай нийцүүлэн тогтоох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэн найруулах, эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар нэвтрүүлэх зарчмыг баримтална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг банкнуудад танилцуулан хэлэлцүүлж, санал авах, хэрэгжилтийн хугацааг тодорхойлох.
- Базел стандартын Бүлэг 2-ын шаардлага болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (LAAP)-г банкнууд дотооддоо үнэлэх, Монголбанкнаас хяналт шалгалтын үнэлгээг (SREP) гүйцэтгэхтэй холбоотой журмуудыг батлуулах.

ЗОРИЛТ 2.2

Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндэсний бодлогыг шинэчилнэ.

Үндэслэл

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-ээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийх Харилцан үнэлгээг 2028 онд эхлэх хуваарь гарсан. Харилцан үнэлгээгээр улс орнуудын сүүлийн 4-5 жилийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийн, эрсдэлд суурилсан хэлбэрээр МУТСТ үйл ажиллагааг үр дүнтэй явуулж буй эсэхийг тодорхойлно. Олон Улсын Валютын Сангийн Дүрмийн 4 дүгээр заалтын дагуу ажлын хэсгийн 2025 онд гаргасан урьдчилсан дүгнэлтэд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх тал дээр хангалттай ахиц дэвшил гаргасан хэдий ч үр дүнтэй байдалд анхаарал хандуулах шаардлагатай байгаа талаар дурджээ. Иймд үндэсний эрсдэлийн үнэлгээ болон ФАТФ-ын зөвлөмж стандартын өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь суурилан Монгол Улсын МУТСТ бодлого стратегийг нэн даруй шинэчлэх, үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр төр болон хувийн хэвшил хамтран ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Харилцан үнэлгээг 2007 болон 2017 онуудад хийж байсан бөгөөд хангалтгүй үр дүн үзүүлсний улмаас 2 удаа ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орсон байдаг. Иймд дараагийн Харилцан үнэлгээнд бэлтгэх, Монгол Улсын МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, дахин “саарал жагсаалт”-д орохоос сэргийлэх зорилгоор 2025 онд үндэсний эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх, ФАТФ-ын зөвлөмж стандартын үр дүнтэй байдлын өөрийн үнэлгээг хийх зэрэг хэд хэдэн томоохон ажлуудыг эхлүүлсэн бөгөөд 2026 онд эцэслэн, дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

ФАТФ-ын Зөвлөмжийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан зарчмаар явуулах шаардлагатай бөгөөд үндэсний, салбарын, мэдээлэх үүрэгтэй этгээдийн түвшинд эрсдэлийн үнэлгээг хийдэг. МУТСТ үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүн тооцох, эрсдэлийн үнэлгээг шинэчлэх ажиллагааг дөрвөн жилд нэг удаа зохион байгуулахаар заасан байдаг. Монгол Улсын гурав дахь удаагийн үндэсний эрсдэлийн үнэлгээг 2025 онд Дэлхийн банкны аргачлалаар хийх шийдвэрийг Үндэсний зөвлөлөөс гаргасан. Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/76 дугаар тушаалаар Санхүүгийн мэдээллийн албаны даргаар ахлуулсан, дэд ахлагчаар Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар ажиллах, дэд ажлын хэсгүүдийн ахлагч нараас бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсгийн хуралдаанаар дэд ажлын хэсгүүдийг байгуулахаар шийдвэрлэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалаар 35 төр болон хувийн хэвшлийн байгууллагын 270 орчим албан хаагчаас бүрдсэн 12 дэд ажлын хэсгийг байгуулж, үндэсний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх аюул занал, эмзэг байдал, санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг хийж байна. Дэд ажлын хэсгүүд ажлын төлөвлөгөө гарган, Дэлхийн банкны аргачлалын дагуу хууль журам, тогтолцоо, статистик тоон мэдээ гаргах, төрийн болон хувийн холбогдох байгууллагуудаас асуумж, ярилцлага авах зэргээр шаардлагатай дата мэдээллийг цуглуулж байна. Эдгээрийг нэгтгэн ажлын хэсгийн хэмжээнд болон салбарын мэргэжилтнүүдийг хамруулан хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулах, үнэлгээг эцэслэх, тайлан бичих, үнэлгээний үр дүнг олон нийтэд танилцуулж, соён гэгээрүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөсөн бөгөөд 2025 онд багтаан дуусгахаар ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/75 дугаар тушаалаар ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын өөрийн үнэлгээг хийх ажлын хэсгийг байгууллаа. Ингэхдээ сүүлийн жилүүдэд ФАТФ, АНДМУТБ-ийн үнэлгээчин, хянагч бэлтгэх сургалтад хамруулсан 15 орчим албан хаагч болон бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ФАТФ-ын үнэлгээний аргачлалыг ашиглан, 40 зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлж буй эсэхийг үнэлнэ.

Эрсдэлийн үнэлгээ болон ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд суурилан МУТСТ үндэсний бодлого стратегид нэмэлт өөрчлөлт оруулан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломжтой болно. Ингэснээр МУТСТ үйл ажиллагааны бодит үр дүнг дээшлүүлэх, шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах, дараагийн Харилцан үнэлгээнд амжилттай үр дүн үзүүлэх, олон улсад эерэгээр үнэлэгдэх үндэс болох юм.

Монгол Улс өнгөрсөн хугацаанд албан хаагчдыг чадавхжуулах, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дараагийн Харилцан үнэлгээнд бэлтгэхэд туршлага хуримтлуулахаас гадна Монгол улсын туршлагыг олон улсад хуваалцах чиглэлээр

томоохон амжилт гаргасан. Тухайлбал ФАТФ, АНДМУТБ-ийн үнэлгээчин, хянагч бэлтгэх сургалтад хамрагдсан гурван албан хаагч Лаос улсын Харилцан үнэлгээний үнэлгээчин, Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгээс Непал улсад хийх үнэлгээний хянагч, Вьетнам улсын Явцын тайлангийн үнэлгээчнээр тус тус ажиллан бусад улсын тогтолцоог үнэлж, туршлага хуримтлуулаад байна. Мөн Монгол Улсын төлөөлөл ФАТФ-ын Виртуал хөрөнгийн бүлэгт АНДМУТБ-ийг төлөөлөн ажиллахаар сонгогдон Монгол Улсын виртуал хөрөнгийн зохицуулалтын орчны туршлага хуваалцах, олон улсын бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцож байна.

Хүрэх үр дүн:

Монгол Улсын эрсдэлийн үнэлгээ болон ФАТФ-ын зөвлөмж стандартуудын өөрийн үнэлгээний үр дүнд суурилан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого стратегийг шинэчилснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Үндэсний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул занал, эмзэг байдал, эрсдэл, санхүүгийн болон санхүүгийн бус салбаруудын мөнгө угаах эрсдэлийн түвшинг тодорхойлох;
- Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын түвшинг тодорхойлох;
- Мэдээлэх үүрэгтэй этгээд, СМА, хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх, хөрөнгө хураах ажиллагаа, гааль, татвар, улсын бүртгэлийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнтэй байдал, дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого стратегийг үндэсний хэмжээний аюул занал, эмзэг байдалтай уялдуулан шинэчилснээр ФАТФ-ын Зөвлөмжийн дагуу эрсдэлд суурилсан хэлбэрээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Дараагийн Харилцан үнэлгээнд бэлтгэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх.

Стратеги

- Үндэсний эрсдэлийн үнэлгээг 11 Модулийн хүрээнд хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул занал, эмзэг байдал, эрсдэлийн түвшинг тодорхойлох;
- ФАТФ-ын Үнэлгээний аргачлалын дагуу үр дүнтэй байдлын өөрийн үнэлгээг хийж, оролцогч талуудын цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хууль журам, тогтолцооны мэдээлэл, статистик тоон мэдээ цуглуулах, холбогдох талуудаас асуумж, ярилцлага авах;
- Ажлын хэсгийн хүрээнд болон салбарын мэргэжилтнүүдийг хамруулан хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан гаргах;
- Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнг олон нийт, салбарын мэргэжилтнүүдэд таниулах;
- Үр дүнтэй байдлын өөрийн үнэлгээг хийх зорилгоор Монгол Улсын нөхцөл байдал, онцлог, эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлгээний хамрах хүрээг гаргах;
- ФАТФ-ын 11 Шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу статистик, тоон мэдээ гаргуулан, оролцогч талуудад газар дээрх шалгалт хийх;
- Цуглуулсан тоон мэдээлэлд суурилан үр дүнтэй байдлын үнэлгээг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- Үндэсний хэмжээнд хэрэгжих “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах;
- Өөрөө өөрийгөө үнэлэхэд ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

ЗОРИЛТ 2.3

Банк, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Олон улсын Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын 2012 оны хурлын үр дүнд “Их 20” (G20)-ийн удирдагчид санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогыг онцгой ач холбогдолтой гэж үзэн, улс орнууд үндэсний түвшинд санхүүгийн боловсролын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэхдээ баримтлах үндсэн зарчмуудыг баталсан. Үүний үр дүнд санхүүгийн боловсролын үндэсний стратеги хэрэгжүүлж буй орнуудын тоо жилээс жилд өссөөр байна. Тухайлбал, 2012 онд 26 улс 2013 онд 46, 2015 онд 60 болж нэмэгдсэн бөгөөд 2025 оны байдлаар 71 улс иргэдийнхээ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Мөн 120 гаруй улс иргэдийнхээ санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг тогтмол явуулж байна.

Монгол Улсын хувьд ч хөгжлийн түвшнээ даган иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэгцээ, ирээдүйн төлөвлөлт хийх чадвартай иргэн

төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Санхүүгийн боловсрол нь иргэдийн хувийн болон нийгмийн сайн сайхан байдлыг хангах үндсэн суурь болдог. Иргэдийн санхүүгийн мэдлэг, чадвар, зөв хандлага нь хувь хүнийг хариуцлагатай шийдвэр гаргах, урт хугацааны зорилт тавих, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг оновчтой сонгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Үүнээс гадна санхүүгийн зах зээлийн хөгжил, банк санхүүгийн системийн тогтвортой байдал, цаашлаад улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтөд үнэтэй хувь нэмэр оруулна.

Стратеги

- Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бусад төв банкуудын санхүү, эдийн засгийн мэдлэг түгээх сайн туршлагыг судалж, нэвтрүүлнэ.
- Зорилтот бүлэг бүрийн онцлогт тохирсон сургалт, мэдээллийн арга хэлбэрийг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- Сургалт, мэдээлэл түгээх үйл ажиллагаанд технологийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлж, ашиглана.
- Залуу үеийн хэрэглээ, сонирхолд нийцсэн мэдээллийн сувгуудыг хөгжүүлж, түгээнэ.
- Сургагч багш нарыг үе шаттайгаар бэлтгэн, чадавхыг нь сайжруулна.
- Орон нутгийн иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 3.1

Цахим шилжилтийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, “Стэйблкойн”-ийг төлбөрийн хэрэгсэл болгох боломжийг судалж, олон улсын зарчмын дагуу төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монголбанк нь Төв банкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу төлбөрийн системийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд зах зээлд шинээр нэвтэрч буй төлбөрийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл, санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Үүний зэрэгцээ төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийх, төлбөрийн системийн үнэлгээг хийснээр олон улсын стандартад нийцүүлэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд “Төлбөрийн системийн хяналтын бодлого”, “Төлбөрийн системийн журам”, “Автомат клиринг хаус системийн дүрэм”, “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”, “Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм” зэрэг Монголбанк төдийгүй төлбөрийн системийн оролцогчдын мөрдөж ажиллах бодлого, журам, дүрмүүдийг боловсруулж ажилласны зэрэгцээ банк, финтек байгууллагуудаас ирүүлсэн зөвшөөрөл олгох хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан шаардлагын дагуу цахим мөнгө, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх, аутсорсингийн зөвшөөрөл зэргийг шинээр олгосон.

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд, тухайлбал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан зөвшөөрөлтэй давхардсан зөвшөөрлийг олгох, бутархай цахим мөнгөний зохицуулалт тусгагдаагүй, мөн хуулийн зарим заалт ойлгомжгүй, тодорхойгүй, бүрэн эрхийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авах боломжгүй байх зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Иймээс, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа тул бусад хууль, журамтай нийцүүлэн холбогдох саналыг боловсруулна.

Монголбанк нь “Монгол Улсын Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичгийг 2022 онд баталсан. Тус стратеги нь аюулгүй, найдвартай, үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн системийг цогцлоох, төлбөрийн үйлчилгээг цахимжуулахад чиглэсэн.

Технологийн шинэчлэл, цахим шилжилтийн эерэг нөлөөгөөр шинээр нэвтэрч буй санхүүгийн төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой дэвшилтэд бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд эрх зүйн баримт бичгүүд болон хяналтын тогтолцоонд цаг тухайд нь холбогдох өөрчлөлтийг тусгаж ажиллах шаардлага үүсээд байна. Эдгээр инновацитай нийцсэн бодлого, зохицуулалтын орчны ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг бууруулах, давхардал гарахаас сэргийлэх, зарим шаардлагатай арга хэмжээ авахад хуулиар олгосон бүрэн эрх хэмжээ хүрэхгүй байх гэх зэрэг хүндрэл бэрхшээл үүсэх эрсдэлийг бууруулахаар ажиллаж байна.

Энэ хүрээнд, олон улсын банк, санхүүгийн системд Төв банкуудын зүгээс нэвтрүүлдэг цахимжсан төлбөрийн хэрэгсэл буюу цахим мөнгөний нэг хэлбэр болох “Стэйблкойн”-ийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийн талаар бодлогын суурь судалгааг боловсруулж, улсын эдийн засагт үзүүлэх нөлөө, санхүүгийн хэрэглэгчдийн хүртээмжэд гарах өөрчлөлт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл зэргийг судална.

Уламжлалт хил дамнасан корреспондент банкны тогтолцоо нь ихэвчлэн олон зуучлагчид, өндөр шимтгэл, хэдэн өдрөөр үргэлжлэх төлбөр тооцооны саатал дагуулдаг. Харин блокчэйн дэд бүтцэд суурилсан “Стэйблкойн” нь харилцагч хоорондын гүйлгээг хурдан, бага өртгөөр гүйцэтгэж, олон улсын худалдаа болон мөнгөн гуйвуулгын саадыг бууруулдаг давуу талтай. Дэлхийн “Стэйблкойн”-ийн зах зээлийн хэмжээ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 252 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний 68 хувийг АНУ-ын Тэтер (Tether, USDT) эзэлж байна (Barry & Kathleen 2025). Харин Stable Coin-ийн гүйлгээний нийт эргэлт 2024 оны байдлаар 27.6 их наяд ам.долларыг давсан нь Виза болон Мастеркарт байгууллагын гүйлгээний эргэлтийг нийлүүлснээс өндөр дүнг эзэлж байгаа юм. Одоогийн байдлаар Өмнөд Америкийн Бразил, Венесуэль, Мексик зэрэг улсууд хэрэглээндээ нэвтрүүлсэн бол Хонгконг, Япон зэрэг улсууд 2025 онд тус төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх хуулийг батлаад байна. Иймд энэ төрлийн төлбөрийн хэрэгслийн ач холбогдол, нэвтрүүлэх боломжийг нэн даруй судлах шаардлага үүсч байна.

Стратеги

- Үндэсний төлбөрийн системийн эрх зүй, зохицуулалтын орчны уялдаа холбоог сайжруулах, шинэ инновац, шилдэг технологид суурилсан төлбөр тооцооны хэрэгслийг дэмжиж ажиллах, төлбөрийн системд хяналт тавих замаар найдвартай, тасралтгүй байдлыг хангаснаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Үндэсний төлбөрийн системд мөрдөж буй журам, дүрэм, зааварт шаардлагатай өөрчлөлтийг тухай бүрд нь оруулж, зохицуулалтын орчны уялдаа холбоо, давхцалыг арилгахын зэрэгцээ шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжинэ. Энэ хүрээнд төлбөрийн системийн одоогийн дэд бүтцэд суурилсан банк хоорондын “нэхэмжлэлийн гүйлгээ”-г нэвтрүүлэхээр Монголбанк төлбөрийн системийн оролцогч нартай хамтран ажиллаж эхлээд байна.
- Монголбанк төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд төлбөрийн системийн оролцогчийн цахим мөнгө, операторын шалгалт зэргийг газар дээрх болон зайнаас тавих төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн, хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлын дагуу гэнэтийн шалгалтуудыг цаг тухай бүрд нь хийнэ.
- Үндэсний төлбөрийн системийн хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс “Стэйблкойн”-ийг гаргахад үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлд бодлогын суурь судалгааг боловсруулж, шинэ төлбөрийн хэрэгсэл нэвтрүүлэх боломжийн талаар бодлогын санал боловсруулан, шаардлагатай тохиолдолд туршилтын ажлыг эхлүүлэх.

ЗОРИЛТ 3.2

Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан холбогдох хуульд хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1-т “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу хүний эдийн засгийн эрх, эрх чөлөөг дээдэлсэн чөлөөт зах зээл дэх төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Монгол Улсын Төв банкны эрх зүйн байдлыг 1996 онд хуульчлан баталгаажуулсан. Тус хууль болон төв банкны үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг, салбарыг нарийвчлан зохицуулсан зарим хуулиуд болох Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш цөөнгүй удаа нэмэлт, өөрчлөлт орсон ч эдгээр хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хугацаанд Хууль

тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ хийгдэж байгаагүй болно.

Монгол Улсад 2028–2029 онд ФАТФ-аас Харилцан үнэлгээний тав дахь шатны шалгалтыг хийхээр урьдчилан төлөвлөж байгаагаар холбогдуулан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн явцыг 2025–2026 онуудад багтаан үнэлж, ФАТФ-ын шалгалтад үр дүнтэй бэлтгэх, шаардлагатай арга хэмжээг урьдчилан авах нь зүйтэй байна.

Түүнчлэн төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг салбарын хуулиар зохицуулж, уг харилцаанд оролцогчдын эрх зүйн байдлыг сайжруулах, бодлогын түвшинд мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах талаар тодорхой шийдвэр гаргах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байх тул Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг гүйцэтгэнэ.

Монгол Улсын банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь банкны зээлийн хүүг өсгөх, санхүүгийн зуучлалд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийн идэвхжилтийг сулруулан, бодит секторын өсөлтийг хязгаарлах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, халамжийн зардлыг өсгөх зэрэг сөрөг нөлөөтэй тул банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах, активыг эдийн засгийн эргэлтэд оруулж үнэ цэнийг алдуулахгүй байх зорилгоор олон улсын туршлага, бүс нутгийн хандлагыг харгалзан чанаргүй зээл, активыг шийдвэрлэх нэг хэрэгсэл болох Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Стратеги

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ олон улсын жишиг, холбогдох аргачлалыг ашиглан, судалгаа, дүгнэлт гаргана;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу мэргэжлийн байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эдийн засаг, хууль зүйн судлаач нарын оролцоог хангана;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаанд үндэслэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг олон нийтэд болон төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэгч талуудад мэдээлж, нэгдмэл ойлголтыг бүрдүүлж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлнэ;
- Актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчны судалгаа хийнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийн санал, дагалдах судалгаа, баримт бичгийг боловсруулна;
- Актив Удирдлагын компанийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийн санал, дагалдах баримт бичгийг боловсруулна;
- Хуулийн төслийн саналыг хууль санаачлагчид уламжилна;
- Хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэж батлахад хэлэлцүүлэг зохион байгуулах, шаардлагатай баримт бичиг боловсруулах, мэдээлэл өгөх зэргээр хууль санаачлагч, холбогдох байнгын хороодтой хамтран ажиллана;
- Хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.

ЗОРИЛТ 3.3

Бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл, шаардлагыг судалж, зээлдэгчийн хэрэгцээ, салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын арга хэмжээг боловсруулна.

Үндэслэл

ААН-үүд бизнесийн үйл ажиллагаанд хээл, хахууль, ядуурал, улс төрийн байдал, ажилгүйдэл зэрэг нийгэм, улс төрийн хүчин зүйлс хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлдэг бол санхүүжилтийн орчны хүчин зүйлс удаах сөрөг нөлөө үзүүлдэг гэж үнэлж байна (Монголбанк, 2023)⁹.


Улс орнуудын эдийн засгийн өрсөлдөх чадвар, хувийн хэвшлийн тогтвортой өсөлт, ажлын байр бий болгох чадавх нь санхүүжилтийн хүртээмжтэй шууд холбоотой байдаг. Манай Улсын бизнесийн байгууллагуудын хувьд санхүүжилтийн гол эх үүсвэр нь банкны зээл байдаг бөгөөд зээлийн хүү, хугацаа, барьцаа хөрөнгийн шаардлага зэрэг зээлийн нөхцөлүүд ямар байх нь зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.¹⁰

Сүүлийн жилүүдэд банкны салбарын нийт зээлийн өсөлт гол төлөв өрхийн зээлээр тайлбарлагдаж, хувийн хэвшлийнхэнд очиж буй зээлийн хэмжээ болон нөхцөл дорвитой сайжраагүй байна. Жишээлбэл, банкнаас иргэдэд олгосон зээл (*ипотекийн зээл, ЖДҮ зээлийг оруулснаар*) 2025 оны II улирлын байдлаар 25.7 их наяд төгрөгт хүрч, 2017 онтой харьцуулахад 3.8 дахин өссөн бол хувийн хэвшилд олгосон зээл 16.5 их наяд төгрөг буюу 2017 оноос 2.4 дахин л өсөөд байна.


⁹ Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, Монголбанк, 2023

¹⁰ Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, Монголбанк, 2023

Зураг 8. Бизнесийн орчны индекс, бүлгээр (1=сайн, 0=дунд, -1=муу)




Зураг 9. Бизнесийн орчны индекс, зарим үзүүлэлтээр (1=сайн, 0=дунд, -1=муу)



Эх сурвалж: Монголбанк, "Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал", 2023


Мөн нэг зээлдэгчид ногдох дундаж зээлийн дүн 2017 онд ойролцоогоор 1,018 сая төгрөг байсан бол 2025 оны II улиралд 990 сая төгрөг буюу төдийлөн нэмэгдээгүй байна. Үүнээс гадна “Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал” түүвэр судалгааны үр дүнгээс харахад бизнесийн байгууллагуудын хүсэж буй дундаж зээлийн хэмжээ, хугацаа нь бодитоор олгогдож буй зээлийн дүн, нөхцөлтэй нийцгүй байна. Энэ нь байгууллагууд санхүүжилтийн хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүйд хүргэж, цаашлаад эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын боломжуудыг хязгаарлаж болзошгүй байна.

Зураг 10. Банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 11. Банкуудын нэг зээлдэгчид ногдож буй зээлийн дундаж дүн (хувийн хэвшлийн зээл)



Эх сурвалж: Монголбанк

Банкны зээлийн нөхцөлийг авч үзвэл банкнаас хувийн хэвшилд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2017 оноос хойш 2025 оны эхний хагас гэхэд дөнгөж 0.8 нэгж хувиар буурсан бол иргэдэд олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү 2.8 нэгж хувиар тус тус буурчээ. Мөн зээлийн жигнэсэн дундаж хугацаа сүүлийн 8 жилд


төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Үүний зэрэгцээ “Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал” түүвэр судалгааны үр дүнгээр бизнесийн байгууллагуудад санхүүжилт авахад тулгарч буй хамгийн тулгамдсан хүндрэл нь “барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур байдал” гэж хариулсан. Энэ нь бизнесийн санхүүжилтийг дэмжихэд зээлийн барьцааны үнэлгээний аргачлалыг сайжруулах, төрөл хүрээг өргөжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Зураг 12. Банкуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, хугацаа



Эх сурвалж: Монголбанк

Зураг 13. Хүсэж буй зээлийн дундаж хугацаа



Эх сурвалж: Монголбанк, “Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал”, 2023


Иймд, эдийн засгийн тэлэлтийн боломжийг бүрэн ашиглах, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, чанаргүй зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор хувийн хэвшлийнхний үйл ажиллагааны онцлогт нийцсэн, төрөлжсөн, уян хатан нөхцөл бүхий банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.

Дэлхийн банкнаас явуулдаг улс орнуудын бизнесийн орчин, санхүүгийн байдлыг тодорхойлсон “Аж ахуйн нэгжийн түүвэр судалгаа”-ны санхүүгийн хүртээмжийн гол үзүүлэлтүүдийг харахад манай улсын аж ахуйн нэгжүүд нь банканд зээлийн болон хадгаламжийн данс эзэмшигчдийн үзүүлэлтээр бусад улс орнуудтай ойролцоо түвшинд байна. Харин банкны зээл шаардлагатай аж ахуй нэгжүүдийн нийтэд эзлэх хувь нэлээдгүй өндөр буюу бусад улс орнуудтай харьцуулахад зээлийн хэрэгцээ ихтэй байна. Гэвч тэдгээрийн дийлэнх нь банкны зээлийн нөхцөл, шаардлага, судлах үйл явц зэргээс шалтгаалан банканд зээлийн хүсэлт гаргадаггүй байна (World Bank, 2019).¹¹


Мөн манай улсын аж ахуйн нэгжүүдийн нийт зээл бүгд ямар нэгэн барьцаатай байх бөгөөд бусад улсуудад нийт зээлийн 68 нь барьцаатай байна. Түүнчлэн бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй хүчин зүйлсийг үнэлэхэд манай улстай орлогын ангиллаар ойролцоо улсуудтай харьцуулахад санхүүжилтийн хүндрэл хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

¹¹ Enterprise Surveys, World Bank, 2019


Зураг 14. Банкны зээл шаардлагатай ААН-ийн эзлэх хувь




Зураг 15. Зээлийн хүү, барьцаа хөрөнгө, судлах үйл явц зэргээс шалтгаалан зээлийн хүсэлт гаргаагүй ААН-ийн эзлэх хувь



Зураг 16. Барьцаатай зээлийн эзлэх хувь



Зураг 17. Бизнесийн үйл ажиллагаанд санхүүжилтийн хүндрэлийн дундаж үзүүлэлт



Манай Улсад хувийн хэвшил тэр дундаа ЖДҮ дэмжих чиглэлд Зээлийн батлан даалтын сан болон ЖДҮ-ийг хөгжүүлэх сан зэрэг төрийн оролцоотой бүтэц үйл ажиллагаа явуулж байна. Зээлийн батлан даалтын сан гэхэд сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд (i) ... зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа ЖДҮ эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах; гэж тусгагдсан хэдий ч одоогийн баталгаа гаргасан бүтцийг харвал 2025 оны эхний хагасын байдлаар тус сангийн батлан даалттай олгосон зээлийн үлдэгдэл 782.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 90.5 хувийг иргэнд, ердөө 9.5 хувийг аж ахуйн нэгжид олгожээ (Монцамэ агентлаг, 2025).¹² Эндээс үзвэл банкны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд тус сангийн үйл ажиллагааг хувийн хэвшилд чиглүүлэх боломж харагдаж байна.

¹² Зээлийн батлан даалтын сан оны эхний улиралд 841 шинэ баталгаа олгожээ

Шигтгээ 1. Япон улсын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн схем

Олон улсын туршлагаас харахад эдийн засгийн өсөлт, ажиллах хүчний дийлэнх хувийг жижиг, дунд бизнесүүд болон хувийн хэвшил бүрдүүлдэг. Иймээс улс орнууд ЖДҮ-ийг дэмжих хүрээнд төр-хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэн, хэрэгжүүлдэг туршлага бий. Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн хувьд банкны зээлийн хүртээмжийг хязгаарлаж буй гол шалтгаан нь санхүүгийн байгууллагууд баталгаатай санхүүгийн тайлан, тогтвортой орлого, хангалттай барьцаа хөрөнгө шаардаж байгаатай холбоотой. Үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал зэрэг уламжлалт барьцаа хангалтгүй тохиолдолд, тогтмол орлоготой, өсөлтийн өндөр боломжтой олон бизнесүүд санхүүжилтийн дутагдалд орж, хөгжлийн боломжоо бүрэн ашиглаж чаддаггүй байна.

Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Япон, Өмнөд Солонгос зэрэг улсууд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан зээлийн баталгаат фондын системийг амжилттай хэрэгжүүлжээ. Тус систем нь банкуудад олгож буй зээлийн эрсдэлийн 50–80 хувийг төрийн баталгаа гаргах замаар зээлдэгчийн барьцааны шаардлагыг зөөлрүүлж, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлдэг (Korea Credit Guarantee Fund, 2022).¹³

Японд хэрэгжиж буй ЖДҮ-ийн баталгаат корпорац (Credit Guarantee Corporation, CGC) нь зөвхөн баталгаа гаргахаас гадна ЖДҮ-ийн санхүүгийн эрүүл мэнд, бизнесийн загварыг орчин үеийн үнэлгээний аргачлалаар дүгнэдэг. Тэд компанийн ирээдүйн боломжийг мөнгөн урсгалын тогтвортой байдал, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, удирдлагын туршлага, бизнесийн загварын оновчтой байдал зэрэг үзүүлэлтээр цогцоор нь үнэлж, инноваци, технологи, экспортын чиглэлээр Засгийн газраас дэмжиж буй тусгай хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан ажилладаг (SME, Japan, 2023).¹⁴

Эцсийн дүндээ зээлийн баталгаа олгох шийдвэр нь зөвхөн тоон санхүүгийн үзүүлэлт бус, компанийн өмнөх зээлийн түүх, төлбөрийн сахилга бат, удирдлагын чадавх зэрэг чанарын хүчин зүйлсэд үндэслэдэг. Ингэснээр санхүүгийн байгууллагын эрсдэлийг мэдэгдэхүйц бууруулж, барьцаа хөрөнгөгүй ч бодитой бизнес санаа, тогтвортой орлоготой аж ахуйн нэгжүүдийг санхүүжилтэд хамруулах боломжийг нээдэг.

Ийм төрлийн тогтолцоо нь эдийн засгийн өсөлт, ажлын байр нэмэгдүүлэх, инновац дэмжих зэрэг ЖДҮ-ийн үндсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд чухал түлхэц болдог. Гэвч ийм системийг нутагшуулахад хууль эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийн эх үүсвэрийн нэгтгэл, байгууллагын бүтэц зэрэг олон хүчин зүйлс шаардлагатай бөгөөд харьцангуй урт хугацаа зарцуулдаг. Иймд, богино хугацаанд банкууд өөрсдийн зээлийн бодлогыг шинэчилж, өр төлбөрийн эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, бараа материал, авлага зэрэг хөрөнгийг барьцаалах боломжийг өргөжүүлэх нь зүйтэй. Харин урт хугацаанд Төв банк болон Засгийн газраас дансны эргэлт, зээлийн түүх зэрэг өгөгдөлд суурилсан ЖДҮ-ийн зээлийн үнэлгээний тогтолцоо, түүнчлэн

¹³ KODIT Annual report, 2022

¹⁴ Credit guarantee system, SME, Japan, 2023

банкуудад эрсдэлийн тодорхой хувийг даах хэсэгчилсэн баталгааны хөтөлбөрийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь хамгийн үр дүнтэй шийдэл болно.

Стратеги

- Хувийн хэвшлийнхний санхүүжилтийн хэрэгцээ, үйл ажиллагааны онцлогийг судлан, санхүүгийн байгууллагуудын тавьж буй нөхцөлтэй уялдуулах замаар зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Бизнесийн орчныг дэмжих, санхүүгийн зуучлалыг төрөлжүүлэх, шинэ шийдэл нэвтрүүлэх чиглэлээр төр-хувийн хэвшил-олон улсын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдааг хангах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Банкны зээл олголтын шалгуур, нөхцөлийн нэгдсэн үнэлгээ хийх мэдээллийг цуглуулах, харьцуулсан судалгааг хийнэ.
- Бизнесийн байгууллагуудын санхүүгийн нөхцөл байдал, санхүүжилтийн хэрэгцээг нарийвчлан судалж, тодорхойлно.
- Зээлийн барьцаа хөрөнгийн төрөл, үнэлгээний аргачлалыг өргөжүүлж, бизнесийн онцлогт нийцсэн уян хатан нөхцөл бүхий бүтээгдэхүүн хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
- Бизнесийн орчныг сайжруулах чиглэлд олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2025 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 34 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ


(2025 оны 2 дугаар улирлын байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОЛОН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:


1.1. Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг дунд хугацаанд 5 хувь (+/-2 нэгж хувийн интервалтай)-ийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэ бодлогыг хэрэгжүүлэхдээ инфляцын зорилтыг 2027 оноос 5 хувь болгон бууруулна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц сүүлийн 4 сар дараалан буурч 2025 оны II улиралд 8.4 хувь¹⁵ хүрлээ. Ийнхүү өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар багасаж, зорилтын дээд интервалд дөхөөд байна. Сүүлийн саруудад инфляцын түвшин саарахад мөнгө, санхүүгийн бодлого хатуурсан, хаврын саруудад цаг агаарын хүндрэл бага байж махны үнэ харьцангуй тогтвортой байсан нь нөлөөллөө.

Зураг 18. Улс болон УБ хотын инфляц



Зураг 19. Улсын жилийн инфляц (бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Сүүлийн байдлаарх инфляцын түвшинг авч үзвэл 2025 оны 6 дугаар сард 8.2 хувьтай байна. Үүнд, голлон нөлөөлсөн буй хүчин зүйлсийг дэлгэрүүлэн тайлбарлая:

¹⁵ Улирлын дундаж инфляц

- Дотоодын мах, махан бүтээгдэхүүний инфляц саарч, тайлант сард жилийн 8.7 хувь болов. Үүнд өмнөх оны хаврын саруудад зудтай холбоотойгоор махны үнэ өндөр өссөн суурь үе голлон нөлөөлсөн байна.
- Хүнсний бус импортын барааны үнийн жилийн өсөлт өмнөх улирлаас 1.4 нэгж хувиар саарч, нийт инфляцын 2.1 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Энэ нь суудлын тэрэгний үнэ сүүлийн 3 сард нийтдээ 6.6 хувиар хямдарсан болон бусад импортын барааны үнэ харьцангуй тогтвортой байгаатай холбоотой юм.
- Шатахууны инфляцад эзлэх хувь өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар нэмэгдлээ. Тайлант сард дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ унасны улмаас дизель түлшний үнэ 200 төгрөгөөр хямдарсан байна. Эсрэгээрээ өрхүүдийн өргөн хэрэглээний шатахуун болох АИ-92 бензиний үнэ 200 төгрөгөөр нэмэгджээ.
- Үйлчилгээний бүлгийн жилийн үнийн өсөлт өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар нэмэгдэж 12.7 хувьд хүрэв. Үүнд, орон сууцны түрээс, нийтийн хоолны үйлчилгээний үнэ өссөн нь голлон нөлөөллөө. Тухайлбал, жилийн дүнгээр орон сууцны түрээс 47.0 хувиар өсөөд байна.

Хүснэгт 1. Инфляцад хамгийн өндөр нөлөөтэй 20 бүтээгдэхүүн, 2025 оны 6 дугаар сар¹⁶

	Бүлэг	Бүтээгдэхүүн	Жилийн өсөлт	Инфляцад үзүүлэх нөлөө	Инфляцад эзлэх хувь
1	Зохицуулалттай	Өрхийн цахилгааны төлбөр, 1 кВтг. /150 квт.ц-аас 300 квт.ц хүртэлх/	97.9%	0.7%	38.0%
2	Зохицуулалттай	Өрхийн цахилгааны төлбөр, 1 кВтг. /150 квт.ц хүртэлх /	57.7%	0.5%	
3	Зохицуулалттай	Автобусны билет, том хүн	100.0%	0.3%	
4	Зохицуулалттай	Улсын их, дээд сургуулийн сургалтын төлбөр, 1-р дамжаа	12.7%	0.3%	
5	Зохицуулалттай	Бензин, А-92, 1 литр	7.3%	0.3%	
6	Үйлчилгээ	Хувийн бага сургуулийн сургалтын төлбөр, 1 жил	28.2%	0.2%	
7	Үйлчилгээ	Хувийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр, 1-р дамжаа	21.4%	0.2%	
8	Дотоодын хүнс	Хонины мах, ястай, 1 кг	4.5%	0.2%	
9	Үйлчилгээ	Хувийн дунд сургуулийн сургалтын төлбөр, 1 жил	26.0%	0.2%	
10	Дотоодын хүнс	Үхрийн мах, ястай, 1 кг	12.4%	0.2%	
11	Импортын бараа	Суудлын жижиг тэрэг, "Toyota Prius 41", 2015 онд үйлдвэрлэсэн	2.9%	0.2%	16.5%
12	Дотоодын хүнс	Үхрийн мах, гуяны цул, 1 кг	11.7%	0.2%	
13	Үйлчилгээ	Орон сууцны түрээслэх үнэ, 2 өрөө байр, тавилгагүй	51.6%	0.2%	
14	Үйлчилгээ	Сууц төлбөрлөгчийн төлсөн бодит түрээс, 1 өрөө байр, тавилгагүй	49.9%	0.2%	
15	Импортын бараа	Эрэгтэй хүний пүүз, хэмжээ 39-43, Хятад	13.3%	0.1%	
16	Үйлчилгээ	Сууц төлбөрлөгчийн төлсөн бодит түрээс, 1 өрөө байр, тавилгатай	51.0%	0.1%	
17	Импортын бараа	Үсний шампунь, савтай, "Pantene", 400 мл, энгийн	12.1%	0.1%	
18	Үйлчилгээ	Эмэгтэй үс засуулах төлбөр, энгийн тайралт	16.5%	0.1%	
19	Импортын бараа	Эмэгтэй өвлийн гутал, хэмжээ 36-39, Хятад	13.5%	0.1%	
20	Импортын бараа	Эрэгтэй өвлийн гутал, хэмжээ 39-43, Хятад	13.1%	0.1%	
ДЭЭРХ 20 БҮТЭЭГДЭХҮҮН		Хүнс /3 бүтээгдэхүүн/		0.6%	54.5%
		Хүнс бус /17 бүтээгдэхүүн/		3.9%	
		БУСАД 409 БҮТЭЭГДЭХҮҮН		3.7%	45.5%
НИЙТ ИНФЛЯЦ				8.2%	

Эх сурвалж: УСХ

¹⁶ Мах, гурил, сүү, хүнсний ногоотой холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг улаан өнгөөр тэмдэглэв.

Мөнгөний бодлогын шийдвэр

- Монголбанкны МБХ-ны 2 дугаар улирлын ээлжит хурал 2025 оны 6 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хуралдаж, бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргав. Жилийн инфляц алгуур саарч, 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувь, Улаанбаатар хотод 9.4 хувьтай гарлаа. Үүнд, мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон импортын барааны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Хэдийгээр инфляцын төсөөлөл өмнөхөөс буурч, хүлээлтээс эрт саарах хандлага ажиглагдаж эхэлсэн ч нийтийн тээвэр, цахилгаан зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөгөөр инфляц энэ оны туршид Төв банкны зорилтоос өндөр байх хүлээлттэй байна. Түүнчлэн дэлхийн зах зээлд нүүрсний үнэ үргэлжлэн буурч, гадаад орчны эмзэг байдал өндөр байгаа энэ үед томоохон төслүүд дотоодоос санхүүжих тохиолдолд төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханшид ирэх дарамт нэмэгдэж, инфляц хүлээлтээс эрчимжих эрсдэлтэй. Ийнхүү МБХ гадаад, дотоод орчны нөхцөл байдал, эрсдэл, инфляцын цаашдын төлөвийг харгалзан бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэлээ. Энэхүү бодлогын шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгтой нийцтэй болно.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

Экспортын орлого 2025 оны нэгдүгээр улиралд буурсан өөрчлөлтийн нөлөөгөөр төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2025 оны 4 дүгээр сарын байдлаар оны эхнээс 4.4 хувиар сулрав. Харин сүүлийн саруудад нүүрсний болон зэсийн экспортын орлого нэмэгдсэнээс гадна санхүүгийн дансны орох урсгал өссөнөөр ханш өдөрт дунджаар 0.01 хувиар хэлбэлзэж, харьцангуй тогтвортой байв. Үүнд уул уурхайн экспортын бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт голлох нөлөөтэй юм. Тухайлбал, нүүрсний үнэ 2025 оны эхний хагаст 18 хувиар унаад байсан бол гуравдугаар улиралд сэргэх хандлага бий боллоо. 2025 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн байдлаар нүүрсний үнэ экспортын үнэ 97 ам.долларт хүрч өсөөд байна. Түүнчлэн, 9 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар олон улсын зах зээл дэх зэсийн үнэ оны эхнээс 13.1 хувиар, Монгол Улсын зэсийн экспортын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 38.0 хувиар тус тус өсжээ. Экспорт идэвхжиж буй эерэг өөрчлөлт нь гадаад валютын нөөц, валютын захын нийлүүлэлтэд эерэгээр нөлөөлнө.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүгээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцдог. Банкуудаас гадаад валютын дуудлага худалдаанд 2025 оны эхний 4 сард долоо хоногт дунджаар 217.3 сая ам.доллар худалдан авах санал ирж байсан бол уг хэмжээ 5 дугаар сараас 9 дүгээр сарын 9-ний өдрийн хооронд 187.3 сая ам.доллар болж, 30.0 сая ам.доллороор буурчээ. Монголбанк 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар нийт 68 удаагийн гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, 4,845.6 сая ам.доллар нийлүүлсэн бол тайлант хугацаанд нийт 2,627.7

сая ам.долларыг худалдан авч (Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 тоот хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс гадаад валют худалдан авч байна), цэвэр дүнгээр 2,164.9 сая ам.долларыг гадаад валютын дотоодын захад нийлүүлээ.

Ийнхүү макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон дотоодын зах зээл дэх улирлын онцлог зэргээс шалтгаалан төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3593.68 төгрөг (9 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар)-т хүрч, оны эхнээс 5.06 хувиар, 2 дугаар улирлын эцсээс 0.36 хувиар тус тус сулрав.

1.3. Макро зохистой бодлогын шийдвэр гаргалтын болон үйл ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Монголбанк нь санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг гүйцэтгэхэд өмнө ашиглаж байсан арга, техникүүдийг сайжруулан шинжлэхийн зэрэгцээ шинэ төрлийн арга хэрэгслүүд ашиглаж байна. Тухайлбал, зээлийн мэдээллийн сан болон өрхийн секторын микро тоон мэдээллийг ашиглан шинжилгээ хийж, банкны системийн эрсдэлийг тодорхойлох болон макро зохистой бодлогын санал боловсруулахад ашиглаж байна. Түүнчлэн, олон улсад макро зохистой бодлогын гол хэрэгслээр ашигладаг мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөцийн хэрэгслийг Монгол Улсын банкны салбарт нэвтрүүлэх боломжийн талаарх суурь судалгааг Өмнөд Данийн их сургуулийн профессорын зөвлөгөөнд тулгуурлан хийж гүйцэтгэв.

Макро зохистой бодлогын үйл ажиллагааны тогтолцоог олон улсын сайн туршлагад нийцүүлэн бэхжүүлэх, сайжруулах хүрээнд тус бодлогын үйл ажиллагааг дэмжих “Макро зохистой бодлогын үйл ажиллагааны систем”-ийг Олон улсын валютын сангийн зөвлөхтэй хамтран хөгжүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлэх туршилтыг хийж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Макро эрсдэлт хүчин зүйлсийн модуль, Банкны ашиг, алдагдлын модуль, Дефолт тархалтын модуль, Санхүүжилтийн эх үүсвэрийн халдварын модуль, Олон үет модуль, Системийн эрсдэлийг хэмжих модуль гэсэн 6 модулиудаас бүрдсэн системийн эрсдэлийн үнэлгээний цогц загварыг хөгжүүлж байна. Энэхүү цогц загвар нь макро зохистой бодлогын үйл ажиллагааны тогтолцооны үндсэн чухал хэсэг болох юм. Загварын хөгжүүлэлтийг эцэслэж, загварын үр дүнг макро зохистой бодлогын шинжилгээ, системийн эрсдэлийн үнэлгээнд ашиглаж эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Санхүүгийн салбарт системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор Монголбанкнаас бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Тодруулбал, Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлын шийдвэрээр банкны салбарын хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс үүдэлтэй эмзэг байдлыг бууруулах, эдийн засгийн сөрөг шокийн үед санхүүгийн системд үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор банкнаас

иргэдэд шинээр олгох болон нөхцөл өөрчлөх хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 55 хувиас 50 хувь болгон бууруулж, 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс мөрдөж эхлэв.

Түүнчлэн тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, тэтгэврийн зээлдэгчдийн санхүүгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, нийгмийн баталгааг хангах хүрээнд Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны санал, хүсэлтийг харгалзан МБХ-ны 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдаанаар банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэх орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доошгүй байх зохицуулалтыг мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Харин МБХ-ны 2025 оны 2 дугаар улирлын ээлжит хурлаар тэтгэврийн зээлийн дээрх зохицуулалтыг сулруулж, тэтгэврийн зээлийг бусад хэрэглээний зээлтэй адил зохицуулалттай байхаар буюу “Банкнаас шинээр олгох тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлд болон тус шинээр олгосон тэтгэврийн зээлийн нөхцөлийг нь өөрчлөхөд өр, орлогын харьцааг 50 хувиас хэтрүүлэхгүй байх”-аар шийдвэрлэв. Тодруулбал, тус шийдвэр нь зөвхөн 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс хойш тэтгэвэр, тэтгэмжийн орлогоо барьцаалан шинээр зээл авч байгаа зээлдэгчдэд хамаатай бөгөөд тус өдрөөс өмнө зээл авсан, зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдэд хамаарахгүй болно.

Гэвч зээл авах боломжийг нь хязгаарлаж, хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байгаа талаар зарим иргэдээс ирүүлсэн гомдол, Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын байнгын хороо, УИХ-ын гишүүдээс Монголбанканд ирүүлсэн хүсэлтийг харгалзан үзэж, Монголбанкны МБХ-ны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар банкнаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд гаргасан 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн, 6 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрийг хүчингүй болгож, хуучин нөхцөлд нь хэвээр үлдээлээ. Ингэснээр тэтгэврийн зээлтэй иргэд өрийн дарамтаа зохистой түвшинд хязгаарлаж, хэт өндөр зээлийн дарамтаас үүдэлтэйгээр нийгэм, эдийн засгийн баталгаа алдагдах эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах нь чухал болж байна. Цаашид тэтгэвэр, тэтгэмж, халамжийн орлого барьцаалсан зээл, түүнээс шалтгаалсан өндөр настай иргэдийн амьжиргааны доройтол зэрэг асуудлыг салбарын яамны зүгээс анхааралдаа авах нь зүйтэй.

Банк нь банк, банкны нэгдлийн бусад оролцогч, банкны харилцан хамаарал бүхий хуулийн этгээдээр дамжуулан банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-д зээл олгох, ББСБ-аас гаргасан үнэт цаас, активыг худалдан авах замаар санхүүжилт олгож байгаа нь нэг талаас хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хүргэж сааруулах макро зохистой бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, нөгөө талаас банк болон ББСБ-ын салбарын харилцан хамаарлын эрсдэл нэмэгдэж, макро-санхүүгийн сөрөг шокийн үед салбар хооронд эрсдэл халдварлах, банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Нөгөөтэйгүүр, зөвхөн ББСБ-д олгох санхүүжилтийг хязгаарлах тохиолдолд бусад санхүүгийн байгууллага (ХЗХ, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд)-аар дамжин бодлогын арга хэмжээний нөлөөлөл сулрах эрсдэлтэй юм. Иймд банк болон банкны бус санхүүгийн салбарын харилцан хамаарлын эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга

хэмжээний хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн “Банкин дахь банкны бус санхүүгийн байгууллагын харилцан хамаарлын эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” тушаалыг батлуулж, арилжааны банк тус бүрд хүргүүлсэн болно. Энэхүү тушаалын дагуу арилжааны банкнаас ББСБ, ХЗХ, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг этгээдэд зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт олгохгүй, тэдгээрээс аливаа актив хөрөнгө худалдан авахгүй байх, олгосон байгаа санхүүжилтийн хугацааг сунгахгүйгээр эргүүлэн төлүүлэх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэв.

Монголбанкнаас банкны хэрэглээний зээлийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2025 оны 3 дугаар сард шийдвэр гарган ББСБ-ын хэрэглээний зээлийн зохицуулалтаа чангаруулаад байна. СЗХ-ны тус шийдвэр нь зөвхөн ББСБ-аас олгох хэрэглээний зээлд мөрдөгдөж байгаа учир зохицуулалтад хамаарахгүй бусад хэсэг буюу ХЗХ, лизингийн компаниудаас олгох хэрэглээний зээлийн хэмжээ нэмэгдэх зэргээр бодлогын нөлөөлөл сулрах эрсдэлтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.


2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

2.1. Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлнэ.

Монголбанк сүүлийн хоёр жилд гадаадын банк санхүүгийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын санхүүгийн салбарт нэвтрэх, хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай бодлого, зохицуулалтын механизмыг бий болгоход анхаарч ажиллалаа. Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд гадаадын банк, санхүүгийн байгууллага нь банкны хувьцааг 20 хувь хүртэл эзэмших, банкны салбараа дотоодод байгуулах, охин компани хэлбэрээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсантай холбогдуулан Монголбанкнаас холбогдох журмыг батлан хэрэгжүүлж байна. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дах хэсэгт “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах болон өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл, шаардлагыг Монголбанк, СЗХ хамтран тогтооно” гэж заасны дагуу “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах болон өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл шаардлагыг тогтоох журам”-ын төслийг боловсруулан, Монголбанкны Ерөнхийлөгч болон СЗХ-ны даргын 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А-88/123 тоот хамтарсан тушаалаар баталлаа.

Зураг 20. Банкны салбарт хөрөнгө оруулах боломжууд



Монгол Улсын "Алсын хараа 2050" баримт бичигт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, хүртээмжтэй санхүүгийн системийн зорилтуудыг тодорхойлсон. Энэ хүрээнд 2021-2030 онд технологийн дэвшил, хиймэл оюун ухааныг ашиглан санхүүгийн олон төрлийн үйлчилгээг хөгжүүлэх, гадаадын банкны салбарын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, Монголбанк банкуудад хяналт тавих зохицуулалтыг нарийвчлан төрөлжүүлэх, санхүүгийн салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлага тулгарч байна.

Иймд банкны салбарын хөгжлийн 2025-2028 оны дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд энэхүү дунд хугацааны хөтөлбөрт банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийн зардал багатай, өндөр технологид суурилсан, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээний орчин бий болгох зорилтыг тусгаад байна. Уг зорилтын хүрээнд Монголбанкнаас гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой бэрхшээл, хөрөнгө оруулалтыг татах орчныг үнэлэх судалгаа, шинжилгээ хийх, түүнээс гарсан үр дүн, дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль, эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтийг хийх ажлуудыг тусгасан.

2.2. Банкнуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлнэ.

Монголбанкнаас банкнуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга

хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд олон улсын хяналт шалгалтын Базел стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлал, хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг банкнуудын болон банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд туршилтын байдлаар нэвтрүүлж, манай улсын банкны системийн онцлогт тааруулан нутагшуулах ажлыг гүйцэтгэж ирлээ. Базел стандартын Бүлэг 2-ын хэрэгжилт нь банкны өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын хүрэлцээний үзүүлэлтүүдэд материаллаг байдлаар шууд нөлөөлөл үзүүлэх тул энэхүү олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу 2025 онд туршилтын байдлаар үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд 2025 оны 2 дугаар улиралд банкнууд 2024 оны эцсийн байдлаар бэлтгэсэн ICAAP, ILAAP-н туршилтын тайланг холбогдох журмын төслийн дагуу бэлтгэн Монголбанканд ирүүлсэн. Тайлангуудын хяналт шалгалтын үнэлгээ (SREP)-г гүйцэтгэх ажлыг Монголбанк эхлүүлээд байна.

“Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP, ILAAP)-ын журам”-ын төслийг 2025 оны 2 дугаар улиралд Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтэд танилцуулах сонсох ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Тодруулбал, тус журмын төслийг Монголбанкны цахим хуудаст заасан хугацааны турш байршуулж, ирсэн саналуудыг судалж тусган 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр банкнууд болон Монголын банкны холбооны төлөөлөлд танилцууллаа.

Олон улсын банк, банкны тогтолцоонд зохистой байдлаар хяналт шалгалт, зохицуулалт хийх суурь шаардлагыг тогтоодог Базелийн хорооноос баталсан зохистой засаглалын зарчимтай нийцүүлэн “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн боловсруулаад байна. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авахаар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Монголбанкны цахим хуудсанд байршуулсан. Монголын банкны холбооноос арилжааны банкнуудын нэгтгэсэн саналыг ирүүлсэн ба журмын төсөлд шаардлагатай саналыг тусган, эцэслэхээр ажиллаж байна.

2.3. Банкны салбарын тогтвортой, ногоон санхүүжилтийн мэдээлэл цуглуулах тогтолцоог бэхжүүлж, уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, стресс тестийн арга зүйг хөгжүүлнэ.

“Уур амьсгалын өөрчлөлт (УАӨ)-ийн эрсдэлийн шинжилгээ, стресс тест хийх аргачлал”-ийг боловсруулж, системийн ач холбогдол бүхий 5 банкныг оролцуулаад нийт 7 банкны тоон мэдээлэлд үндэслэн туршилтаар анх удаа уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ, стресс тестийг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Энэхүү шинжилгээг хийхдээ УАӨ-ийн биет болон шилжилтийн эрсдэлийн хувилбарыг тодорхойлж, ялгаатай хувилбар тус бүрд харгалзах макро үзүүлэлтийн тооцоолол, арга зүйг боловсруулав. Уур амьсгалын стресс тестийн аргазүй, холбогдох мэдээлэлд

үндэслэн банкнууд шаардлагатай тоон мэдээллийг боловсруулах, тооцоолох ажлыг 2025 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэлээ. Уур амьсгалын стресс тест хийхтэй холбоотойгоор банкнуудад үүсэж буй ойлголтын зөрүү, тооцооллын бэрхшээлийг шийдвэрлэх, банкнуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд холбогдох засвар, сайжруулалтыг хийх зорилгоор 2024 оны 10 дугаар сараас 2025 оны эхний хагас жилд 6 удаагийн сургалт, уулзалтуудыг зохион байгуулж ажиллав.

Уур амьсгалын стресс тестийн шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулах, оролцогч талуудад үр дүнг танилцуулах ажлыг 2025 оны 5 сард зохион байгуулсан. Түүнчлэн 2025 оны 7 сард НҮБ-ын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн түншлэл, Ази-Номхон далайн бүсийн Эдийн Засаг, Нийгмийн Комисс, Европын хөрөнгө оруулалтын банк, Францын хөгжлийн агентлагаас Тайланд улсад зохион байгуулсан “Төв банкныг ногооруулах: Харилцан суралцах, инновац, сургамжууд” сэдэвт олон улсын арга хэмжээнд уур амьсгалын стресс тестийн талаарх өөрийн орны туршлага, сорилт, сургамжийн тухай танилцуулж, туршлага хуваалцлаа.

Мөн Монголбанк нь Олон Улсын Санхүүгийн корпорац (ОУСК), СЗХ болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран “Монгол Улсад ногоон санхүүгийн захыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд банкны салбарын уур амьсгалын эрсдэлд өртөмтгий байдлын үнэлгээг гүйцэтгэж, үнэлгээний тайланг гаргалаа. Тус тайлангийн төслийг эцэслэсний дараа Монголбанкны цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэх болно.

Зураг 21. Банкнуудын ногоон зээл, 2025 оны 1 дүгээр улирлаар, тэрбум төгрөг¹⁷



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк нь Тогтвортой хөгжлийн зорилтын Санхүүжилтийн таксономийн тайлагналын загварыг боловсруулахаар Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС холбоо) болон банкнуудтай хамтран ажиллаж байна. Нийт санхүүгийн салбарын ногоон зээлийн мэдээг банкнууд, Хөгжлийн банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын тайланг нэгтгэн 2024 оны 3 дугаар улирлаас нийтэд мэдээлж эхэлсэн ба 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 18,862 зээлдэгчийн 2,110.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Банкуудын хувьд ногоон зээл

¹⁷ 1 улирлын хоцрогдолтой мэдээлэл цуглуулж боловсруулдаг.

өмнөх оны мөн үеэс 901.1 тэрбум төгрөг буюу 84.1 хувиар өсөж, 1,972.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 4.7 хувийг эзэлж байна. Үйл ажиллагааны салбараар нь задалбал, ногоон зээлийн дийлэнх буюу 63.3 хувь нь эрчим хүчний хэмнэлтийн салбарт, 17.5 хувь нь тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбарт, 7.0 хувь нь карбон бага тээвэрт олгогджээ.

2.4. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны техник хэрэгжилт, үр дүнтэй байдлын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэж, шууд хэрэгжилтийн үзүүлэлтийн дагуу өөрийгөө үнэлэх болон үндэсний, салбарын эрсдэлийн үнэлгээг эхлүүлнэ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) Үндэсний зөвлөлийн 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан хурлаар ФАТФ-ын Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу Монгол Улсын МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлын үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/75 дугаар тушаалаар МУТСТ тогтолцоог Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. Тус ажлын хэсэг нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийх чиг үүрэгтэй бөгөөд ажлын хэсгийг Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, СЗХ ахлан ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, хурлаар 2028 онд эхлэх дараагийн харилцан үнэлгээ, өмнөх харилцан үнэлгээнүүд, болон Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлт, түүнийг хэрхэн үнэлэх тухай мэдээллийг танилцуулав.

Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол, товч мэдээлэл, зохион байгуулалтын талаар хэлэлцэв. Мөн Дэлхийн банкны аргачлалын дагуу 11 Модулийн хүрээнд мөнгө угаах аюул занал, эмзэг байдал, салбаруудын эмзэг байдал, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, виртуал хөрөнгийн салбарын эрсдэлийг үнэлэх тул модуль тус бүрийг хариуцан ажиллах дэд ажлын хэсгүүдийг яаралтай байгуулах, дэд ажлын хэсэг тус бүрийн ажлын төлөвлөгөөг боловсруулах шийдвэрүүд гаргалаа. Мөн 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/171 дүгээр тушаалаар 35 байгууллагын 270 орчим албан хаагчдаас бүрдсэн 12 дэд ажлын хэсгийг байгууллаа.

Тайлант хугацаанд дэд ажлын хэсгүүд нийт 90 орчим уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, аргачлалын дагуу статистик мэдээллийн 85%-ийг цуглуулан, боловсруулах шатандаа байгаа бөгөөд үндэсний эрсдэлийн үнэлгээг 2025 оны 11 дүгээр сард эцэслэн, олон нийтэд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн, Хамтын ажиллагааны зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар Мөнгөн зээлийн үйл

ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг Модуль 6.1-ээс тусад нь Модуль 6.3 болгон хийх, ажлын хэсэгт ажиллах нэрсийг авах шийдвэр гаргалаа.

Монголбанкны Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ банкнууд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан, эрсдэлд суурилсан арга хэлбэрээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд банкнаас ирүүлсэн тайлан, мэдээнд үндэслэн банк бүрийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг үнэллээ.

Мөн холбогдох журмын дагуу мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтыг иж бүрэн хэлбэрээр хийж, илэрсэн зөрчил дутагдалд хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллалаа. Түүнчлэн, СЗХ-той хамтран 2 удаагийн газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

Монголбанкнаас МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх хяналт шалгалтын стандартыг таниулах, үр дүнтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд шинээр үүсэж байгаа эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, соён гэгээрүүлэх зорилго бүхий сургалтуудыг тухай бүр нь хийж ажиллаж байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Үндэсний төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн шинэ үйлчилгээг дэмжиж, цаг үедээ нийцсэн хяналт, зохицуулалтын уялдааг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс оролцогч болон операторын үйл ажиллагааны тайланд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдалд холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллалаж байна. Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээний зөвшөөрөлтэй 8 байгууллагаас ирүүлж буй цахим мөнгөний тайланд хяналт тавьсан бөгөөд тайлант хугацаанд цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд хууль, журмын заалтуудыг бүрэн хангаж ажиллав.

Тайлант хугацаанд 1 байгууллагад аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай олгосон бөгөөд 1 байгууллагын цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээг сунгах, 1 байгууллагын мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, 1 байгууллагын төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх, 1 байгууллагын цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ, 1 байгууллагын төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийн материалыг тус тус хянаж байна.

Үндэсний төлбөрийн F карт 2020 оноос EMV технологийн чип стандартад шилжсэн тул картын нууцлал аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд биет карт дээр карт

эзэмшигчийн мэдээллийг хэвлэх шаардлагагүй болов. Үндэсний төлбөрийн ₮ картын загварт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүсэж, карт гаргагч бүх байгууллагуудтай холбогдон санал авч, судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнгийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн тушаалаар “Үндэсний төлбөрийн ₮ картын загвар, лого, холограм”-ыг шинэчлэн батлаад байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн тушаалаар Автомат клиринг хаус системээр дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг 5 сая төгрөг болгон тогтоосон бөгөөд тайлант хугацаанд энэ хязгаарыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийв. Судалгааг Банксүлжээ (RTGS) системээр дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн доод хязгаарыг 10 сая төгрөгөөс хэтрэхгүйгээр тогтоосон тохиолдолд системд ачаалал, эрсдэл үүсэх эсэх, тус системийн ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлөх зэрэг хүчин зүйлсийг чухалчилж үзсэн. Мөнгөн дүнгийн хязгаар нэмэгдүүлснээр дараах давуу тал бий болно:

- Их дүнтэй гүйлгээ дамжуулах эрсдэл буурах: RTGS системээр дамжих гүйлгээний ачаалал багасаж, тасралтгүй найдвартай байдал нэмэгдэнэ.
- Томоохон бизнесүүдийн мөнгөн урсгал сайжрах: бизнесийн хөрвөх чадвар сайжирснаар зах зээлд хөрөнгө оруулалт, санхүүгийн эргэлт түргэснэ.
- Эдийн засгийн өгөөж нэмэгдэх: RTGS системийн төвлөрсөн бүтэц нь их дүнтэй гүйлгээг илүү аюулгүй, эрсдэлгүй байдлыг бий болгосноор ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлнө.

Дээрх судалгаанд үндэслэн иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжих зорилгоор АСН системээр бодит цагийн горимоор дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг 10 сая төгрөг болгох саналыг төлбөрийн системийн нийт оролцогчдод албан бичгийг хүргүүлж, холбогдох саналыг нэгтгэв.

Монголбанк нь үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгын хүрээнд "Төлбөрийн системийн журам"-д 2024 онд нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Төлбөрийн системд хийгддэг хяналт шалгалт болон оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн тулгарч буй асуудал, түүнийг хууль зүй, зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх зорилгоор журмын заалт тус бүрээр нэг бүрчлэн хэлэлцэж шинэчлэн батлахаар ажиллаж байна.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгын хүрээнд үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж хуулийн хэрэгжилтийг үр нөлөөг үнэлэх ажлыг гүйцэтгэж, хуулийн бүлэг, заалт тус бүр дээр судалгаа хийж байна.

Мөн зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсронгуй болгох зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 2-р сарын 03-ны өдрийн тушаалаар ажлын хэсэг шинэчлэн байгуулсан. Энэхүү ажлын хэсэгт байгууллагуудын төлөөлөл бүхий 26 хүн багтаж 2 удаагийн хурал хийгээд байгаа бөгөөд Монголын банкнуудын холбоо болон бусад холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг

харгалзан үзэж, зээлийн мэдээллийн зохицуулалтыг илүү оновчтой, үр дүнтэй болгох чиглэлээр ажиллах үүрэгтэй юм. Хуулийн төслийг дахин сайжруулан ажлын хэсгийн нийт гишүүдэд санал авахаар хүргүүлж СЗХ, Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч 2 байгууллага болон Монголбанкны чиг үүргийн газруудаас хуулийн төсөлд нийт 231 санал ирүүлснийг тусгаж хуулийн төслийн саналыг боловсруулж байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн төсөлд Зээлийн мэдээллийн албанаас хүргүүлэх саналыг эцсийн байдлаар боловсруулан, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.

Ажлын хэсэг 2025 оны 2-р улиралд багтаан Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, танилцуулах зорилготой байсан боловч ажлын хэсгийн гишүүдээс хуулийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэхэд хугацаа их орсон тул энэ оны 3 дугаар улиралд багтаан Монголбанкны удирдлагад танилцуулав. Цаашид ажлын хэсэг хуулийн төслийн заалт тус бүрийг нарийвчлан хэлэлцэж, төслийн анхны албан ёсны хувилбарыг боловсруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэхүү хувилбарыг олон нийт, холбогдох байгууллагуудад танилцуулахаар ажиллаж байна.

3.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийх суурь нөхцөлийг бүрдүүлэн мөнгөний захыг хөгжүүлнэ.

Мөнгөний захыг хөгжүүлэх хүрээнд Монголбанкнаас арилжааны хэрэгслүүд, дэд бүтэц, зах зээлийн мэдээлэл авах боломжийг хөгжүүлэх гэсэн 3 бүлэг ажлыг 2025 оны туршид хийж байна.

Мөнгөний зах дахь хэрэгслүүдийг хөгжүүлэх чиглэлд Монголбанк, Сангийн яамтай хамтран төгрөгийн жишиг хүү буюу өгөөжийн муруйг бий болгохоор ажиллаж байна. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) нь ихэвчлэн өгөөжийн муруйн богино хугацааны хэсгийг, харин Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) нь өгөөжийн муруйн урт хугацааны хэсгийг бүрдүүлдэг тул ТБҮЦ болон ЗГҮЦ-ны арилжаа нь мөнгөний захын хөгжилд чухал ач холбогдолтой байна. Тус зорилгоор Монголбанкнаас Сангийн яамтай ЗГҮЦ-ыг дотоод зах зээлд дахин арилжаалж эхлэхэд шаардлагатай дэд бүтцийн талаар санал солилцож, тухай бүр шаардлагатай мэдээллийг хүргүүлсэн бөгөөд Засгийн газар 2025 оны 2 дугаар улиралд ЗГҮЦ-ны анхдагч захын арилжааг хөрөнгийн биржээр дамжуулан 2 долоо хоног тутам арилжаалж эхэлснээр төгрөгийн эрсдэлгүй үнэт цаасны өгөөжийн муруй бий болох боломж үүсэж эхлээд байна.

Цаашид ЗГҮЦ-ны арилжаа тогтмолжиж, хангалттай тоон мэдээлэл бүрдэн арилжааны идэвх нэмэгдэх хэрээр төгрөгийн өгөөжийн муруй бий болох боломж бүрдэнэ. Мөн мөнгөний захын нэг чухал хэрэгсэл болох банкнаас гаргах хадгаламжийн сертификатын арилжааг хөгжүүлэх зорилгоор Монголбанкнаас Банкны хадгаламжийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг тогтоох журмын төсөлд хадгаламжийн сертификат, түүнийг арилжаалах үйл ажиллагааны зохицуулалтыг тусган олон нийтээс санал авч байна.

Мөн арилжааны дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд банк хоорондын цахим арилжааны системд “MMTS Board” цэсийг нэвтрүүлээ. MMTS Boards буюу хоёрдогч захын

арилжааны талбар нь арилжааны банкнуудын хоорондох мөнгөний захын арилжааг ил тод, үр ашигтай байдлаар зохион байгуулах цэс юм. Энэхүү цэс нь банк хоорондын захад оролцогчдын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, арилжааны хэлцэл хийх үйл явцыг хөнгөвчлөх, нэгдсэн мэдээллээр хангах зорилготой.

Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах үүднээс Монголбанкны статистик мэдээлэл тархах веб хуудсанд “мөнгөний зах” гэсэн шинэ цэсийг үүсгэсэн бөгөөд энэхүү цэсээр дамжуулан Мөнгөний зах зээлийн улирлын тойм, сар бүрийн мөнгөний захын тайлан, мөнгөний захын хэрэгслүүдийн статистик мэдээллийг тогтмол олон нийтэд хүргэж байна.

Цаашид 2025 оны 4 дүгээр улиралд Монгол Улсын мөнгөний зах зээлийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн, хязгаарлаж буй гол асуудлуудыг тодорхойлох, олон улсын жишгийн дагуу хөгжлийн боломж, тус зах зээлийг үе шаттай хөгжүүлэх бодлогын санал, шийдлүүдийг боловсруулан батлуулахаар холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлгийг хийж байна. Үүний үр дүнд мөнгөний захыг хөгжүүлэх замын зургийг 2026 оны 1 дүгээр хагаст боловсруулан батлуулах юм.

3.3. Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлж, Төв Банкны бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллана.

3.3.1 Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлэх

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги” болон “Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Энэ хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд:

“Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хүрээнд:

- УИХ-ын даргын санаачилгаар Монголбанк, СЗХ, Хадгаламжийн даатгалын корпорац (ХДК), Боловсролын ерөнхий газартай хамтран ахлах ангийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох “Level-Up” хөтөлбөрийг 2025 онд 2 улирлын хугацаанд хэрэгжүүллээ. Хөтөлбөрт Улаанбаатар хотын 6 дүүргийн ерөнхий боловсролын 80 сургууль болон орон нутгаас Орхон, Булган, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймгийн нийт 149 багшийг бэлтгэж, 5,033 гаруй ахлах ангийн сурагчдыг амжилттай хамруулав. “Level-Up” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын дарга болон УИХ-ын гишүүдийн төлөөлөл, Монголбанк, СЗХ, ХДК, Боловсролын ерөнхий газар, Монголын банкны холбооны удирдлагууд оролцож, үг хэллээ. Арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл сурагчидтай хамтран “Санхүүгийн боловсрол – миний амьдралд” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, аймаг бүрээс 30 шилдэг сурагчийг шагнав.

- “Дэлхийн мөнгөний долоо хоног–2025” аяныг 13 дахь жилдээ Монгол Улсад амжилттай зохион байгууллаа. Аяны нээлтийн арга хэмжээг 2025 оны 3 дугаар сарын 22-нд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод, хаалтын үйл ажиллагааг 4 дүгээр сарын 14-нд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод тус тус хийв. Аяны хүрээнд УИХ-ын гишүүд, Монголбанкны удирдлагууд болон орон нутгийн төлөөлөл оролцсон бөгөөд нийт 300 орчим хүүхэд, залуус биечлэн оролцож, 193,800 хүүхэд, залуус болон 3.7 сая иргэнд мэдээлэл, мэдлэг түгээн ажиллалаа. л оролцсон бөгөөд нийт 300 орчим хүүхэд, залуус биечлэн оролцож, 193,800 хүүхэд, залуус болон 3.7 сая иргэнд мэдээлэл, мэдлэг түгээн ажиллалаа.
- Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ой энэ жил тохиож байгаатай холбогдуулан Монголбанкнаас ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд эсээ бичлэг болон 1-5 дугаар ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулж нийт 300 эсээ болон 86 зураг ирүүлснийг дүгнэн шалгаруулж батламж гардуулав.
- Иргэдийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Төрийн банктай хамтран сургагч багш бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 52 ажилтныг сургагч багшаар бэлтгэж, батламж гардууллаа.
- Монголбанк нь Монголын анхны цахим сургууль болох Medle-тэй хамтран ажиллаж байна. Өнгөрсөн онд ерөнхий боловсролын сургуулийн 10, 11, 12-р ангийн нийт 1173 сурагч “Бизнес судлал” хичээлийг сонгон судалсан бөгөөд тайлант хугацаанд уг хичээлийг заах багш нарыг ахисан түвшний агуулгаар чадавхжуулах зорилгоор нийслэл болон орон нутгийн 21 багшийг сургагч багшийн сургалтад хамруулав.

“Иргэдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд:

- Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жилийн ой, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн 100 жилийн ой, Үнэт цаасны хорооны 30 жилийн ойг тус тус тохиолдуулан “Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь бичиг”-ийг шинэчлэн боловсруулж, 2024 онд цахим хуудас (www.etoli.mn)-ыг ашиглалтад орууллаа. Уг тайлбар толийн хэвлэмэл хувилбарыг 2025 оны 1-р улиралд гаргаж, Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
- Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай хууль батлагдсанаар Монголбанкнаас энэ чиглэлээр Засгийн газар болон арилжааны банкнуудтай хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд мэдээлэл түгээх зорилгоор “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмж” товхимлыг 300 ширхэгийг хэвлүүлээ.
- Монголбанкнаас мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа хийдэг бөгөөд 2024 онд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд оролцсон тэргүүлэх бүтээлүүд болон судалгаануудыг

эмхэтгэн “Монголбанкны Судалгааны ажил” товхимол 300 ширхгийг, “Мөнгөний бодлогын тайлан” 300 ширхгийг хэвлүүлэн олон нийтэд түгээв.

- Төв банкны бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай санхүү, эдийн засгийн боловсрол олгох чиглэлээр хамтран ажиллаж, цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээлэл болон сэтгүүлчдэд чиглэсэн сургалт зохион байгуулав.
- Монголбанкны Ерөнхийлөгч МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн оюутнуудад “Мөнгөний бодлого” сэдвээр лекц уншлаа. Тус лекцэд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн 2-3 дугаар дамжааны 150 гаруй оюутан идэвхтэй хамрагдлаа.

3.3.2 Төв банкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх:

Төв банкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэж ажиллахдаа 2025 оны 2 дугаар улирлын байдлаар дараах сувгуудыг ашиглаж байна. Үүнд, хэвлэлийн хурал, ярилцлага, цаг үеийн мэдээ мэдээллийг цахим хуудаст байршуулах, олон нийтийн цахим сүлжээнд мэдээ, мэдээллийг түгээх, видео, фото, инфографик хэлбэрээр мэдээллийг хүргэх, чөлөөт уулзалт, хэлэлцүүлэг зэрэг болно. Тодруулбал:

Хэвлэлийн хурал: Тайлант улиралд 6 удаагийн хэвлэлийн хурал зохион байгуулж, ажиллалаа. Үүнд 2025.09.01-нд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан хэвлэлийн хурлыг зохион байгуулж, зээлийн мэдээллийн тухай хуулийн өөрчлөлт, зээлийн мэдээллийн онооны системд шилжиж буй талаар мэдээлэл өглөө. Мөн 2025.09.16-ны өдөр МБХ-ны ээлжит хурлыг зохион байгуулж, хэвлэл, мэдээллийнхнийг өргөн хүрээнд хамруулж, мэдээлэл өгөв. Хэвлэлийн хурлуудыг давхардсан тоогоор 30 гаруй хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөл сурвалжилж, олон нийтэд түгээлээ.

Ярилцлага: Он гарснаас хойш Монголбанкны газар, нэгжийн удирдлагууд нийт 28 удаа хэвлэл, мэдээллийн байгууллагад ярилцлага, мэдээлэл өгөв. Ярилцлагаар гадаад валютын албан нөөц, эдийн засгийн төлөв байдал, ипотекийн санхүүжилт, эдийн засгийн гадаад нөхцөл байдал, түүний нөлөөлөл, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл зэрэг сэдвийн хүрээнд олон нийтэд мэдээлэл хүргэв.

Цаг үеийн мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулах: Тайлант хугацаанд Монголбанкны цахим хуудаст нийт 24, оны эхнээс өссөн дүнгээр 92 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулав. Мөн статистик мэдээлэл, Монголбанкны судалгаа зэргийг хуваарийн дагуу цахим хуудаст байршуулж, олон нийтэд хүргэж байна.

Олон нийтийн цахим сүлжээнд мэдээ мэдээлэл түгээх: Монголбанкны албан ёсны цахим сүлжээ болох Facebook, Twitter, Instagram, Youtube сувгуудын хөгжүүлэлтийг тогтмол хийж ажиллахдаа 1) мэдээ мэдээллийн линкийг байршуулж, түгээх, 2) инфографик, постер бэлтгэж түгээх, 3) богино хэмжээний видео контент, рийл бэлтгэж түгээх, 4) шууд дамжуулалт гэсэн хэлбэрүүдийг ашиглаж байна.

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар Монголбанкны цахим сувгуудад нийтдээ 47 мэдээ, мэдээлэл нийтэллээ. Үүнд:

- Мэдээ мэдээллийн линк, фото: 17 удаа, оны эхнээс өссөн дүнгээр 78 удаа,
- Инфографик, постер: 24 удаа, оны эхнээс өссөн дүнгээр 60,
- Шууд дамжуулалт: 1 удаа, оны эхнээс өссөн дүнгээр 3 удаа,
- Видео контент, рийл: 5, оны эхнээс өссөн дүнгээр 53, үүнд Мөнгөний бодлогын тайлангийн танилцуулга – Цуврал -4, бусад 1 удаа тус тус нийтлэв.

Чөлөөт уулзалт, хэлэлцүүлэг: Монголбанкны бодлого, үйл ажиллагааны талаарх ойлголтыг сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн байгууллагуудад хүргэх, тайлбарлах зорилгоор сэтгүүлч, редакцуудтай чөлөөт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг бөгөөд тайлант улиралд цаг үеийн асуудлаар 1 удаагийн чөлөөт уулзалтыг (2025.08.23) зохион байгууллаа. Чөлөөт уулзалтад 25 хэвлэл, мэдээллийн байгууллагуудын төлөөлөл оролцов. Уулзалтын хүрээнд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл болон Монголбанкнаас баримталж буй бусад бодлого, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

Инфляцын хүлээлтийг удирдах: Инфляцын тайлангийн агуулгыг өргөжүүлэн 2025 оноос эхлэн “Мөнгөний бодлогын тайлан” хэлбэрээр гаргаж, Монголбанкны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээлээ. Тайлант хугацаанд “Мөнгөний бодлогын тайлан”-гийн 2025 оны I, II, III улирлын дугаарыг цахим хуудаснаа нийтэлж, мөн олон нийтийн сүлжээний цахим сувгуудаар түгээв. Ингэхдээ тайлангийн татаж авах линкийг хуваалцах, мөн тайлангийн голлох агуулгаар цуврал рийл (богино хэмжээний видео контент) 4 бэлтгэж, цахим сувгуудаар түгээв.

Тогтмол хэвлэгддэг тайлангуудаас гадна цаг үеийн шинжтэй макро эдийн засгийн судалгаа, статистик тоон мэдээллүүдийг Монголбанкны цахим хуудаст хуваарийн дагуу нийтэлж, олон нийтэд хүргэлээ.

Инфляцын хүлээлтийг удирдах, мөн Монголбанкны бодлого, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг олон нийтэд танилцуулах нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр зөвхөн мөнгөний бодлогын хүрээнээс гадна эдийн засгийн төлөв байдал, төсөв, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаар олон нийт, эрдэмтэн судлаачдыг хамруулан өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулсан нь онцлог байв.

Мөн хэлэлцүүлгийг төвийн 17 хэвлэл, мэдээллийн байгууллага сурвалжилж, ирэх оны инфляц, эдийн засгийн төлөв байдал, төсөв, мөнгөний бодлогын уялдаа зэрэг өргөн хүрээний сэдвээр мэдээллийг бэлтгэж, хүргэлээ. Хэлэлцүүлэгт Монголбанкны бодлогын газрын захирлууд оролцож, төв банкны бодлого, үйл ажиллагаа, мөнгөний бодлогын төлөв, эдийн засгийн байдал, эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал зэрэг өргөн хүрээний сэдвээр оролцогчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөлд мэдээлэл ярилцлага өгч ажиллав.

3.4. Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.

Тайлант онд иргэдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв төлөвшил бий болгох, хариуцлагатай санхүүгийн шийдвэр гаргах чадвар сайжруулах зорилгоор төрөл бүрийн сургалт, мэдээлэл түгээх арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ цахим контент, анимейшн зэргийг бүтээв. Тэдгээрээс дурдвал:

- Японы JICA-тай хамтран “Анар, Ану хоёр” анимейшний хоёр дугаарыг бүтээх ажлыг гүйцэтгэж, ажлын даалгавар, зохиолын санааг бичсэнээр гүйцэтгэгч байгууллагын сонгон шалгаруулалтыг хийв. Ингэхдээ хүүхдүүдийн худалдан авалт болон цахим хэрэглээг харгалзан үзэж санхүүгийн боловсролын хүрээнд "Анар, Ану хоёр дэлгүүр орсон нь", "Анар, Ану хоёр цахим мөнгөний талаар ярилцсан нь" сэдвээр анимейшн хийлгэж, цахим сувгуудаар түгээж ажиллав.
- Ерөнхий боловсролын Гэгээ дунд сургууль болон Хобби сургуулийн бага ангийн 150 гаруй сурагчдад хувь “Хуримтлал” сэдвээр сургалт орлоо.
- Цахим орчинд мэдээлэл түгээх ажлын дагуу www.sankhuugjinbolovsrol.mn хуудсанд баяжуулалт хийж, www.facebook.com/sankhuugjinbolovsrol пэйж хуудас, twitter.com/SankhBolovsrol твиттер хуудсанд тайлант хугацаанд нийт 48 мэдээ, постер байршуулав. Мөн “Анар Ану 2” цуврал богино хэмжээний видеоны ээлжит дугаарыг YouTube сувагт байршуулав.
- Монголбанканд иргэдээс ирсэн санал, хүсэлтэд тогтмол хариу өгч хамтран ажиллалаа.
- Олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор ЦЕГ-тай хамтран 100 албан хаагчдад “Хувь хүний санхүү” болон “Төв банкны үйл ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгууллаа.
- Сурагчдад санхүүгийн мэдлэг түгээх ажлын хүрээнд Level-Up хөтөлбөрийн зохион байгуулахдаа УИХ-ын Тамгын газар, арилжааны банкны санхүү эрхэлсэн захирлууд, Боловсролын яам, Татварын ерөнхий газрын төлөөллүүдтэй удаа дараа ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж ажилласан болно. Мөн хөтөлбөрийн хүрээнд заагдах модулийн ажлыг эхлүүлсэн болно.

3.5. Жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан-Алт” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас “Малын Гаралтай Түүхий Эдийг Боловсруулах Үйлдвэрлэлийг Дэмжих Санхүүжилт, Үйл Ажиллагааны Ерөнхий Зөвлөмж” баримт бичгийг боловсруулж, 2025 оны 3 дугаар сард УИХ, байнгын хороодод хүргүүлсний зэрэгцээ баримт бичгийг хэвлүүлэн, олон нийт, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлээ.

Түүнчлэн, тус хөтөлбөрийн хүрээнд ноолуурын салбарын нөхцөл байдал, санхүүжилтийн байдлыг тодруулах зорилгоор Монголбанкнаас 2025 оны 2 дугаар улиралд “Ноолуурын салбарын дэлгэрэнгүй түүвэр судалгаа”-г салбарын аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгууллаа. Тус судалгааны хүрээнд ноолуурын салбарын үйлдвэрлэлийн нөхцөл байдал, орлого, зардал, ААН-үүдийн санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, нэгтгэсэн тайланг удирдлага болон холбогдох газруудад хүргүүлээ.


Мөн нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, энэ төрлийн санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг стандартчилж, тэдгээрийг ашиглах хууль эрх зүйн орчин болон дэд бүтцийн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2019 оны А-155/134 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-294/340 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ын зохицуулалтуудыг судлан, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА


I. ИНФЛЯЦ

Гадаад орчны тодорхой бус байдал өндөр байгаагийн зэрэгцээ дотоод эдийн засагт гарч буй өөрчлөлтийн нөлөөгөөр инфляцын дарамт буурахгүй байна. Хэрэглээний үнээр хэмжигдэх инфляцын түвшин дотоод эрэлт, цалингийн өсөлтөөр дамжин 2024 оны дунд үеэс эхлэн эрчимжсэн. Үүний дээр боловсрол, цахилгаан, нийтийн тээвэр зэрэг зарим төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өөрчлөлт, тэдгээрийн дам нөлөөний улмаас инфляцын түвшин 2024 оны эцэст зорилтоос давав. Иймээс мөнгөний бодлогын төлөвийг шат дараатай хатууруул болон цаг агаарын хүндрэл 2025 онд бага байсантай холбоотойгоор инфляц эргэн саарах чиглэлд өөрчлөгдөж байна. Ийнхүү инфляц 2025 оны 6 дугаар сарын байдлаар 8.2 хувьд хүрч зорилтын дээд интервалд дөхөж буураад байна.

Зураг 22. Улс болон Улаанбаатар хотын инфляц



Зураг 23. Жилийн инфляцын¹⁸ задаргаа¹⁹



Эх сурвалж: УСХ, Монголбанк

2025 оны 6 дугаар сарын байдлаар инфляцын хөдөлгөөнд дараах хүчин зүйлс голлох нөлөө үзүүлээ.

- Инфляцын тал орчим хувь нь үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалж байна. Өмнөх оны 11 дүгээр сард өрх, ААНБ-ын цахилгааны үнэ нэмэгдсэн болон 2025 оны 2 дугаар сараас нийтийн тээврийн үнэ нэмэгдсэнээр инфляцын 1.9 нэгж

¹⁸ Инфляцыг мах, махан бүтээгдэхүүн, махнаас бусад хүнс, шатахуун, төрийн зохицуулалттай үйлчилгээ болон бусад гэсэн хэсгүүдэд хуваасан. Бусад хэсгийг дотор нь импортын бараа, бусад дотоодын бараа болон үйлчилгээ зэрэг бүлэгт хувааж тооцов.

¹⁹ Бусад дотоодын бараад хатуу түлшийг оруулж тооцов.

хувийг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ бүрдүүлэв. Түүнчлэн цахилгааны үнийн дам нөлөө, 2 жил үргэлжилсэн цалингийн эрчтэй өсөлт, үүнээс улбаатай эрэлт зэргээс шалтгаалан бусад үйлчилгээний үнийн өсөлт өндөр байлаа. Дэлгэрүүлбэл, боловсролын үйлчилгээ жилийн 18.2 хувийн, орон сууцны түрээс жилийн 47.0 хувийн, нийтийн хоолны үйлчилгээ жилийн 12.1 хувийн өсөлттэй байна.

- Төгрөгийн ханш суларсан нь инфляцыг нэмэгдүүлэх талаас нөлөөлж буй хэдий ч худалдааны голлох түнш БНХАУ-д үнийн өсөлт ажиглагдахгүй байгаа нь импортын барааны инфляц эрчимжихгүй байхад нөлөөлж байна. Хамгийн сүүлийн байдлаар нийт импортын барааны жилийн инфляц 5.0 хувьтай, инфляцын 2.4 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнээс 0.3 нэгж хувь нь хүнс, -0.1 нь шатахуун, 2.1 нэгж хувь нь хүнсний бус импортын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.
- Цаг агаарын хүндрэл бага байсан нь дотоодын хүнс, ялангуяа махны нийлүүлэлтийг харьцангуй тогтвортой байх хөшүүрэг болж хүнсний инфляц алгуур саарч байна. Тодруулбал, дотоодын хүнсний үнэ жилийн 5.9 хувиар өсөж, инфляцын 1.3 нэгж хувийг бүрдүүлжээ. Үүний 0.8 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн, 0.5 нэгж хувийг махнаас бусад хүнс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2. Инфляцын хөдөлгөөнд голлох нөлөө үзүүлсэн бүлгүүд (6-р сарын байдлаар)

Бүлэг	Жин	Жилийн инфляц	Жилийн инфляцад эзлэх хувь
Нийт импортын бараа, бүтээгдэхүүн	48.5	5.0%	2.4%
Хүнсний импортын бараа	7.1	4.6%	0.3%
Хүнсний бус импортын бараа	34.4	6.2%	2.1%
Шатахуун	7.0	-0.8%	-0.1%
Дотоодын хүнс	19.6	5.9%	1.2%
Үйлчилгээ	24.2	16.9%	4.1%
Төрийн зохицуулалттай	7.3	26.7%	1.9%
Бусад	16.9	12.7%	2.1%

Эх сурвалж: Монголбанк

II. БОДИТ СЕКТОР

2.1. Нийт нийлүүлэлт

Урьдчилсан гүйцэтгэлээр нийт үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд 5.6 хувиар²⁰ өслөө. Өвөл, хаврын саруудад цаг агаар таатай байж, хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар тэлж, нийт өсөлтийн 3.6 нэгж хувийг дангаараа бүрдүүлэв. Тодруулбал, өнгөрсөн оны эхний хагас жилд малын зүй бус хорогдол 8.1 сая толгойд хүрч, хөдөө аж ахуйн салбар огцом агшиж байсан бол энэ онд 190 мянга болж буурчээ. Мөн өнгөрсөн онтой харьцуулахад 5.4 саяар илүү буюу 20.8 сая төл бойжиж байна.


Аж үйлдвэр, барилгын салбар оны эхний хагаст жилийн 9.6 хувиар нэмэгдэж, өсөлтийн 1.0 нэгж хувийг бүрдүүлэв. Орон сууц, эмнэлэг, сургууль, төмөр замын барилгын ажлын гүйцэтгэл өндөр байж барилгын салбар 25.2 хувиар нэмэгдсэн бол Бөөрөлжүүгийн

²⁰ 2015 оны зэрэгцүүлэх үнээр

цахилгаан станц ашиглалтад орсон нь эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг тайлант хугацаанд дэмжсэн байна.

Уул уурхайн олборлолт эхний хагас жилд төдийлөн нэмэгдсэнгүй. Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэн хэдий ч нүүрс, газрын тос, алтны олборлолт өмнөх оноос буурсан байна. Мөн уул уурхайг дагасан тээврийн орлого огцом буурч, тээврийн салбарын бодит үйлдвэрлэл 12.5 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар сааруулжээ. Цаашлаад хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил сул байж худалдааны салбар 5.7 хувиар агшсанаар өсөлтөд 0.7 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Зураг 24. ДНБ-ий өсөлт, эдийн засгийн салбараар



Эх сурвалж: YCX

Шигтгээ 2. Уур амьсгалын өөрчлөлтийн шинжилгээ, стресс тестийн үр дүн

Дэлхий нийтээр уур амьсгалын өөрчлөлт (УАӨ) хурдтай явагдаж, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртож, хохирол нэмэгдэж байгаа нь хөдөө аж ахуй, уул уурхайгаас өндөр хамааралтай манай улсын хувьд дэд бүтэц, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд томоохон эрýсдэл учруулахаар байна. Иймд уур амьсгалын эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх, аргазүй, өгөгдөл мэдээллийн зөрүүтэй байдлыг тодорхойлох зорилгоор банкны салбарын уур амьсгалын стресс тестийг туршилтаар жил орчмын хугацаанд системийн ач холбогдол бүхий банкуудын оролцоотой нийт 7 банкны тоо, мэдээлэлд үндэслэн анх удаа гүйцэтгэлээ.

Энэхүү шинжилгээнд уур амьсгалын биет болон шилжилтийн эрсдэлийн хэд хэдэн хувилбаруудыг авч үзсэн. Тодруулбал, бага нүүрстөрөгчийн хий бүхий эдийн засагт шилжихэд үүсэх шилжилтийн эрсдэлийг үнэлэх хүрээнд i) Одоогийн бодлого хэвээр үргэлжлэх, ii) Дэлхийн дулаарал цельсийн 2 градусаас бага байх, iii) Шилжилт хойшлох гэсэн ялгаатай хувилбаруудыг NGFS²¹-ээс гаргадаг хувилбарт үндэслэн байгуулсан. Уур амьсгалын биет эрсдэлийн хувьд i) ган/зуд, ii) үерийн эрсдэлийг тус тус авч үзсэн. Эдгээр хувилбар тус бүрт статик балансийн аргачлал ашиглан эдийн засгийн секторуудаар

²¹ Network greening the financial system (NGFS) - Төв банкууд болон хянан шалгах байгууллагуудын ногоон санхүүгийн сүлжээ

банкуудын эрсдэлийн параметруудыг 2030 болон 2050 оны хувьд тооцсон. Мөн эдийн засгийн секторуудаар банкны санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг тооцохын зэрэгцээ банкны уур амьсгалын эрсдэлийн удирдлагатай холбоотой чанарын судалгааг хийж гүйцэтгэв.

Уур амьсгалын эрсдэлүүд нь банкны салбарын активын хүлээгдэж буй алдагдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр өсгөхөөр байна. Тухайлбал, шилжилтийн эрсдэлийн хувилбаруудын хувьд активын хүлээгдэж буй алдагдал 2030 он гэхэд 11-14 хувиар нэмэгдэх, үүн дотроо дулаарал цельсийн 2 градусаас бага байх хувилбарт богино хугацааны бодлогын шокын улмаас активын хүлээгдэж буй алдагдал хамгийн огцом нэмэгдэхээр байна. Одоогийн бодлого хэвээр үргэлжлэх хувилбарт активын алдагдал суурь түвшинтэй харьцуулахад 17.3%-иар нэмэгдэхээр байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх нь урт хугацаанд өндөр зардал дагуулахыг харуулж байна. Биет эрсдэлүүдийн тухайд ган, зудын хосолсон гамшигт үзэгдэл нь хүлээгдэж буй активын алдагдлыг 2030 онд 11.7%, 2050 онд 22.7%-иар тус тус нэмэгдүүлэхээр байна. Харин үерийн эрсдэлийн үнэлгээгээр орон сууц болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн гуравны хоёр нь маш өндөр эрсдэлтэй бүсэд төвлөрсөн байгаа нь банкуудыг их хэмжээний алдагдалд өртөх эрсдэлтэйг харуулж байна.

Санхүүжүүлсэн ХХЯ-ын үнэлгээгээр Монгол Улсын нийт ялгарлын ойролцоогоор 23%-ийг банкны зээлээр санхүүжүүлсэн ХХЯ эзэлж байгаа бөгөөд хөдөө аж ахуй, боловсруулах, тээврийн салбарт санхүүжүүлсэн ялгаралын хэмжээ хамгийн өндөр байна. Энэ нь банкууд өөрсдийн зээлийн багцыг уур амьсгалын зорилтуудтай нийцүүлэх замаар өндөр ялгаруулагч секторуудын ялгаралыг бууруулахад томоохон хувь нэмэр оруулах боломжтойг илтгэж байна. Чанарын судалгаагаар банкуудын уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ эхний шатандаа байна. Ихэнх банкууд бизнесийн тасралтгүй байдал болоод эрсдэлийн удирдлагын хүрээнд уур амьсгалын эрсдэлийг авч үздэг ч секторт суурилсан загвар, цогц өгөгдлийн систем, зах зээл, хөрвөх чадвар, хуулийн эрсдэлийн үнэлгээнд уур амьсгалын эрсдэлийг нэгтгэх тал дээр дутагдалтай байна.


Ерөнхийдөө энэхүү уур амьсгалын шинжилгээ нь Монгол Улсын санхүүгийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх чиглэлд анхдагч алхам болж байна. Энэхүү шинжилгээгээр дамжуулан банкуудад уур амьсгалын эрсдэлийг үнэлэх чадамжийг бий болгох, шилжилтийн болон биет эрсдэлийн нөлөөллийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, өгөгдөл, арга зүйг сайжруулах болон бодлого, зохицуулалтын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох боломжийг олгож буйгаараа чухал ач холбогдолтой байна. Цаашид уур амьсгалын шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх, шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах болон уур амьсгалын шинжилгээ, стресс тестийг тогтмолжуулах нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй өсөн нэмэгдэж буй эрсдэлийг даван туулах, бага нүүрстөрөгчийн эдийн засагт шилжих үйл явцыг дэмжихэд Монголын санхүүгийн системийн бэлэн байдлыг хангахад чухал үүрэгтэй байх юм.

2.2. Нийт эрэлт

Урьдчилсан гүйцэтгэлээр нийт эрэлт 2025 оны эхний хагас жилд 5.7 хувиар²² өслөө. Өрхийн хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлал өсөлтийг дэмжсэн бол цэвэр экспорт бууруулах чиглэлд нөлөөлсөн байна.

Өрхийн хэрэглээ тайлант оны эхний хагаст 9.9 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 7.8 нэгж хувийг бүрдүүлэв. Өрхийн бодит орлого 2025 оны эхний хагаст 7.5 хувиар нэмэгдсэн, хэрэглээний зээл 15.0²³ орчим хувиар өссөн зэрэг нь хэрэглээг дэмжиж байна. Өрхийн хэрэглээг задалж үзвэл хүнсний хэрэглээ 11.6 хувиар өссөн нь сүү, гурил, согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой бол хүнсний бус хэрэглээ 9.2 хувиар нэмэгдсэн нь тээвэр, эрүүл мэнд, гэр ахуйн хэрэглээнээс шалтгаалжээ. Харин төрийн байгууллагын хэрэглээ 3.7 хувиар буурч, нийт өсөлтөд 0.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Зураг 25. ДНБ-ийн жилийн өсөлт, эрэлт талаас



Эх сурвалж: УСХ

Хөрөнгийн нийт хуримтлал 2025 оны эхний хагаст 7.9 хувиар өсөж, нийт өсөлтөд 3.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Үндсэн хөрөнгийн хуримтлал өсөхөд орон сууцны барилга, бусад барилга, байгууламжийн бүлэг нэмэгдсэн нь голлох нөлөөтэй байв. Харин бараа материалын үлдэгдэл буурсан нь өсөлтөд 3.0 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ.

Цэвэр экспорт нийт өсөлтөд 4.7 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүлэв. Үүнд, зэсээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ багассан нь бодит экспорт буурах шалтгаан болов. Нөгөө талаас, хөдөө, аж ахуйгаас бусад салбарын идэвхжил бага байгаагаас импортын өсөлт саарч нийт өсөлт үзүүлэх сөрөг нөлөө буурч байна.

III. УЛСЫН ТӨСӨВ

Нийт тэнцвэржүүлсэн орлого 2025 оны эхний хагаст 13.2 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 983 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар буурав. Харин төсвийн зардал эхний хагасын байдлаар 14.0 их наяд төгрөгт хүрч, 8.2 хувиар өсжээ.

²² 2015 оны зэрэгцүүлэх үнээр

²³ ХҮИ-р засварласан бодит өсөлт

Хүснэгт 3. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Тэрбум төгрөг	2025		2025.05
	Бат. I	Тод. II	Гүй. III
Нийт орлого	36,436	32,540	14,033
Тогтворжуулалтын сан	609	429	221
Үндэсний баялгийн сан	2,357	1,901	595
Тэнцвэржүүлсэн орлого	33,470	30,210	13,215
1. Татварын орлого	31,557	28,347	12,173
2. Татварын бус орлого	1,913	1,863	1,042
Нийт зардал	33,432	31,575	13,973
А. Урсгал зардал	25,305	24,005	12,183
Б. Хөрөнгийн зардал	8,340	7,841	1,754
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	-213	-272	741
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	38	-1,365	
ДНБ-д эзлэх хувь	0.0%	-1.5%	
Нэгдсэн төсвийн суурь зарлага	30,297	28,402	
ДНБ-д эзлэх хувь	31.9%	31.6%	
Нэгдсэн төсвийн суурь тэнцэл	3,173	1,808	
ДНБ-д эзлэх хувь	3.3%	2.0%	

Эх сурвалж: Сангийн яам

нь тэтгэврийн зардал байна.

Хүснэгт 4. Шаардлагатай санхүүжилт болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

Тэрбум төгрөг	2025 он	
	Жилийн төлөвлөгөө	Эхний 7 сард
Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ	3066	3175
1.1 Үнэт цаас эргэн төлөхөд	225	1731
Дотоод	225	0
Гадаад	0	1731
1.2 Зээл эргэн төлөхөд	1477	686
Дотоод	0	0
Гадаад	1477	686
1.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд	1364	758
2 Эх үүсвэрийн бүрдэл	3066	3175
2.1 Шинээр гаргасан үнэт цаас	1931	2191
Дотоод	490	160
Гадаад	1441	2031
2.2 Шинээр авсан зээл	1542	400
Дотоод	0	0
Гадаад	1542	400
2.3 Тогтворжуулалтын сан	0	0
2.4 Монголбанкинд байрших дансны цэвэр өөрчлөлт	-408	583

Эх сурвалж: Сангийн яам

Өөрөөр хэлбэл төсвийн зардлын өсөлтийг цалин, тэтгэврийн зардал бүрдүүлсэн байна. Харин хөрөнгийн зардал 541 тэрбум төгрөгөөр буурахад барилга байгууламжийн зардал 171 тэрбум төгрөгөөр бага байсантай холбоотой.


Төсвийн тэнцэл 2025 оны эхний хагасын байдлаар 758 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, 3.2 их наяд төгрөгийн зээл, үнэт цаас эргүүлэн төлсөн байна. Үүнийг шинээр гаргасан 2.0 их наяд төгрөгийн гадаад, 160 тэрбум төгрөгийн дотоод бонд болон 400 тэрбум төгрөгийн гадаад зээлээр санхүүжүүлжээ.

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

4.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв

Эдийн засаг энэ онд 5.8 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бөгөөд өсөлтийг хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, барилгын салбар голлон тэтгэхээр байна. Тодруулбал, малын зүй бус хорогдол бага, төл бойжилт сайн байж хөдөө аж, ахуйн салбарын өсөлт 2025 онд нийт өсөлтийн тал орчим хувийг бүрдүүлэхээр байна. Уул уурхайн салбарын хувьд зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь өсөлтийг тэтгэхээр байгаа бол аж үйлдвэр, барилгын салбарын хувьд хүнсний үйлдвэрлэл энэ онд сэргэх, орон сууц, эмнэлэг, сургууль, төмөр замын барилгын ажлын гүйцэтгэл өндөр байгаа нь өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Нөгөө талаас нүүрсний экспортын орлого болон биет хэмжээ буурч, үүнээс шалтгаалан авто замын тээврийн орлого буурснаар тээврийн салбар энэ онд агших бол зээлийн өсөлт, гадаад худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад удааширч, худалдааны салбарын үйлдвэрлэл буурахаар байна.

Зураг 26. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (нийт нийлүүлэлт болон нийт эрэлт)



*2025 оны II улирал болон 7 дугаар сарын тоон мэдээнд үндэслэсэн төсөөлөл


Эх сурвалж: YCX, Монголбанк

Нийт эрэлт 2025 онд мөн 5.8 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бөгөөд өсөлтийн дийлэнх хэсгийг эцсийн хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлал бүрдүүлэхээр байна. Тодруулбал, өрхийн хэрэглээ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь өсөлтөд эерэг нөлөөлөх боловч цаашид өрхийн орлого, хэрэглээний зээлийн өсөлт саарч байгаа нь өсөлтийн эрчийг сааруулна. Түүнчлэн, энэ оны эхний хагаст ихэнх нутгаар цаг агаар харьцангуй таатай байсан нь хөдөө аж ахуй салбарт эерэгээр нөлөөлсөн, мөн төсвийн хөрөнгө оруулалтын зардал нэмэгдсэн зэргээс шалтгаалж үндсэн хөрөнгийн хуримтлал энэ онд эрчтэй өсөх хүлээлттэй байна. Нөгөө талаас, нүүрсний үнэ дэлхийн зах зээлд харьцангуй бага, экспорт 2025 онд өмнөх оноос 4 сая орчим тонноор бууран 80.0 сая

тоннд хүрэхээр хүлээгдэж байгаа нь цэвэр экспортыг бууруулан, өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлтийн дунд хугацааны төсөөллийг авч үзвэл 2026-27 онуудад 30 хувийн итгэх интервалд харгалзан 3.4-7.9 хувь, 3.1-8.5 хувийн орчимд гарах хүлээлттэй байна. Уул уурхайн салбарын хувьд зэсийн баяжмалын агууламж нэмэгдсэн нөлөө харьцангуй өндөр түвшинд хадгалагдах, экспортын үнэ болон олборлолт энэ оны түвшинд тогтвортой байх зэрэг нь 2026 оны өсөлтийг тэтгэхээр байна. Уул уурхай болон хөдөө аж ахуйгаас бусад салбарын хувьд энэ оны бага өсөлтийн суурь нөлөөгөөр өсөлт нэмэгдэх ч гадаад эрэлт саарах, хөрөнгө оруулалтууд багасах зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтийн эрчийг сааруулна гэж үзлээ. Төсөөлөлд цаг агаарын нөхцөл байдал хэвийн байна гэсэн таамаглалт нөхцөлийг ашигласан бөгөөд хэрэв өвөлжилт хүндэрвэл хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг сааруулах эрсдэлтэй. Харин 2027 оноос зарим төслийн бүтээн байгуулалтын ажлууд дуусаж, эдийн засгийн өсөлт 5-6 хувийн орчимд тогтворжих хүлээлттэй байна.

Зураг 27. Эдийн засгийн өсөлтийн дунд хугацааны төсөөлөл




*4 улирлын нийлбэр ДНБ-ий өсөлт
Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.2. Инфляцын төлөв

Инфляц 2025 оны эцэст зорилтот түвшинд хүрч буурахаар байна. Жил дараалсан цалингийн өндөр өсөлт болон цахилгаан, нийтийн тээвэр зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ нэмэгдсэнээс инфляц 2025 оны эхний саруудад эрчимжиж зорилтоос даваад байв. Мөнгө, санхүүгийн бодлогын төлөвийг шат дараатайгаар хатууруулсан, өвөлжилт өнтэй байсан зэргээс сүүлийн саруудад инфляц аажим буурч байна. Цаашид эдийн засагт томоохон шок бий болохгүй, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ огцом өсөхгүй тохиолдолд инфляцын буурах хандлага үргэлжилж зорилтот түвшинд хүрч тогтворжихоор байна.


Зураг 28. Инфляцын богино хугацааны төсөөлөл, бүрэлдэхүүнээр²⁴



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Инфляцын дунд хугацааны төсөөллөөр 2026 онд 30 хувийн итгэх интервалд харгалзан 4.6-9.2 хувь, 2027 онд 2.7-7.5 хувийн орчимд тогтворжих хүлээлттэй байна. Тодруулбал, инфляцын эрч саарч, 2026 онд Төв банкны зорилтын дээд интервалын орчимд хадгалагдахаар байна. Үүнд, нэг талаас 2026 оны эхний хагаст хүнсний инфляц эрчимжих ч нөгөө талаас төрийн зохицуулалттай зарим үйлчилгээний үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилах, эдийн засгийн өсөлт харьцангуй тогтворжин, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурах, гадаад инфляц харьцангуй бага түвшинд хадгалагдах зэрэг нь инфляцыг сааруулах гол нөлөөг үзүүлэхээр байна.

Зураг 29. Инфляцын дунд хугацааны төсөөлөл



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

²⁴ Үйлчилгээний бүлэгт төрийн зохицуулалттай үйлчилгээ багтана.

4.3. Төсвийн бодлогын төлөв

Өнгөрсөн онд уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр төсвийн орлого бүрдүүлэлт сайн байсан хэдий ч төсвийн зардал орлогын өсөлтийг даган нэмэгдсэнээр төсвийн төлөв 1.9 нэгж хувиар суларлаа. Харин 2025 онд нүүрсний үнийн уналтаас шалтгаалан уул уурхайн салбар болон түүнийг дагасан салбаруудын орлого буурах, төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 3.0 орчим хувиар саарахаар байна. Улмаар төсвийн алдагдал ДНБ-ий 2.0 хувьд хүрч төсвийн төлөв 1.3 нэгж хувиар сулрах хүлээлттэй байна.

2026 онд зэсийн баяжмалын агууламж харьцангуй өндөр түвшинд хадгалагдах, эрдэс түүхий эдийн үнэ харьцангуй тогтвортой байх хэдий ч татварын багц хуулийн шинэчлэлийн нөлөөгөөр татварын орлого саарч, төсвийн тэнцвэржүүлсэн орлого төдийлөн нэмэгдэхээргүй байна. Харин 2027 оны хувьд эдийн засгийн өсөлт 5-6 хувийн орчимд тогтворжих, алт, зэсийн үнийн төсөөлөл харьцангуй өндөр хэвээр хадгалагдах, зэсийн баяжмалын экспортын хэмжээ 2026 оныхоос нэмэгдэх нь нэг талаасаа төсвийн орлогын өсөлтөд дэмжлэг үзүүлэхээр байгаа ч татварын шинэчлэлийн нөлөө нь орлогыг тус онд сааруулах нөлөө үзүүлснээр тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 5 орчим хувиар нэмэгдэхээр байна. 2026 оны төсвийн өргөн барьсан санал, төсвийн хүрээний мэдэгдэлд²⁵ тусгаснаар ирэх онуудад төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал ДНБ-ий -2.0 хувьд хүрэх, суурь тэнцэл ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байх хүлээлттэй байна. Улмаар төсвийн төлөв 2026 онд өөрчлөлтгүй байхаар байгаа бол 2027 онд 0.1 нэгж хувиар чангарах тооцоололтой байна.

Зураг 30. Төсвийн импульс




4.4. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүдийн төлөв

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн жил гаран хугацаанд саарах хандлагатай байсан бол 2025 оны 8 дугаар сард эргэн нэмэгдлээ. Сүүлийн 4 улирал гадаад валютын цэвэр орох урсгал саарч, банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 3.7 хувьд хүрч саарах гол


²⁵ 2026 онд 33.0 их наяд төгрөг, 2027 онд 34.6 их наяд төгрөг

шалтгаан болов. Харин сүүлийн хоёр сард төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал өмнөх оны мөн үеэс сайжирсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 6.5 хувьд хүрч нэмэгдэх гол хүчин зүйл боллоо. Түүнчлэн, зээлийн өсөлт сүүлийн саруудад алгуур саарч байгаа боловч мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг тэтгэсэн хэвээр байна.

Зураг 31. M2 мөнгөний өсөлт, актив



Зураг 32. M2 мөнгөний өсөлт, пассив



Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт саарч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд 2.7 нэгж хувийн нөлөө үзүүлсэн бол гадаад валютын харилцах, хадгаламж 3.9 нэгж хувийг бүрдүүлэв. Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт сүүлийн жил гаран хугацаанд 25.4 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өндөр үзүүлэлт байна. Харин зээлийн долларжилтын хувьд сүүлийн гурав гаруй жилийн хугацаанд 6-7 хувийн орчимд хадгалагдаж байна.


Ипотекийн зээлээр баталгаажуулсан бондыг оруулан нийт зээлийн өсөлтийг авч үзвэл, өнгөрсөн оны сүүлийн хагаст өндөр түвшинд хадгалагдаж байсан зээлийн өсөлт сүүлийн саруудад саарч, 2025 оны 7 дугаар сард 25.2 хувьд хүрлээ. Өнгөрсөн онд цалингийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж²⁶, уул уурхай, хөдөө аж ахуйгаас бусад салбарууд 10 орчим хувиар тэлсэн, дотоод идэвхжил өндөр байсны зэрэгцээ Хуримтлалын сангаас ипотекийн зээлийн санхүүжилт олгогдож эхэлсэнтэй холбоотойгоор зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдсан. Түүнчлэн, 2024 оны 12 сард банкны системийн чанаргүй зээлийн үлдэгдэл зээлийн багцын 3.5 хувийг бүрдүүлж байгаа нь сүүлийн 10 жилийн хамгийн бага үзүүлэлт болж, банкуудын зээлийн чанар сайжирсан нь зээл олголт нэмэгдэхэд нөлөөлсөн байж болзошгүй. Харин энэ оны эхний хагаст хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил сул байгаагаас гадна цалингийн өсөлт саарч, 2025 оны 3 дугаар сард хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг бууруулж 50 хувьд хүргэсэн бөгөөд тэтгэврийн зээлд макро зохистой бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн²⁷ зэрэг нь зээлийн өсөлт сүүлийн саруудад саарахад голлон нөлөөллөө.

²⁶ Дундаж цалин 2024 онд дунджаар 24.5 хувиар өсөв.


²⁷ МБХ-ны 2025 оны 3 дугаар сарын ээлжит хурлаар банкнаас шинээр олгох болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр, орлогын

Цаашид зээлийн өсөлт үргэлжлэн саарахаар байна. Энэ онд ипотекийн зээлийн санхүүжилт өмнөх оны орчимд байх, цалингийн өсөлт саарах болон хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил төдийлөн нэмэгдэхээргүй байгаагаас зээлийн өсөлт үргэлжлэн саарахаар байна. Ирэх онд төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, банкуудын зээл олгох боломжит эх үүсвэр буурах, эдийн засгийн өсөлтийн төлөвтэй уялдан зээлийн өсөлт алгуур саарах хүлээлттэй байна.

Зураг 33. Банкны системийн долларжилт



Зураг 34. Нийт зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Энэ онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна. Үүнд, нэг талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон тэтгэж буй зээлийн өсөлт саарах, нөгөө талаас төсвийн алдагдал тэлж, төсвийн төлөв сулрахаар байна. Улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлт энэ оны эцэст 6.0 хувьд хүрэх тооцоололтой байна. Ирэх онуудад зээлийн өсөлт саарах, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэхээр байгаагаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлт төдийлөн сэргэхээргүй байна.

Цаашид геополитикийн эрсдэл, гадаад худалдааны нөхцөлтэй холбоотойгоор төлбөрийн тэнцэл, төсвийн төлөв болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, арилжааны банкуудын зээлийн нөхцөл, шалгуур хэрхэн өөрчлөгдөхөөс зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн төлөв хамаарахаар байна.

Шигтгээ 3. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээ

Хөрөнгийн урсгалын матриц шинжилгээний аргачлал нь эдийн засгийн 4 сектор буюу Засгийн газар, хувийн сектор, гадаад сектор болон санхүүгийн салбар хооронд тодорхой хугацаанд шилжиж буй хөрөнгийн урсгалыг шинжилдэг. Энд 2024 оны байдлаар хөрөнгийн илүүдэл болон дутагдлыг сектороор тодорхойлж, дутагдалтай салбарууд нь алдагдлаа хөрөнгийн илүүдэлтэй бусад салбаруудын хөрөнгөөр хэрхэн санхүүжүүлж, нөөцийн шилжилт хэрхэн хийгдсэнийг санхүүгийн бус болон санхүүгийн тэнцлээр харууллаа. Санхүүгийн бус тэнцлээр засгийн газрын болон хувийн хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалтын балансыг ерөнхий байдлаар харуулж эдийн засагт хэдий хэмжээний хөрөнгийн

харьцааны дээд хязгаарыг бусад хэрэглээний зээлийн адилаар 50 хувиар тогтоохоор шийдвэрлэв. Уг шийдвэрийг 2025 оны 7 дугаар сард хүчингүй болгов.

дутагдал бий болж, гадаад эх үүсвэрээр санхүүжүүлснийг тодорхойлно. Гадаад санхүүжилт нь эдийн засгийн потенциалыг ирээдүйд нэмэгдүүлэх ач холбогдолтой боловч хэт их байх нь эргээд ирээдүйн хэрэглээг хумих, өрийн дарамтад орох зэргээр эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг.

Харин санхүүгийн тэнцлийн хувьд хөрөнгийн дутагдлыг гадаад, дотоод ямар эх үүсвэрээр яаж санхүүжүүлсэн бэ гэдгийг сектор бүрийн хувьд санхүүгийн зуучлагчдын балансаар дамжуулан дэлгэрэнгүй авч үздэг.

А. Санхүүгийн бус тэнцэл²⁸: Эдийн засгийн харьяатууд 2024 онд 72.6 их наяд төгрөгийн цэвэр орлоготой ажилласнаас, орлогынхоо ихэнх хэсэг буюу 72 орчим хувийг (52.4 их наяд төгрөг) хэрэглээндээ зарцуулав. Улмаар нийт хадгаламж²⁹ 20.2 их наяд төгрөгт хүрч, нийт хөрөнгө оруулалт болох 28.7 их наяд төгрөгийг санхүүжүүлэхэд хүрэлцээгүй тул 8.4 их наяд төгрөгийн эх үүсвэрийг гадаад сектороос татсан байна. Өөрөөр хэлбэл, урсгал тэнцэл уг дүнгээр (ДНБ-ий 10.5 хувь) алдагдалтай гарчээ.

Засгийн газар болон хувийн сектороор нь ангилан авч үзвэл, Засгийн газар орлогынхоо 71.4 хувийг, хувийн сектор орлогынхоо 72.3 хувийг тус тус хэрэглэсэн байна.

Засгийн газар өнгөрсөн онд 17.5 их наяд төгрөгийг татварын цэвэр орлого хэлбэрээр бүрдүүлж, үүний 71.4 хувьтай тэнцэх буюу 12.5 их наяд төгрөгийг хэрэглээндээ зарцуулсан бол 5.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гаргажээ. Ийнхүү Засгийн газрын хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү -776 тэрбум төгрөг байв.

Хувийн секторын цэвэр орлого 2024 онд 55.1 их наяд төгрөг хүрч, үүнийхээ 72.3 хувийг буюу 39.9 их наяд төгрөгийг хэрэглэсэн байна. Харин хөрөнгө оруулалтад 22.9 их наяд төгрөгийг зарцуулснаар, хувийн секторт хадгаламжаасаа 7.6 их наяд төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болжээ.

Б. Санхүүгийн тэнцэл.

1. Гадаад санхүүжилт: Дотоод эдийн засгийн салбарууд гадаад сектороос нийт 9.2 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгийн урсгалыг хүлээн авснаас хувийн сектор 6.9 орчим их наяд төгрөгийг бүрдүүллээ. Нийт гадаад санхүүжилтийн дүн дотоодын санхүүгийн бус тэнцлээс их байгаа нь төлбөрийн тэнцлийн ашигтай холбоотой бөгөөд энэ нь гадаад цэвэр активыг нэмэгдүүлнэ.

$$^{28} [GNDI = C + I + (X - M) + Y_f + Y_r] \Rightarrow [GNDI - C - I = CAB] \Rightarrow [S - I = CAB] \Rightarrow [(S_g - I_g) + (S_p - I_p) = CAB].$$

Энд Y – Үндэсний цэвэр орлого, X – Нийт экспорт, M – Нийт импорт, Y_f – Төлбөрийн тэнцлийн анхдагч орлого, Y_r – Төлбөрийн тэнцлийн хоёрдогч орлого, $GNDI$ – Үндэсний нийт цэвэр орлого, C – Эцсийн хэрэглээ, I – Нийт хөрөнгө оруулалт, CAB – Урсгал тэнцэл, S – Дотоодын нийт хуримтлал, S_g – Засгийн газрын хуримтлал, I_g – Засгийн газрын хөрөнгө оруулалт, S_p – Хувийн секторын хуримтлал, I_p – Хувийн секторын хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

²⁹ Цэвэр орлого-Хэрэглээ

Хүснэгт 5. Эдийн засгийн секторууд хоорондын хөрөнгийн урсгалын шинжлэгээний матриц, тэрбум төгрөгөөр

Гүйлгээ/Салбарууд	Дотоод эдийн засгийн салбарууд							Гадаад сектор
	Дотоод эдийн засаг	Засгийн газар	Хувийн сектор	Санхүүгийн сектор	Үүрэг			
					Төв банк	Банк	Бусад санхүүгийн байгууллага	
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО (I)	72602	17473	51148					
Эцсийн хэрэглээ (II)	52355	12483	39873					
Нийт хөрөнгө оруулалт (III)	28672	5766	22906					
Экспорт	55440							-55440
Импорт	-56240							56240
Хүчин зүйлсийн орлого	-9054							9054
Шилжүүлэг (цэвэр)	1427							-1427
A. САНХҮҮГИЙН БҮС ТЭНЦЭЛ (I-II-III)	-8426	-776	-7649					8426
1. ГАДААД САНХҮҮЖИЛТ	9766	2152	6913	701			701	-9766
Хөрөнгө оруулалт	11205	773	9801	632			632	-11205
ГШХО	9243		9243					-9243
Санхүүгийн ХО	1380	773	-24	632			632	-1380
Хөрөнгийн данс	581		581					-581
Гадаад цэвэр зээл	827	1379	-622	69			69	-827
Бэлэн валют, харилцах	-2266		-2266					2266
2. ДОТООД САНХҮҮЖИЛТ		-1565	3462	-1898	4465	-4736	-1627	
Дотоод зээл		-3351	11794	-8443	2574	-8753	-2263	
Засгийн газрын цэвэр зээл		-3351	562	2789	2376	417	-3	
Зээл, үнэт цаас			11232	-11232	198	-9170	-2260	
Нийт мөнгө			-5266	5266	72	4656	537	
Санхүүгийн байгууллага хоорондын хөрөнгийн урсгал					1971	-1394	-577	
Төв банк					1264	-827	-437	
Банк					1193	-567	-626	
БСБ					-487		487	
Бусад цэвэр зүйлс		1787	-3066	1279	-153	756	676	
3. ГИЦАКТИВЫН ӨӨРЧЛӨЛТ (-)	-255			-255	4463	-4718	0	255
Гадаад актив (+)	1086			1086	2052	-966	0	-1086
Гадаад пассив (ОУВС-гийн зээл орсон) (-)	1341			1341	-2411		0	-1341
						3752		
Б. САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ (1+2-3)	10021	588	10375	-942	2	-18	926	-10021
В. А.ЦАА БА ЗАЛРУУЛГА	-1595	189	-2726	942	-2	18	926	1595

Тэмдэглэгээ: Гадаад болон дотоод санхүүжилтийн хувьд (±) тэмдэгтэй байгаа нь өр төлбөр болоод хөрөнгө нэмэгдсэнийг³⁰ илэрхийлнэ. Харин гадаад цэвэр активын хувьд (+) тэмдэг нь гадаад актив нэмэгдэх, гадаад өр төлбөр буурсан болохыг илтгэнэ³¹. Төлбөрийн тэнцэл, нэгдсэн төсөв болон мөнгөний тоймын статистик хоорондын зөрүү, алдаа, орхигдуулга, валютын ханийн зөрүү зэрэг нь цэвэр алдаа ба залруулгыг тайлбарлана.

Хувийн сектор гадаад зах зээлээс цэвэр дүнгээр нийт 6.9 орчим их наяд төгрөгийн эх үүсвэр татсаны дийлэнх нь ГШХО хэлбэртэй байна. Тухайлбал, хувийн сектор 9.2 их наяд төгрөгийн ГШХО татсан бөгөөд үүний 83 орчим хувь нь Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчийн зээлтэй холбоотой хүүний аккруэль байна. Түүнчлэн хувийн сектор цэвэр дүнгээр 622 тэрбум төгрөгийн гадаад зээлийг эргэн төлөв.

³⁰ Хөрөнгө болон өр төлбөр буурсан бол (-) тэмдэгтэй байна.

³¹ (-) тэмдэг нь гадаад актив буурах/ гадаад өр төлбөр нэмэгдсэн болохыг илэрхийлнэ.

Засгийн газар гадаад эх үүсвэрээс цэвэр дүнгээр 2.2 их наяд төгрөгийн эх үүсвэр татжээ. Үүнд, цэвэр дүнгээр гадаад зээлээр 1.4 их наяд төгрөг, гадаад бондоор 773 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2. Дотоод санхүүжилтийн хэсэгт сектор хоорондын санхүүгийн хөрөнгийн урсгалыг харуулдаг. Дотоод эдийн засагт **Засгийн газар** болон **санхүүгийн сектороос** хөрөнгө шилжин, **хувийн сектор** хөрөнгө хүлээн авсан байна.

Засгийн газар төсвийн алдагдлыг голлон гадаад эх үүсвэрээр санхүүжүүлж, үлдсэн 1.4 их наяд төгрөг болон Баялгийн сантай холбоотой хувийн сектороос татсан 1.8 их наяд төгрөгийг санхүүгийн секторт байршуулав. Хувийн сектор санхүүгийн сектороос 11.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг зээл, үнэт цаас хэлбэрээр авсан бол 5.3 их наяд төгрөгийн хөрөнгийг арилжааны банкуудад харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулжээ. Түүнчлэн, санхүүгийн сектор дотроо цэвэр дүнгээр арилжааны банкнаас 1.4 их наяд төгрөг, бусад санхүүгийн байгууллагаас 577 тэрбум төгрөгийн хөрөнгө Төв банк руу шилжив.

3. Санхүүгийн секторын гадаад цэвэр активын өөрчлөлт -255 тэрбум төгрөг байгаа нь Төв банк болон арилжааны банкуудын гадаад цэвэр актив тус дүнгээр буурсныг илэрхийлнэ. Тухайлбал, арилжааны банкны хувьд гадаад цэвэр актив 4.7 их наяд төгрөгөөр буурсан нь энэ дүнгээр арилжааны банкуудын гадаадад байршуулсан хөрөнгө цэвэр дүнгээр буурсныг илтгэнэ. Харин Төв банкны гадаад цэвэр актив 4.5 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд гадаад актив 2.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж, гадаад пассив 2.4 их наяд орчим төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Нэгтгэн дүгнэхэд, дотоод эдийн засагт хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү буюу урсгал тэнцэл 2024 онд 8.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Өөрөөр хэлбэл, дотоодын хадгаламж хөрөнгө оруулалтдаа хүрэлцээгүй тул уг хэмжээний гадаад санхүүжилтийн шаардлага үүсч, үүнийг голлон ГШХО болон гадаад бондоор санхүүжүүлэв. Түүнчлэн, уул уурхайн бус эдийн засгийн идэвхжил өндөр түвшинд хадгалагдаж, санхүүгийн системээс хувийн секторт олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн, төсвийн алдагдлыг голлон гадаад эх үүсвэрээр санхүүжүүлсэн зэргээс шалтгаалан цэвэр дүнгээр хувийн сектор бусад дотоод эдийн засгийн секторуудаас хөрөнгийн урсгал хүлээн авсан байна.

4.5. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв

Нүүрсний үнэ буурснаар урсгал дансны алдагдал тэлж байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл, тарифын гэнэтийн шийдвэрүүдээс шалтгаалан гангийн эрэлт буурав. Түүнчлэн тус улсын дотоодын нүүрсний уурхайнуудын үйлдвэрлэл эрчимжсэнээр нүүрсний үнэ оны эхний хагаст 40 хувиар буураад байна. Иймд нүүрсний экспортын орлого 2025 онд өмнөх оноос 3 тэрбум ам.доллараар буурах тооцоололтой байна. Алт, зэсийн үнэ олон улсын зах зээлд харьцангуй өндөр байж, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ нэмэгдэж байгаа нь нүүрсний экспортоос ирж буй сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх ч бүрэн нөхөхөөргүй байна.

Импорт энэ онд өмнөх оноос нэмэгдэхээргүй байна. Тухайлбал, нүүрсний экспорттой уялдан өмнөх онуудад огцом нэмэгдээд байсан уул уурхайн тоног төхөөрөмж, том

оврын тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт энэ онд буурч байна. Мөн 2025 онд авч хэрэгжүүлж буй мөнгө, санхүүгийн бодлогыг хатууруулсан, ХАА бус салбарын идэвхжил сул байгаа зэргээс хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт саарах тооцоололтой.

Санхүүгийн дансны ашиг энэ онд өмнөх жилээс буурах төсөөлөлтэй байна. Зэсийн экспортын орлого нэмэгдэхтэй уялдан гадаад хөрөнгө оруулагчийн зээл өмнөх жилүүдээс буурах нь үүнд нөлөөлнө. Засгийн газрын гадаад зээл болон банкуудын гадаад зээл, бондын эх үүсвэрүүд энэ оны санхүүгийн дансны орох урсгалыг голлон бүрдүүлж, урсгал дансны алдагдлын тодорхой хэсгийг санхүүжүүлэх төлөвтэй байна.

Төлбөрийн тэнцэл ирэх онд алдагдалтай байх суурь төсөөлөлтэй. Урсгал дансны алдагдал буурах хэдий ч санхүүгийн дансны ашиг тус алдагдлыг нөхөхөөргүй байна. Алт, зэсийн үнэ олон улсын зах зээлд өндөр хэвээр байж, зэсийн үйлдвэрлэл өндөр байх нь экспортын орлогын өсөлтийг тэтгэх хэдий ч нүүрсний үнэ, биет хэмжээ огцом нэмэгдэх боломж хязгаарлагдмал байна. Түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан импортын өсөлт бага байх тооцоололтой.

Санхүүгийн дансны ашиг ирэх онд өндөр дүнгээр буурах хүлээлттэй боллоо. Тодруулбал, хувийн секторын гадаад зээлийн эргэн төлөлт өмнөх онтой харьцуулахад харьцангуй өндөр байх хуваарьтай байна. Үүнд банк болон хувийн секторын олон улсын зах зээлд шинээр гаргах гадаад бондын санхүүжилт 2025 онтой харьцуулахад нэмэгдэхгүй байх таамаглал ашиглав.

Төлбөрийн тэнцлийн төсөөлөлд нүүрсний үнийн бууралт томоохон эрсдэлийг дагуулж байна. Том гүрнүүдийн худалдааны сөргөлдөөн ширүүсч, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал болон эрдэс бүтээгдэхүүний үнэ хүлээлтээс эрчтэй муудвал төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлнө. Гадаад эдийн засгийн орчин таагүй үед Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон төслүүдийн бүтээн байгуулалт давхцаж байна. Эдгээр төслүүдийг гадаад бус дотоод эх үүсвэрээр санхүүжүүлвэл төлбөрийн тэнцлийн алдагдал улам тэлж, эдийн засгийн хүндрэл гүнзгийрэх эрсдэл үүснэ.

4.6. Инфляцын гол эрсдэлд суурилсан хувилбар төсөөлөл

Инфляц суурь төсөөллөөс өөрчлөгдөж болзошгүй гадаад, дотоод голлох эрсдэлүүдэд үндэслэн; 1) Экспортын орлого буурах 2) Цаг агаарын нөхцөл муудах гэсэн хувилбар төсөөллүүдийг боловсрууллаа. Эдгээр нөхцөл байдал үүсвэл инфляц болон эдийн засгийн бусад үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг суурь төсөөлөлтэй харьцуулан тайлбарлав.


Хувилбар 1. Нүүрсний үнэ ирэх онд 10 орчим хувиар буурах, экспортын биет хэмжээ энэ оны түвшинд хадгалагдах тохиолдолд экспортын орлого 800 орчим сая ам.доллаароор бууран эдийн засагт дараах нөлөөг үзүүлэхээр байна. Энэ тохиолдолд уул уурхайн салбарын өсөлт саарч, уг салбараас хамааралтай тээвэр, худалдаа зэрэг салбаруудын орлого буурч, ирэх оны эдийн засгийн өсөлт 1.1 нэгж хувиар буурахаар байна. Ийнхүү эдийн засгийн өсөлт саарч, инфляцын дарамт буурах хэдий ч төлбөрийн тэнцлийн алдагдал тэлснээр ханшид ирэх дарамт нэмэгдэх, улмаар импортын барааны үнэ,

цаашлаад дотоодын бараа, үйлчилгээний үнийг өсгөж инфляц суурь төсөөллөөс ирэх онд 0.7 нэгж хувиар, 2027 онд 1.2 нэгж хувиар тус тус нэмэгдэхээр байна.

Хувилбар 2. Энэ оны 8 дугаар сарын байдлаар нийт нутгийн 40 орчим хувьд гандуу байсантай холбоотойгоор ургацын хэмжээ бага байх, өвөлжилт хүндэрч малын хорогдол нэмэгдэх тохиолдолд эдийн засагт үзүүлэх нөлөөг авч үзье. Энэ хувилбар төсөөлөлд 2024 онд тохиосон зудтай ижил хэмжээний хохирол учруулах таамаглалт нөхцөлийг авч үзвэл эдийн засгийн өсөлт суурь төсөөллөөс энэ онд 0.4 нэгж хувиар, ирэх онд 2.6 нэгж хувиар саарахаар байна. Эдийн засгийн өсөлт буурч, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурах ч нийлүүлэлтийн шалтгаанаар мах, гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өсөж нийт инфляцыг энэ онд 0.4 нэгж хувиар, ирэх онд 0.6 хувиар тус тус өсгөхөөр тооцлоо.

Хувилбар 3. Ирэх онд нүүрсний экспортын биет хэмжээ өргөн барьсан Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн дагуу 90 сая тонн хүрч нэмэгдэхэд экспортын орлого сайжирч төлбөрийн тэнцлийн алдагдал 410 орчим сая ам.доллараар багасахаар байна. Улмаар ханшийн сулрах дарамт буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш суурь төсөөллөөс чангарах бол нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт сайжрах, үүний дам нөлөөгөөр уул уурхайгаас бусад салбарын өсөлт нэмэгдэж эдийн засгийн өсөлт 0.7 нэгж хувиар сайжрахаар байна. Ийнхүү эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн дарамт нэмэгдэх хэдий ч ханш өмнөхөөс чангарснаар импортын барааны үнэ багаар өсөх, цаашлаад үйлдвэрлэлийн зардлаар дамжин инфляцыг 2026 оны эхний хагас хүртэл 0.3-0.4 нэгж хувиар сааруулахаар байна.

Зураг 35. Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөллүүд



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 6. Инфляцын эрсдэлд суурилсан хувилбар төсөөллүүд

Хувилбарууд	Авч үзсэн нөхцөлүүд	Инфляц**			
		2024	2025*	2026*	2027*
Суурь	Суурь төсөөлөл	7.4	8.1	6.9	5.1
X1	Экспортын орлого буурах	7.4	8.1	7.6	6.3
X2	Цаг агаарын нөхцөл муудах	7.4	8.5	7.5	4.6
X3	Эдийн засгийн нөхцөл сайжрах	7.4	7.7	6.9	5.2

**Он тус бүрийн 4 улирлын дундаж инфляц

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 7. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД											
									2025	2026	2027
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025.07*	Төсөөлөл		
живийн өсөлтийн хувь											
Бодит сектор											
Бодит ДНБ	7.7	5.6	-4.6	1.6	5.0	7.4	5.1	5.6	5.8 [^]	5.6 ^{^^}	5.8 ^{^^^}
Уул уурхайн ДНБ	5.4	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4	10.8	1.1	8.6	5.9	5.6
Уул уурхайн бус ДНБ	8.2	6.9	-3.7	1.8	8.2	5.4	4.3	6.3	5.3	5.6	5.8
Инфляц, хугацааны элсэт	8.1	5.2	2.6	13.8	13.2	7.1	8.4	8.1	8.1	6.9	5.1
ДНБ-ийн дефлятор	8.0	10.0	3.7	14.4	17.7	21.8	8.2	3.0	6.2	7.4	4.1
их наяд төгрөгөөр											
Нэгдсэн төсөв											
Нийт орлого	10.1	11.9	10.4	14.3	18.6	24.3	31.4	16.6	31.0	33.9	35.4
Тэнцвэржүүлсэн орлого	9.2	10.8	9.4	12.7	17.2	23.2	29.6	15.6	28.8	30.8	32.3
Татварын орлого	8.2	9.7	8.5	11.3	15.6	21.5	27.4	14.4	26.4	28.1	29.2
Татварын бус орлого	1.0	1.1	0.9	1.4	1.6	1.8	2.2	1.2	2.4	2.7	3.0
Нийт зардал ба цэвэр зээл	9.2	11.4	14.0	15.6	18.2	22.5	30.4	16.9	30.6	32.9	34.5
Урсгал зардал	7.3	8.2	10.9	12.8	14.2	17.0	22.1	14.1	24.0	25.6	26.8
Хөрөнгийн зардал ба зээл	1.9	3.2	3.1	2.8	4.0	5.4	8.3	2.8	6.6	7.3	7.8
Хөрөнгийн зардал	1.6	2.8	3.1	3.0	3.8	5.2	7.9	2.7	6.8	7.6	8.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0.3	0.4	0.0	-0.2	0.2	0.2	0.4	0.1	-0.3	-0.3	-0.3
Тэнцвэржүүлсэн гэнцэл	0.0	-0.6	-4.5	-2.9	-1.0	0.8	-0.8	-1.3	-1.8	-2.1	-2.3
Аюулгүй гэнцэл (Тэнцвэржүүлсэн гэнцлээс тооцсон)	1.1	0.2	-3.6	-2.1	-0.2	1.9	0.4	-0.4	-0.5	-0.8	-1.1
Шаварлагатай санхүүжилт	2.7	1.2	7.4	7.0	2.4	4.4	3.1	3.8	5.2	4.5	6.0
Догоод эх үүсвэр	1.3	-0.3	2.3	2.9	0.7	-1.1	-0.7	1.0	1.6	0.2	0.8
Гадаад эх үүсвэр	1.4	1.5	5.1	4.1	1.7	5.4	3.7	2.9	3.6	4.4	5.2
ДНБ-д эзлэх хувь											
Тэнцвэржүүлсэн орлого	28.3	28.5	25.2	29.1	31.9	33.0	36.7	17.2	31.8	30.0	28.5
Нийт зардал ба цэвэр зээл	28.3	30.2	37.3	35.8	33.8	31.9	37.6	18.6	33.8	32.0	30.5
Тэнцвэржүүлсэн гэнцэл	0.0	-1.7	-12.1	-6.7	-1.8	1.1	-1.0	-1.4	-2.0	-2.0	-2.0
живийн өсөлтийн хувь											
Мөнгө, зээл											
M2 мөнгө	22.8	7.0	17.5	13.8	6.5	26.8	15.2	3.2	6.0	4.3	5.4
Зээл+ИЗББ	24.3	4.5	-4.0	19.5	7.5	22.5	30.9	25.1	21.8	14.9	11.0

*БДНБ-ийн өсөлт, ДНБ-ийн дефлятор 2025 оны 2 дугаар улирлаар

**2026, 2027 оны төсвийн зардлыг 2025.09.01-ний өдөр өргөн баригдсан "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд оорчилолт оруулах тухай хуулийн төсөл"-д тусгагдсан дүнгээр авав.

[^] - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(4.9) - (7.1)]

^{^^} - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(5.3) - (10.0)]

^{^^^} - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(2.3) - (7.8)]


Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл

Сүүлийн улирлуудад мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарах хандлагатай байсан бол 2025 оны 8 дугаар сард нэмэгджээ. Тухайлбал, өнгөрсөн оны 2 дугаар улиралд 31.9 хувьд хүрээд байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт энэ оны 2 дугаар улиралд 3.7 хувь, 8 дугаар сард 6.5 хувиар өслөө. Сүүлийн нэг жилийн хугацаанд банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хөдөлгөөнийг тайлбарлах гол хүчин зүйл болж байна. Тухайлбал, сүүлийн 4 улирлын турш гадаад валютын цэвэр орох урсгал буурч, банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт саараад байсан бол сүүлийн хоёр сард төлбөрийн тэнцэл ашигтай байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сэргэх гол шалтгаан боллоо. Түүнчлэн, банкны системийн зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг тэтгэж байна. Энэ онд төсөв алдагдалтай байгаа тул нэгдсэн төсвийн шаардлагатай санхүүжилт нэмэгдэж, Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)-ийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө нь буурч байна.

Зураг 36. M2 мөнгөний өсөлт, актив



Зураг 37. M2 мөнгөний өсөлт, пассив




Эх сурвалж: Монголбанк


Эх үүсвэр талаас төгрөг болон гадаад валютын эх үүсвэрийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг бүрдүүлж байна. Тухайлбал, төгрөгийн эх үүсвэр мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 2.7 нэгж хувийг бүрдүүлж байгаа бол гадаад валютын эх үүсвэр 3.9 нэгж хувийг бүрдүүлэв. Ийнхүү гадаад валютын эх үүсвэр төгрөгийн эх үүсвэрээс илүү нэмэгдэж, банкны системийн эх үүсвэрийн долларжилт өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өслөө³². Харин зээлийн долларжилт сүүлийн 3 жил гаруй хугацаанд 6-7 хувийн орчимд тогтвортой хадгалагдаж байна.

³² 2025 оны 8 дугаар сарын байдлаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт 25.4 хувьд хүрээд байна.

Зураг 38. Банкны системийн долларжилт



Зураг 39. Банкны системийн зээлийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн өсөлт 2025 оны 8 дугаар сард 23.6 хувьд хүрлээ. Өнгөрсөн онд хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил өндөр байж, банкны системээс бизнесийн салбаруудад олгосон зээл нэмэгдсэн нь нийт зээлийн өсөлт эрчимжихэд голлон нөлөөлж байв. Харин 2025 он гарснаар хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт илүү хурдтай саарч, банкны системийн зээлийн өсөлтийг буурууллаа. Тодруулбал, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор Мөнгөний бодлогын хорооноос макро зохистой бодлогын арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлсэн³³. Үүний зэрэгцээ, цалин, тэтгэврийн өсөлт саарсан нь иргэдийн зээлийн өсөлтийг хязгаарлав. Улмаар хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт сүүлийн 4 улирлын турш саарч, 2025 оны 6 дугаар сард 19.6 хувьд, 8 дугаар сард 18.1 хувьд хүрлээ. Нөгөө талдаа энэ онд хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил даруухан байгаагаас бизнесийн зээлийн өсөлт сүүлийн саруудад алгуур саарч, энэ оны 8 дугаар сард 28.6 хувьд хүрлээ. Эдийн засгийн салбаруудаар нь авч үзвэл, худалдаа, үйлчилгээ, барилга болон уул уурхайн салбарын зээл бизнесийн зээлийн өсөлтийг голлон тэтгэж байна. Нийт ипотекийн³⁴ зээлийн хувьд өсөлт нь 19.8 хувьд хүрч, энэ онд алгуур саарах хандлагатай байна.

Банкны системийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Тухайлбал, анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл энэ оны 8 дугаар сард 1.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 48.2 хувиар нэмэгдсэний 20.9 нэгж хувийг хэрэглээний зээлийн үлдэгдэл дангаар бүрдүүлэв. Түүнчлэн, чанаргүй зээлийн үлдэгдэл 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.5

³³ Үүнд, 2024 оны 7 дугаар сард хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 55 хувьд, 2025 оны 1 дүгээр сард 50 хувьд шинэчлэн тогтоох, 2025 оны 3 дугаар сард болон 6 дугаар саруудад тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлд холбогдох зохицуулалтуудыг хийв. Гэхдээ 7 дугаар сард МБХ-оос тэтгэврийн зээлийн хувьд гаргасан 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн, 6 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрийг хүчингүй болгож, тэтгэврийн зээлийг хуучин нөхцөлд нь шилжүүлсэн билээ.

³⁴ Ипотек+ИЗББ

хувиар өсөхөд хэрэглээний зээлийн үлдэгдэл 16.8 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ³⁵. Улмаар банкны системийн эргэн төлөлтийн доголдолтой зээлийн үлдэгдэл 4.1 их наяд төгрөгт хүрч, нийт зээлийн багцын 9.8 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 8. Мөнгөний тойм

(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)

Мөнгөний тойм	2020	2021	2022	2023	2024	2025			2026	2027	
	Q4	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	M8	Q4	Q4	
	Гүйцэтгэл					Төсөөлөл					
M2 мөнгө	24,220	27,863	29,665	37,624	43,334	41,483	42,999	44,286	45,924	47,919	50,523
M1 мөнгө	4,197	6,507	7,201	9,853	11,687	10,138	10,646	10,255	10,860	11,331	11,947
Банкнаас гадуурх мөнгө	753	847	831	906	978	916	937	949	1,038	1,083	1,142
Харилцах ₮	3,444	5,660	6,370	8,948	10,709	9,222	9,709	9,305	9,822	10,249	10,806
Бараг мөнгө	20,023	21,356	22,463	27,771	31,647	31,345	32,353	34,031	35,064	36,588	38,576
Хадгаламж ₮	13,398	15,039	12,607	17,125	22,060	22,137	22,574	23,026	24,514	25,579	26,969
Хадгаламж \$	4,642	3,973	4,910	4,999	4,856	4,964	5,380	5,426	5,783	6,035	6,363
Харилцах \$	1,983	2,345	4,947	5,647	4,730	4,245	4,400	5,579	4,767	4,974	5,244
Гадаад цэвэр актив	5,356	3,806	832	8,972	8,559	5,282	3,923	6,161	4,905	-2,158	-6,266
Төв банкны	6,273	4,892	2,434	11,140	15,473	13,587	13,294	15,299	14,022	8,807	5,977
Арилжааны банкны	-916	-1,085	-1,602	-1,661	-6,537	-7,922	-9,019	-8,787	-8,768	-10,616	-11,893
Дотоод цэвэр актив	18,864	24,057	28,833	28,652	34,775	36,202	39,076	38,125	41,019	50,078	56,789
Дотоодын цэвэр зээл	19,333	24,203	26,276	29,106	35,343	37,667	40,652	41,506	44,219	51,096	57,209
ЗГ-ын цэвэр зээл	-1,524	-471	-1,631	-4,323	-7,099	-6,956	-7,487	-7,236	-7,080	-7,671	-7,898
Төв банк	-1,114	-738	-1,775	-3,842	-6,088	-5,824	-5,687	-5,418	-6,313	-6,663	-6,815
Арилжааны банкууд	-411	267	143	-480	-1,010	-1,132	-1,800	-1,818	-767	-1,008	-1,084
ЗГ-аас авах авлага	1,690	1,734	1,675	1,558	2,780	2,735	2,904	2,940	3,237	2,996	2,921
ЗГ-ын хадгаламж	2,100	1,467	-1,531	-2,038	-3,790	-3,867	-4,704	-4,758	-4,004	-4,004	-4,004
Банк бусаас авах авлага	20,857	24,674	27,908	33,428	42,442	44,623	48,138	48,742	51,298	58,767	65,107
Үүнээс зээл	17,207	20,876	22,242	27,374	37,050	38,859	42,506	42,590	45,420	52,283	58,017
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	4,099	4,510	5,761	6,054	5,392	5,764	5,633	6,152	5,878	6,484	7,090
Төв банк											
Нөөц мөнгө	4,516	4,808	6,727	7,227	10,980	11,055	10,882	9,019	8,772	8,026	7,943
Гүйлгээнд гаргаан бэлэн мөнгө	991	1,106	1,089	1,152	1,222	1,190	1,202	1,212	1,318	1,375	1,450
Арилжааны банкуудын харилцах, хадгаламж	3,525	3,702	5,638	6,075	9,757	9,865	9,680	7,807	7,454	6,651	6,493
Гадаад цэвэр актив	7,117	5,509	4,732	11,140	15,473	13,587	13,294	15,299	14,019	8,804	5,974
Дотоод цэвэр актив	-2,601	-702	1,994	-3,913	-4,493	-2,532	-2,413	-6,280	-5,247	-778	1,970
Мөнгөний үзүүлэлтүүд											
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	17.5	13.8	6.5	26.8	15.2	10.9	3.7	6.5	6.0	4.3	5.4
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	-12.7	6.5	39.9	7.4	51.9	81.3	43.5	49.2	-20.1	-8.5	-1.0
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.42	5.80	4.41	5.21	3.95	3.75	3.95	4.91	5.24	5.97	6.36
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	-4.0	21.3	6.5	23.1	35.3	33.4	26.9	23.5	22.6	15.1	11.0
Зээл/ДНБ	0.54	0.55	0.48	0.46	0.51	0.53	0.56		0.55	0.56	0.57
Мөнгөний эргэлтийн хурд	1.53	1.56	1.82	1.83	1.86	1.97	1.95		1.97	2.14	2.24
Нэрлэсэн ДНБ /их наяд төгрөг/	37.5	43.6	53.9	70.4	80.7	81.5	83.9		90.6	102.8	113.2
Нэрлэсэн ДНБ-ий жилийн өсөлт (%)	-1.0	16.3	23.6	27.9	14.5	11.6	9.7		12.4	13.4	10.1

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

5.2. Орон сууцны зээлийн хөтөлбөр

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 99 дүгээр тогтоолд орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А-246 дугаар тушаалаар “Банканд ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зээл олгох түр журам”-ыг баталсан. Журмын хүрээнд хөтөлбөрт оролцогч талууд болох “МИК ОССК” ХХК болон банкуудтай 2024 оны 02 дугаар сарын 23-ны

³⁵ Нөгөө талдаа уул уурхайн салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл голлон буурав.

өдөр “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г шинэчлэн байгуулж хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанк өөрийн эзэмшлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын эргэн төлөлтөөр хэвийн үргэлжлүүлж байна.

Ипотекийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монголбанк, Засгийн газар, Хуримтлалын сан болон банкуудын эх үүсвэрээр нийт 9.9 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 137.4 мянган зээлдэгчид олгосон. 2025 оны хоёрдугаар улирлын байдлаар оны эхнээс 602.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 4.8 мянган өрхөд олгоод байна.

Зураг 40. Ипотекийн зээл олголт



Эх сурвалж: Монголбанк

Хөтөлбөрийн санхүүжилтийг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл болон Засгийн газрын хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгагдсан нийслэлийн хэт төвлөрлийг бууруулах бодлогын хүрээнд нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилах бодлогыг баримталж байна. Энэ хүрээнд орон нутагт олгох хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн, аймаг бүрд тэгш, хүртээмжтэй олгох чиглэлээр банкуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2025 оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар олгосон зээлийн 35 хувийг буюу 211.8 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт орон сууц худалдан авч буй 1.8 мянган өрх (нийт өрхийн 38 хувь)-д олголоо.

Түүнчлэн, Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, орон нутагт шилжин суурьшаж байгаа иргэдийг дэмжих ажлын хүрээнд Засгийн газраас жилийн 3 хувийн татаастай ипотекийн зээлийг хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд байр авч буй зээлдэгчид 2023 оноос олгож эхэлсэн билээ. Холбогдох гэрээний дагуу 3 хувийн татаастай зээлийг энэ оныг дуустал үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2025 оны 2 дугаар улирлын байдлаар оны эхнээс 51.7 тэрбум төгрөгийн зээлийг 442 өрхөд олгоод байна.

Мөн Засгийн газрын 2023 оны “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 483 дугаар тогтоолын хүрээнд хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх, амины орон сууцыг хөтөлбөрт түлхүү хамруулах зорилгоор Засгийн газартай хамтран ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд Монголбанкны 2016 оны А-295 дугаар


тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д холбогдох өөрчлөлтийг оруулсан бөгөөд ингэснээр хотын захын болон алслагдсан дүүргүүдэд баригдсан, эрчим хүчний хэмнэлттэй, ханаараа нийлсэн болон эгнээгээр баригдсан амины орон сууц худалдан авах иргэд хөтөлбөрийн зээлд хамрагдах боломжтой болоод байна. Тодруулбал, хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний хагаст нийт 1.3 тэрбум төгрөгийн зээлийг амины орон сууц худалдан авч буй зээлдэгчид олгоод байна.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны “Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 228 дугаар тогтоолоор Хуримтлалын санд 2025 онд төвлөрүүлэх 562.1 тэрбум төгрөгийг орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулахаар баталсан. Тогтоолын хүрээнд Засгийн газар болон Монголбанк хооронд 98/А/132/2025/195/0525/183 дугаартай “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан бөгөөд Хуримтлалын санд төвлөрөх эх үүсвэрийг орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулахаар ажиллаж байна. Монголбанк хөтөлбөрийн хүрээнд 2025 онд нийт 1.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг олгохоор тооцсон бөгөөд оны хоёрдугаар хагаст Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгөөр хөтөлбөрийг санхүүжүүлэхээр байна. Түүнчлэн, Монголбанкнаас хөдөө орон нутагт олгож буй зээлийг аймаг бүрд тэгш, хүртээмжтэй олгох, нийслэлд олгож буй зээлийг дахин төлөвлөлтийн бүс болон алслагдсан дүүргүүдэд түлхүү олгох чиглэлийг банкуудад хүргүүлэн ажиллаж байна.

5.3. Мөнгөний зах, хүүний түвшин

Банкуудын зээл олгох, хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ.

Зураг 41. Банк хоорондын захын арилжааны хүү




Эх сурвалж: Монголбанк


Мөнгөний Бодлогын Хороо (МБХ) 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит бус хуралдаанаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс харгалзан 13 хувь болон 18 хувьд хүргэхээр шийдвэрлэв. Түүнчлэн, МБХ-ны 2025 оны I улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 10 хувь байсныг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэв. Тус өөрчлөлтөөс үүдэн банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2025 оны II улирлын эцэст 12.0 нэгж хувь болж өмнөх оны мөн үеэс 1 нэгж хувиар өсөв.

Мөн 2025 оны эхний хагаст хийгдсэн банк хоорондын арилжааны 75.2 хувь нь бодлогын хүү дээр хийгдсэн бол 9.3 хувь бодлогын хүүнээс 0 хувиас 0.05 хувийн интервалд, 8.5 хувь нь -0.05 хувиас 0 хувийн интервалд харьяалагдаж байгаа нь банк хоорондын захын хүү бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалагдсан байгааг харуулж байна.

Зураг 42. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны хэмжээ, тэрбум ₮



Зураг 43. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны дундаж хугацаа, хоногоор



Эх сурвалж: Монголбанк

2025 оны II улиралд банк хоорондын төгрөгийн захад нийт 4,771.2 тэрбум төгрөгийн дүн бүхий 208 хэлцлийг 12.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, 11 хоногийн дундаж хугацаатайгаар байгуулжээ. Банк хоорондын төгрөгийн захад хийгдсэн нийт хэлцлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөг буюу 18.8 хувиар, өмнөх улирлаас 187.6 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар тус тус буурчээ. Түүнчлэн, нэг хэлцлийн дундаж хэмжээ 24.7 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 3.2 тэрбум төгрөгөөр буурав.

Хүснэгт 9. Хоёрдогч захын төгрөгийн арилжаанд эзлэх хэмжээ, хувиар

Үзүүлэлт	2024				2025	
	I	II	III	IV	I	II
Repo (ТБҮЦ)	38%	33%	45%	24%	38%	28%
ТБҮЦ-ны шууд арилжаа	48%	53%	36%	46%	41%	55%
Овернайт арилжаа	5%	10%	10%	7%	15%	9%
Банк хоорондын хадгаламж	9%	4%	9%	22%	7%	8%


Эх сурвалж: Монголбанк

Арилжааны бүтцийг авч үзвэл нийт банк хоорондын арилжаанд ТБҮЦ-ыг барьцаалан хийж байгаа репо хэлцэл 28%, ТБҮЦ-ны шууд хэлцэл 55%, овернайт хэлцэл 9%, банк хоорондын хадгаламж 8%-ийг тус тус бүрдүүлж байна. Банк хоорондын ТБҮЦ-ны шууд болон репо хэлцэл нь харилцагчийн эрсдэл багатай тул нийт арилжаанд давамгайлж байна).

5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны II улирлын эцэст 3,580.94 төгрөг болж, оны эхнээс 4.69 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.91 хувиар тус тус сулрав. Ингэхдээ, 2025 оны эхний хагас жилд төгрөгийн ам.доллартой харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.40 хувиар суларч, 0.06 хувиар чангарсан бөгөөд өдрийн дундаж хэлбэлзэл 0.04 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.04 нэгж хувиар өссөн байна.

Зураг 44. Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж




Зураг 45. Төгрөгийн ам.доллартой харьцах Монголбанкнаас зарласан ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн, олон улсын зах зээл дээрх нүүрсний үнийн бууралт нь манай улсын экспортын орлогыг буурахад голлон нөлөөлсөн бөгөөд зах зээл дэх валютын нийлүүлэлтийг бууруулж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрахад нөлөөлөв. Тодруулбал, нүүрсний үнэ 2024 оны төгсгөлд тонн тутамд 105.08 ам.доллар байсан бол 2025 оны эхний хагаст 86.55 ам.доллар болж оны эхнээс 17.6 хувиар буурсан байна. Улмаар тус хугацаанд банкны системээр дамжин Монгол улсад орох гадаад валютын урсгал гарах урсгалаас 293.8 сая ам.доллаароор бага байв. Ингэснээр Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2025 оны эхний хагас жилд 462.4 сая ам.долларын алдагдалтай гарсан бол гадаад валютын улсын нөөц 5,198.5 сая ам.долларт хүрч, 2024 оны эцсээс 303.7 сая ам.доллаароор буурсан байна.

Зураг 46. Гадаад валютын улсын нөөц, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк


Мөн гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк 2024 онд 16.5 тонн үнэт металл худалдан авсан бол 2025 оны эхний хагаст нийт 5.9 тонн үнэт металл худалдан аваад байна. Ингэснээр гадаад валютын улсын нөөц нэмэгдэх бөгөөд олон нийтийн төгрөгт итгэх итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд эергээр нөлөөлөх зэрэг ач холбогдолтой байдаг. Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримталдаг бөгөөд богино хугацааны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцон ажилладаг. Үүний хүрээнд Монголбанк 2025 оны эхний хагас жилд цэвэр дүнгээр 1,853.9 сая ам.долларыг валютын захад нийлүүлсэн байна.

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗЭЭЛ


6.1. Төлбөрийн тэнцэл

2025 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 74 хувиар өсөж, 1,662 сая ам.долларт, санхүүгийн дансны ашиг 78 хувиар өсөж 1,642 сая ам.долларт тус тус хүрснээр нийт төлбөрийн тэнцэл 462 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оноос 405 сая ам.доллаароор өссөн дүнгэй байна.

Зураг 47. Төлбөрийн тэнцэл



Зураг 48. Урсгал ба хөрөнгийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 10. Төлбөрийн тэнцэл, 2025 оны эхний 6 сараар, сая ам.доллар

	Эхний 6 сар		Өөрчлөлт	
	2024	2025	Дүн	Хувь
I. Урсгал данс	-957	-1,662	-705	74%
а. Бараа	1,942	853	-1090	-56%
б. Үйлчилгээ	-1,692	-1,481	211	-12%
в. Анхдагч орлого	-1,451	-1,206	245	-17%
г. Хоёрдогч орлого	243	172	-71	-29%
II. Хөрөнгийн данс	78	51	-27	-35%
III. Санхүүгийн данс	-921	-1,642	-721	78%
а. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	-1,632	-1,013	619	-38%
1. Актив	-40	-68	-28	69%
2. Пассив	1,592	945	-647	-41%
б. Багцын хөрөнгө оруулалт	-206	-77	129	-63%
1. Актив	27	44	17	62%
2. Пассив	233	121	-112	-48%
в. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	0	15	15	-3897%
1. Актив	2	3	1	37%
2. Пассив	3	-12	-15	-542%
г. Бусад хөрөнгө оруулалт	917	-567	-1484	-162%
1. Актив	235	451	215	91%
2. Пассив	-682	1,018	1700	-249%
III. Алдаа ба орхигдуулаг	-99	-494	-394	398%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-57	-462	-405	707%
IV. Албан нөөцийн өөрчлөлт	-57	-462	-405	707%


Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн данс

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2025 оны эхний 6 сард 1,611 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 732 сая ам.доллароор өссөн. Үүнд барааны дансны ашиг 1,090 сая ам.доллароор, хоёрдогч орлогын дансны ашиг 71 сая ам.доллароор тус тус буурсан нь голлох нөлөөг үзүүлэв.

Урсгал дансны алдагдал нь дотоодын эдийн засгийн сэргэлт, уул уурхайн бүтээн байгуулалтууд болон импортын өсөлтөөс шалтгаалж 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байсан. Энэ үзүүлэлт 2014 оноос барааны худалдаа ашигтай гарч эхэлснээр 2016 онд 6 хувьд хүрсэн. 2018 онд импортын өсөлттэй холбоотойгоор барааны дансны ашиг буурснаар 33 хувьд хүрсэн бол 2020 онд импорт эргэн буурснаар 10 хувьд тус тус хүрсэн. 2023 онд уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр урсгал дансны ашиг ДНБ-ий 1 хувьд хүрэв. Гэвч 2025 онд нүүрсний экспорт буурсантай

Зураг 49. Урсгал тэнцэл/Нэрлэсэн ДНБ



Эх сурвалж: Монголбанк, YCX

холбоотойгоор урсгал дансны алдагдал ДНБ-ий 14 хувийг эзэлж байна.


Гадаад худалдааны эргэлт буурав. 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны дансны нийт эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,274 сая ам.доллараар буурч 11,670 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 16%-аар буюу 1,182 сая ам.доллараар, импорт 2%-аар буюу 92 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Улмаар барааны данс 853 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1,090 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Чулуун нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж экспорт өмнөх үеэс 2,118 сая ам.доллараар буурсан. Тодруулбал, нүүрсний тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 318 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,800 сая ам.доллараар буурсан.

Импорт өмнөх оны мөн үеэс 92 сая ам.доллар буюу 2%-иар буурахад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 87 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 77 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орж 39 сая ам.доллараар буурсан нь нөлөөлсөн.

Харин хэрэглээний бүтээгдэхүүний хувьд 23%-иар буюу 352 сая ам.доллараар өссөн байна. Үүний 259 сая ам.долларыг авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт эзэлж байна.

Зураг 50. Барааны гадаад худалдаа




Эх сурвалж: Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал буурав. Үйлчилгээний дансны алдагдал 2025 оны эхний 6 дугаар сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 12%-иар буюу 211 сая ам.доллараар буурч 1,481 сая ам.долларт хүрсэн.

Ийнхүү алдагдал буурахад өмнөх оны мөн үетэй харьцуулахад, тээврийн зардал 105 сая ам.доллараар, барилгын үйлчилгээний зардал 75 сая ам.доллараар, бизнесийн бусад үйлчилгээний зардал 58 сая ам.доллараар буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 51. Үйлчилгээний гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Анхдагч орлогын дансны алдагдал буурсан. Анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 17%-иар буюу 245 сая ам.доллараар буурч 1,206 сая ам.долларт хүрсэн нь дахин хөрөнгө оруулалтын зардлын бууралттай холбоотой байна.

Санхүүгийн данс

Санхүүгийн данс 1,642 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 78%-иар өссөн дүнтэй байна. Үүнд бусад хөрөнгө оруулалтын дансны үзүүлэлт өмнөх оноос 1,484 сая ам.доллароор сайжирсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 52. Санхүүгийн данс



Зураг 53. Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын албан нөөц. Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 462 сая ам.долларын алдагдалтай гарснаар гадаад валютын албан нөөц 6 дугаар сарын эцэст 5,206 сая ам.долларт буюу валютын төлбөртэй импортын гурван сарын дунджаар тооцсон барааны 3.9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрээд байна.

6.2. Хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны 1 дүгээр улирлын эцэст -45,167.5 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 45,167 сая ам.доллароор өндөр байна.

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат бусд оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 9,361.5 сая ам.доллар байна. Үүний 53%-ийг гадаад валютын албан нөөц, 28%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 54,529.0 сая ам.долларт хүрэв. Үүний 62%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 7%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 30%-ийг бусад хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 11. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2025 оны 1-р улирал, сая ам.доллар

А. ГАДААД АКТИВ	9,361.5	Б. ГАДААД ПАССИВ	54,529.0
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	1,124.4	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	33,874.3
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	805.3	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	16,262.3
1.2 Бусад хөрөнгө	319.1	6.2 Бусад хөрөнгө	17,612.1
2. Багцын хөрөнгө оруулалт	571	7. Багцын хөрөнгө оруулалт	4,078
2.1 Хөрөнгийн хувьцаа	456.5	7.1 Хөрөнгийн хувьцаа	212.9
2.2 Өрийн бичиг	114.5	7.2 Өрийн бичиг	3,864.6
3. Санхүүгийн дериватив	6.4	8. Санхүүгийн дериватив	11.2
4. Бусад хөрөнгө оруулалт	2,663.8	9. Бусад хөрөнгө оруулалт	16,565.9
4.1 Худалдааны зээл	285.4	9.1 Худалдааны зээл	1,285.1
4.2 Эзэл	106.0	9.2 Эзэл	14,084.7
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	109.9
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	6,293.7
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	61.8	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	1,932.4
4.2.4 Аж ахуйн нэгж	44.2	9.2.4 Аж ахуйн нэгж	5,748.7
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	2,272.4	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	1,039.5
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	156.6
5. Нөөц актив	4,996	В. ПОЗИЦ	-45,167.5
5.1 Мөнгөжсөн алт	705.3	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-32,750.0
5.2 Эзэлжих тусгай эрх	89.8	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-3,506.6
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	7.4	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	-4.8
5.4 Бэлэн валют ба харилцах	2,578.1	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-13,902.1
5.5 Үнэт цаас	1,615.4	14. Нөөц актив	4,996.0
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0		
5.7 Бусад нөөц актив	0.0		

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 48%-ийг буюу 16,262.3 сая ам.долларыг хувь нийлүүлэгчдийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 52% буюу 17,612.1 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

6.3 Монгол Улсын гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2025 оны 1 дүгээр улирлын эцэст 38,042.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн үлдэгдлээс 8 хувиар буюу 2,958.7 сая ам.доллараар нэмэгдсэн. Энэхүү өсөлтийг банкуудын урт хугацаат зээл болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн өсөлт тайлбарлаж байна.

Хүснэгт 12. Гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллар

Үзүүлэлт	3/31/2024	3/31/2025	Өөрч.ю.п	
			Дүн	Хувь
Нийт гадаад өр	35,083.9	38,042.6	2,958.7	8.4%
I. Засгийн газар	8,197.9	8,634.1	436.2	5.3%
II. Төв банк	1,754.0	1,198.9	-555.1	-31.6%
III. Банк	1,516.6	2,936.6	1,420.0	93.6%
Богино хугацаат	178.4	201.1	22.7	12.7%
Урт хугацаат	1,338.2	2,735.5	1,397.3	104.4%
IV. Бусад сектор	7,917.7	7,661.0	-256.7	-3.2%
Богино хугацаат	1,494.6	1,684.4	189.8	12.7%
Урт хугацаат	6,423.1	5,976.6	-446.5	-7.0%
V. Хөрөнгө оруулагч зээл	15,697.7	17,612.1	1,914.4	12.2%

Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын гадаад өр 436.2 сая ам.доллаароор нэмэгдэж 8,634.1 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүнд олон улсын зах зээлд шинээр арилжсан бондуудын ашиглалт болон үнийн өөрчлөлт нөлөөлсөн.

Төв банкны гадаад өр 555.1 сая ам.доллаароор буурч 1,198.9 сая ам.долларт хүрсэн нь Хятадын Ардын банктай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээл өнгөрсөн оны мөн үеэс 3,077.7 сая ам.доллаароор нэмэгдэж 28,209.7 сая ам.доллар болсон байна.

Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2025 оны 1 дүгээр улирлын эцэст 2,936.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 94%-иар буюу 1,420 сая ам.доллаароор өсжээ. Гадаад өрийн 63%-ийг урт хугацаат зээл, 30%-ийг бонд өрийн бичиг, 4%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг, үлдсэн 3%-ийг богино хугацаат зээл тус тус бүрдүүлж байна.

Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өрийн үлдэгдэл 1,657.7 сая ам.доллаароор нэмэгдэж 25,273.1 сая ам.долларт хүрэв. Үүний 70% буюу 17,612.1 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгжүүдийн гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаатай, ихэнх тохиолдолд хүүгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдаг.

VII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

7.1. Санхүүгийн салбар

Монгол Улсын санхүүгийн системд 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 12 банк, 573 банк бус санхүүгийн байгууллага, 177 хадгаламж зээлийн хоршоо, 20 даатгалын компани, 62 даатгалын зуучлагч, 29 даатгалын хохирол үнэлэгч компани тус тус үйл ажиллагаа явуулж байна. Манай санхүүгийн систем нь банк төвтэй боловч банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд өргөжин тэлж

байна. Тухайлбал, 2025 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн системийн нийт актив хөрөнгийн 11.1 хувь, нийт ашгийн 38.2 хувь, нийт өөрийн хөрөнгийн 37.6 хувь нь банкнаас бусад санхүүгийн салбарт ногдож байна.

Хүснэгт 13. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлтүүд	Банк		ББСБ		ХЗХ		Даатгал	
	Дүн	Эзлэх %	Дүн	Эзлэх %	Дүн	Эзлэх %	Дүн	Эзлэх %
Нийт хөрөнгө	72,599.6	88.9%	7,983.4	9.8%	376.9	0.5%	703.7	0.9%
Өр төлбөр	64,994.2	93.6%	3,758.0	5.4%	298.77	0.4%	420.8	0.6%
Өөрийн хөрөнгө	7,605.5	62.4%	4,225.3	34.7%	78.1	0.6%	282.9	2.3%
Зээлийн өрийн үлдэгдэл	42,224.4	85.8%	6,674.9	13.6%	294.8	0.6%	-	-
Чанаргүй зээл	2,069.5	79.9%	514	19.8%	7.0	0.3%	-	-
Тайлант үеийн ашиг	803.2	61.8%	457.7	35.2%	8.2	0.6%	30.1	2.3%
Даатгалын хураамжийн орлого							250.6	
Даатгалын нөхөн төлбөр							88.6	

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Шигтгээ 4. “СТОУС 9” стандартын хэрэгжилт


Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, эрсдэлийн санг тооцоолох тухай “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 9: Санхүүгийн хэрэгсэл” стандартыг олон улсад 2018 оноос мөрдөж эхэлсэн.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкнууд 2018 оноос хөндлөнгийн аудитаар баталгаажих жилийн эцсийн санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж эхэлсэн бөгөөд Банкны тухай хуулийн 2021 оны нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулалтын дагуу системд нөлөө бүхий банкнууд Санхүүгийн Зохицуулах Хороонд санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу тайлагнадаг болсон.


Банкны салбарт “СТОУС 9” стандартыг нэвтрүүлснээр эрсдэлийн санг тооцохдоо зээлийн эрсдэлийг үүсэхээс нь өмнө, ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх төсөөлөл, таамаглалыг үндэслэн тооцоолдог тул банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах, санхүүгийн тайланг илүү ил тод, бодитой гаргах, хөрөнгө оруулагч нарын итгэлийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлээс хөрөнгө татахад эерэг нөлөөтэй.

Иймд Монголбанк дээр дурдсан одоогийн нөхцөл байдал, “СТОУС 9” стандартыг хэрэгжүүлэх ач холбогдлыг харгалзан үзсэний үндсэн дээр уг стандартыг банкнуудад нэгдсэн байдлаар нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Монголбанк олон улсын зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, банкнуудын “СТОУС 9” стандартыг нэвтрүүлэх бэлэн байдлыг судлах, Монголбанкны хянан шалгагч нарыг чадавхжуулах, сургалтыг зохион байгуулах, банкнуудтай уулзалт зохион байгуулах, санал солилцох, “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг “СТОУС 9” стандартыг нийцүүлэн шинэчлэх, “Банканд “СТОУС 9” стандартыг хэрэгжүүлэх журам”-ыг боловсруулах ажлуудыг гүйцэтгээд байна.

Зураг 55. ББСБ-ын хөрөнгө ба зээлийн дүн, жилийн өсөлтийн хувь



Зураг 56. ББСБ-ын орлого, зарлага болон ашигийн дүн




Эх сурвалж: СЗХ


7.2.2 Үнэт цаасны салбар

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөж, 12.2 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий³⁶ 15.2 хувьтай тэнцэж байна. Харин үнэт цаасны арилжааны дүн 503.9 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 43.4 хувиар буурсан үзүүлэлт байна.

Зураг 57. Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн жилийн өсөлтийн хувь



Зураг 58. Даатгалын салбарын нийт хөрөнгө болон нөөц сан, жилийн өсөлт хувь



Эх сурвалж: СЗХ

Үүний 430.2 тэрбум төгрөгийн арилжаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 73.7 тэрбум төгрөгийн арилжаа нь хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна. Түүнчлэн, Монгол Улсын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн утга

³⁶ 2024 оны нэрлэсэн ДНБ

2025 оны 6 дугаар сард 49,246.2 нэгжид хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувиар өслөө.

7.2.3 Даатгалын салбар


Энэ оны 2 дугаар улирлын байдлаар 20 даатгалын компани, 62 даатгалын зуучлагч, 1093 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 703.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өссөн бол нөөц сангийн нийт дүн 337.5 тэрбум төгрөгт хүрэв. Даатгалын нийт хураамж 250.6 тэрбум төгрөг, үүний 96.7 хувийг ердийн даатгал, 2.0 хувийг давхар даатгал, 1.3 хувийг урт хугацааны даатгалын хураамж тус тус бүрдүүлж байна.

Харин даатгалын нийт нөхөн төлбөр 88.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.3 хувиар өсөв. Салбарын нийт цэвэр ашиг 2025 оны 2 дугаар улиралд 30.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өслөө. Мөн хохирлын харьцаа³⁷ ердийн даатгалын компаниудын хувьд 51.0 хувь, урт хугацааны даатгалын компаниудын хувьд 73.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Харин үйл ажиллагааны зардлыг нэмж тооцсон хохирлын харьцаа буюу хосолсон харьцаа нь харгалзан 105.2 хувь болон 140.0 хувьтай байна. Энэ нь даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал харьцангуй өндөр байгааг харуулж байна.


7.2.4 Хадгаламж, зээлийн хоршооны салбар

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар 177 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) үйл ажиллагаа явуулж байна. Тус салбарын голлох үзүүлэлтүүдийг авч үзвэл нийт хөрөнгө 376.9 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 294.8 тэрбум төгрөг, нийт хадгаламж 259.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс харгалзан 15.0 хувь, 21.1 хувь болон 14.7 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Тайлант улиралд ХЗХ-дын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 39.7 хувиар өсөж, 8.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 59. ХЗХ-дын нийт хадгаламж ба ашигийн дүн



Зураг 60. ХЗХ-дын нийт хөрөнгө, зээлийн дүн ба жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: СЗХ

³⁷ Нөхөн төлбөрийн зардал, орлогод тооцсон хураамжийн харьцаа

Түүнчлэн, нийт зээлийн үлдэгдлийн 93.0 хувь буюу 274.2 тэрбум төгрөг нь хэвийн, 4.6 хувь буюу 13.6 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн, 2.4 хувь буюу 7.0 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд байна.

7.2.5 Банкны бус санхүүгийн салбарт тулгамдаж буй эрсдэл

ББСБ-уудын өр төлбөрийн хэмжээ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх хандлагатай байгаа ба 2025 оны хоёрдугаар улиралд 1.2 их наяд төгрөгөөр буюу өмнөх жилээс 45.6 хувиар өсөж, 3.8 их наяд төгрөгт хүрээд байна. Энэхүү өсөлтөд ББСБ-аас гаргасан өрийн бичиг, дотоодын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өсөлт голлон нөлөөлөв. Өр төлбөрийн өсөлтийн 12.3 нэгж хувийг дотоодын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөгийн өсөлт, 10.6 нэгж хувийг итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өсөлт, 8.8 нэгж хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөгийн өсөлт, 8.0 нэгж хувийг ББСБ-аас гаргасан өрийн бичгийн өсөлт тус тус бүрдүүлж байна. ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг 2025 оны 6 дугаар сарын эцэст жилийн 32.3 хувиар нэмэгдэж 1.1 их наяд төгрөгт хүрэв. Үүний 58.8 хувийг иргэдээс татан төвлөрүүлжээ.

ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээгээр эх үүсвэр татах сэдлийг бууруулах зорилгоор 2025 оны 3 дугаар сард Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа 80 хувиас хэтрэхгүй байсныг 60 хувь болгон бууруулсны зэрэгцээ итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэгч ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөс 10 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.


Итгэлцлийн үйлчилгээ нь банкны хадгаламжтай ижил төрлийн шинж чанартай, харьцангуй өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн юм. Гэвч банкны салбартай харьцуулахад ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээ авагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сул, итгэлцлийн үйлчилгээ нь хадгаламжийн даатгалд албан журмаар хамрагддаггүй зэргээс шалтгаалан эдийн засаг, санхүүгийн зах зээлд хямрал тохиоход чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдэх, цаашлаад иргэдээс татан төвлөрүүлсэн итгэлцлийн үйлчилгээний өглөгийг барагдуулахад хүндрэл үүсэх эрсдэлтэй юм.

Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан ББСБ-уудын зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өсч, 2024 оны эцэст 987.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх жилээс 538.9 тэрбум төгрөгөөр буюу 120.0 хувиар өсөв. Ийнхүү банкны салбараас ББСБ-уудад зээл олгох нь банк болон ББСБ-ын салбарын харилцан хамаарлын эрсдэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Монголбанкнаас банкны салбарын хэрэглээний зээлд мөрдүүлж буй макро зохистой бодлогын нөлөөллийг сулруулж, санхүүгийн эрсдэл нэг салбараас нөгөөд шилжих эрсдэлийг нэмэгдүүлэв. Иймд Монголбанк энэ оны 4 дүгээр сард арилжааны банкнаас ББСБ, ХЗХ, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэгч зэрэг этгээдэд зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт олгохгүй, тэдгээрээс аливаа актив хөрөнгө худалдан авахгүй байх, олгосон байгаа санхүүжилтийн хугацааг сунгахгүйгээр эргүүлэн төлүүлэх зохицуулалт хийсэн. Түүнчлэн, 2025 оны 3 дугаар сард СЗХ-ноос ББСБ-ууд дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй

байхаар шийдвэрлэв. Эдгээр бодлогын арга хэмжээний нөлөөгөөр 2025 оны 2 дугаар улиралд ББСБ-аас дотоодын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөгийн хэмжээ 114.6 тэрбум төгрөгөөр буураад байна.

Түүнчлэн, ББСБ-ын бусдаас татсан эх үүсвэрийн хэмжээ огцом нэмэгдэхэд ББСБ-уудын гаргасан өрийн бичиг, үүн дотроо хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэмжээ огцом өссөн нь нөлөөлөв. ББСБ-уудаас гаргасан ХБҮЦ-ны дүн 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 215 тэрбум төгрөгт хүрч өсөөд байна. Улмаар ББСБ-ууд өрийн бичиг гарган бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх байдлыг зохистой хэмжээнд хязгаарлах зорилгоор ББСБ-аас гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа нь 50 хувиас хэтрэхгүй байсныг 30 хувь болгон бууруулах шийдвэрийг СЗХ-ноос 2025 оны 3 дугаар сард гаргасан.

Зураг 61. ББСБ-ын өр төлбөрийн задаргаа, Зураг 62. ББСБ-ын нийт зээлийн чанар жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: СЗХ

2025 оны 3 дугаар сарын байдлаар ББСБ-уудын дотоодын банкуудаас татсан санхүүжилтыг авч үзвэл зээлийн жигнэсэн дундаж хүү 19.1 хувь, өрийн бичгийн дундаж хүү 18.2 хувь, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны дундаж хүү 17.9 хувь байна. Ийнхүү ББСБ-ууд өндөр хүүгээр эх үүсвэр татаж байгаа нь банкуудын эх үүсвэрийн зардал өндөр байхад нөлөөлж, цаашлаад зээлийн хүү буурахгүй байх хүчин зүйл болж байна.


2025 оны 2 дугаар улиралд ББСБ-уудын нийт зээлийн үлдэгдлийн 87.3 хувийг буюу 5.8 их наяд төгрөгийг хэвийн зээл, 5.0 хувийг буюу 332.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.7 хувийг буюу 513.9 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүлж байна. Нийт зээлд эзлэх анхаарал хандуулах зээл болон чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс харгалзан 1.4 нэгж хувь болон 1.8 нэгж хувиар тус тус өссөн байна.

7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв


Монгол Улсын банкны системд 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 12 банк нийт 1,400 салбар, тооцооны төвтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 431 салбар, тооцооны төв (30.8%), орон нутагт 963 салбар, тооцооны төв (68.8%), гадаад улсад 6 төлөөлөгчийн газар (0.4%) ажиллаж байна.

Тайлант улиралд Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 12.1 их наяд төгрөг байгаагаас хөрөнгийн биржид бүртгэлтэй банкнуудын зах зээлийн үнэлгээ 5.2 их наяд төгрөг буюу нийт хөрөнгийн зах зээлийн 42.9 хувийг дангаараа бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан үзүүлэлтэй байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй банкнуудаас 2024 оны жилийн эцсийн байдлаарх цэвэр ашгаас нийт 651.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2025 онд хуваарилсан нь өмнөх онтой харьцуулахад 197.2 тэрбум төгрөг буюу 43.4 хувиар өссөн байна.

Зураг 63. Банкнуудын зах зээлийн үнэлгээ (их наяд төгрөг)



Зураг 64. Банкнуудын нэгж хувьцаанд ногдох ашгийн өгөөж (хувиар)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


Банкны системийн нийт актив

Банкны системийн нийт актив 2025 оны 2 дугаар улиралд 72.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 их наяд төгрөгөөр (16.8%) өссөн бөгөөд үүний 85.6 хувийг 8.9 их наяд төгрөгийн зээлийн өсөлт³⁸ дангаараа бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкнуудын Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 1.4 их наяд төгрөгөөр (14.0%) буурч, нийт активын 11.9 хувийг бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө мөн дүнгээр өссөнөөр нийт активын 19.8 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Харин Засгийн газрын үнэт цаас дахь хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад тогтвортой түвшинд хадгалагдсан хэвээр байна.

³⁸ Зээлийн эрсдэлийн сангаар цэвэршүүлсний дараах цэвэр дүнгээр

Зураг 65. Активын бүтэц (их наяд төгрөг) Зураг 66. Активын өөрчлөлт (их наяд төгрөг)




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үйл ажиллагаа

Банкны системийн нийт зээл 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 42.2 их наяд төгрөгт (эрсдэлийн сангаар цэвршүүлээгүй дүн) хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буюу 8.9 их наяд төгрөгөөр өссөн байна. Банкны системийн хэмжээнд нийт зээлийн 91.5 хувийг хэвийн зээл, 4.1 хувийг анхаарал хандуулах зээл, 4.4 хувийг чанаргүй зээл бүрдүүлж, нийт 2.0 их наяд төгрөгийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зураг 67. Зээлийн бүтэц (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн нийт зээлийн 26.8 хувийн жилийн өсөлтийн нөлөөллийг зээлдэгчдийн төрлөөр авч үзвэл 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн өсөлтийн 11.2 нэгж хувийг байгууллагын зээл, 15.6 нэгж хувийг иргэдийн зээл тус тус бүрдүүлж байна.


Зураг 68. Зээлийн өөрчлөлтийн задаргаа (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн өөрчлөлтийг эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл барилгын салбарын зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлтийн хувиар хамгийн өндөр буюу 37.3 хувийн өсөлтийг үзүүлсэн бол өсөлтийн абсолют дүнгээр иргэдийн зээл хамгийн өндөр хэмжээгээр буюу 4.0 их наяд төгрөгөөр өссөн байна.


Зураг 69. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг) Зураг 70. Иргэдийн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк

Иргэдэд олгосон зээлийн өөрчлөлтийг зориулалтаар нь авч үзвэл Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хүүгийн татаастай зээлийн хөтөлбөрүүдийн үр дүнд “Өрхийн үйлдвэрлэл” ангилалтай зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамгийн өндөр буюу 45.0 хувийн өсөлтийг үзүүлж 5.4 их наяд төгрөгт хүрсэн бол цалингийн зээл 27.4 хувь болон хэрэглээний зээл 20.0 хувиар тус тус өссөн байна. Харин иргэдийн зээлийн багц дахь малчны зээл 10.4 хувиар буурч 1.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зураг 71. Эдийн засгийн голлох салбаруудын анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн харьцаа



Зураг 72. Иргэдийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн чанаргүй зээл 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 4.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Банкны системийн нийт зээлийн чанарыг эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл боловсруулах үйлдвэрлэл болон барилгын салбаруудад олгосон анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл хамгийн өндөр буюу харгалзан 469.8 тэрбум төгрөг (17.8%) болон 487.1 тэрбум төгрөг (17.0%) байна. Уул уурхайн салбарт олгосон анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 128.0 тэрбум төгрөгөөр буурсан нь эдгээр салбарууд дахь чанаргүй зээл эргэн төлөгдсөн, ангилал дээшилсэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөлөл байна.


Иргэдийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийг зориулалтаар нь авч үзвэл цалингийн болон хэрэглээний зээлийн хувьд хамгийн өндөр буюу харгалзан 720.1 тэрбум төгрөг (10.5%) болон 106.4 тэрбум төгрөг (11.9%) байна. Харин өрхийн үйлдвэрлэлд олгосон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар буурсан байгаа нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Хоршооны гишүүн малчны зээлийн хөтөлбөр” нөлөөлсөн байна.

Банкны системийн нийт эх үүсвэр


Банкны системийн нийт эх үүсвэр 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 65.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.3 их наяд төгрөгөөр (14.3%) өссөн байна. Үүний 65.6 хувийг 6.1 их наяд төгрөгийн Хадгаламжийн өсөлт дангаар бүрдүүлж байна.

Банкны системийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 их наяд төгрөгөөр (12.8%) буурснаар нийт эх үүсвэрийн 22.0 хувьд хүрсэн бол банк, санхүүгийн байгууллаас татсан эх үүсвэр 3.4 их наяд төгрөгөөр (31.8%) өсөж, нийт эх үүсвэрийн 21.7 хувьд хүрсэн байна.

Зураг 73. Эх үүсвэрийн бүтэц
(их наяд төгрөг)



Зураг 74. Эх үүсвэрийн үлдэгдэл, өөрчлөлт (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк


Эх үүсвэр, валютын төрлөөр

Банкны системийн нийт эх үүсвэрийг бүтцийн хувьд авч үзвэл харилцах дансны төвлөрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 нэгж хувиар буурсан бол хадгаламжийн данс болон банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн төвлөрөл 3.3 болон 2.4 нэгж хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин эх үүсвэрийн төвлөрлийг валютын төрлөөр нь авч үзвэл гадаад валютын эх үүсвэрийн хувийн жин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 нэгж хувиар өссөн байна.

Зураг 75. Эх үүсвэрийн бүтэц өөрчлөлт
(их наяд төгрөг)



Зураг 76. Эх үүсвэрийн бүтэц өөрчлөлт, валютаар
(их наяд төгрөг)




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн гадаад валютын эх үүсвэрийн өөрчлөлтийг 2016 оноос хойш авч үзвэл 2020 оны эцэс хүртэл нийт 25.1 их наяд төгрөгөөр өссөний 76.0 хувийг гадаад валютын ханшийн нөлөөгүй өөрчлөлт бүрдүүлж байсан бол Ковид-19 цар тахлын дараа буюу 2021 оноос хойш гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө нэмэгдэж, тайлант оны 2 дугаар улирлын байдлаар гадаад валютын эх үүсвэрийн өөрчлөлтийн 83.5 хувьд хүрсэн нь ам.долларын эсрэг төгрөгийн ханш 2016 онтой харьцуулахад 46.3 хувиар суларсантай холбоотой байна. Харин тайлант онд гадаад валютын эх үүсвэр 21.4 их наяд

төгрөгөөр өссөний дийлэнх хэсгийг гадаад валютын ханшийн нөлөөгүй өөрчлөлт (11.2 их наяд төгрөг) бүрдүүлж³⁹, гадаад валютын ханшийн нөлөөтэй өөрчлөлтөөс 1.0 их наяд төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна.

Зураг 77. Гадаад валютын эх үүсвэрийн ханшийн нөлөөтэй өөрчлөлт (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 5. Банкны зохистой засаглалын түүхэн хөгжил ба шинэчлэлийн үе шат

Компанийн засаглалын асуудал анх 16–17 дугаар зуунд “Левант компани”, “Зүүн Энэтхэг компани”, “Хадсоны булан компани” зэрэг хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын бүтэцтэй компаниуд үүсэх үед бий болсон гэж судлаачид үздэг. Гэвч 1970–1980 оны үед АНУ-ын компаниуд хурдацтай өсч, гүйцэтгэх удирдлагын нөлөө хэт давамгайлснаар компанийн засаглалын зохицуулалт шаардлагатай болсон. Энэ хугацаанд компанийн засаглалыг хууль, журмаар тодорхойлж, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож байгаагүй бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт сул байснаас хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх асуудал үүсэж байв. Үүний үр дүнд АНУ-ын “Үнэт цаасны арилжааны хороо”-ноос хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг нийтэлдэг байх, аудитын, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодыг байгуулах зэрэг шаардлагуудыг тавьж эхэлсэн нь компанийн засаглалын зохистой тогтолцоог бүрдүүлэх эхлэл болсон гэж үздэг.

Монгол Улсад 1991 оноос Төв банк болон хувь нийлүүлэгчдийн хөрөнгөөр байгуулагдсан арилжааны банкуудын хоёр шатлалт тогтолцоо үүссэнээр Монголбанк нь банкуудын үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгах үүрэгтэй болсон.

Банкны салбарын хууль, эрх зүйн орчин сайжирч, банканд тавих хяналт, шалгалтын үйл ажиллагаа олон улсын жишиг стандартад нийцтэй байсан хэдий ч ихэнх тохиолдолд банканд зохистой засаглал алдагдсанаас банк төлбөрийн чадваргүй болж татан буугдаж байсан. Энэ үйл явдал, сургамж нь банкны салбарт дараагийн реформыг

39 Гадаад валютын ханшийн нөлөөгүй өөрчлөлт:

2025.I улиралд 5.3 их наяд төгрөг, 2025.II улиралд 5.9 их наяд төгрөг, нийт 11.2 их наяд төгрөг;


Гадаад валютын ханшийн нөлөөтэй өөрчлөлт:

2025.I улиралд 4.8 их наяд төгрөг, 2025.II улиралд 5.5 их наяд төгрөг, нийт 10.2 их наяд төгрөг;

эхлүүлэх, банкнуудын зохистой засаглалын сайжруулах шийдвэртэй алхмыг хийх шаардлагатай болсон.

Монголбанк 2006 онд банк, санхүүгийн салбарын “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг анхлан нэвтрүүлж холбогдох хууль эрх, зүйн зохицуулалт, нөхцөл, шаардлагыг үндэслэн тасралтгүй журмын зохицуулалтыг сайжруулсаар ирсэн.

Зураг 78. Банкны засаглалын шинэчлэл, сорилт, түүхэн он жилүүд



2018 оны Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулалтаар дараах зохицуулалтууд тусгагдсан:

- Банкны эцсийн өмчлөгч, холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг илүү нарийвчлан тайлагнах;
- ТУЗ-ийн гишүүдийн банканд хүлээсэн үүрэг, төлбөр нь анхаарал хандуулах болон чанаргүй ангилалд орсон тохиолдолд саналын эрхийг хязгаарлах;

- Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үед аудит, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх, эрсдэлийн удирдлагын хороонд саналын эрхтэйгээр оролцохыг хориглосон зэрэг чухал өөрчлөлтүүд байв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-366 дугаар тушаалаар баталсан “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж, 2021 онд Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг УИХ-аар батлуулж, банкнуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн зохицуулалт хийгдсэн.

Зураг 79. Банкны салбарын дунд хугацааны шинэтгэлийн хөтөлбөр



Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгээр банкны салбарын хувьцаа эзэмшигчийн тоо 150 орчим байснаас 73 мянга болон нэмэгдэж банканд тавигдах олон нийтийн хяналт өргөжсөн.

2021 оны Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулалтаар санхүүгийн салбарын зохистой засаглалыг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- 2021 оны 3 сард “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”⁴⁰-ыг хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн боловсруулан батлуулж ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн;
- 2022 оны 3 сард Санхүүгийн Зохицуулах хорооноос Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зохистой засаглалын зарчимд нийцүүлэн

⁴⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207160412851&showType=1>

боловсруулсан “Компанийн засаглалын кодекс⁴¹”-ийг баталж, нээлттэй хувьцаат компани хэлбэртэй банкнуудын засаглалыг давхар үнэлж байна;

- 2022 оны 5 сард 2021 оны Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн холбогдох зохицуулалтуудыг тусгаж “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам⁴²”-ыг ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн;
- 2022 оны 12 сард Солонгосын Төв банктай хамтран “Монгол Улсын банкны салбар дах зохистой засаглалыг сайжруулах” хамтарсан судалгааг хийж хэвлэн гаргасан;
- 2023 оны 2 сард Банкны хяналт шалгалтын Базелийн хорооны зохистой засаглалын зарчмын дагуу арилжааны банкуудын ТУЗ-ийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн;
- 2025 оны 4 сард Банкны хяналт шалгалтын Базелийн хорооны зохистой засаглалын зарчимтай нийцүүлэн шинэчлэн найруулсан зохистой засаглалын журмын төслийг⁴³ олон нийтээс санал авахаар Монголбанкны цахим хуудсанд байршуулан танилцуулсан. Шинэчлэн найруулсан журмын төслөөр доорх зохицуулалтыг шинээр тусгаснаараа онцлогтой:
 - Банкнуудын эрсдэлтэй холбоотой мэдээллийг өргөн цар хүрээтэй ил тод тайлагнах тогтолцоог бүрдүүлэх;
 - Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах хүрээнд банкны эрсдэлийн удирдлагын нэгж, дотоод аудит, нийцлийн нэгжийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх;
 - Хувьцаа эзэмшлийн төвлөрлөөс үүсэх эрсдэлийг хязгаарлах хүрээнд ТУЗ-ийн бүрэлдэхүүн дэх хараат бус гишүүдийг олонх болгох;
 - Зохицуулагч байгууллагын хяналтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн тасралтгүй, үр дүнтэй, бодитой үнэлгээг өгөхөд чиглүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үе шаттайгаар нэвтрүүлэх.

7.4. Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүд

Банкны системийн хэмжээнд 2025 оны 2 дугаар улирлын байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт хангагдаж байна. Тайлант улиралд банкны системийн Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон Нийт өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүд тус бүр 14.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлагаас харгалзан 5.8 болон 2.8 нэгж хувиар тус тус давсан үзүүлэлттэй байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа тайлант улиралд банкны системийн хэмжээнд 36.3 хувьд хүрсэн нь зохистой харьцааны доод шаардлагаас 11.3 нэгж хувиар өндөр байна. Банкны системийн нийт орлого 4.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар өссөн бол нийт зардал 3.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс

⁴¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468331291331&showType=1>

⁴² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530282425931>

⁴³ <https://www.mongolbank.mn/mn/r/9143>

34.4 хувиар өссөнөөр 2025 оны 2 дугаар улирлын байдлаар цэвэр ашиг 795.4 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.5 хувь буюу 114.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Ашгийн бууралтад хүний нөөцийн болон бусад зардал өссөн, арилжааны болон ханшийн тэгшитгэлийн орлого буурсан зэрэг нөлөөлсөн байна.

Банкны салбарт тулгамдаж буй эрсдэл

Банкны системийн зээлийн өсөлт 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буюу 8.9 их наяд төгрөгөөр өссөнөөс тайлант улиралд иргэдийн (21.1%) болон байгууллагын (20.8%) зээлийн багцууд жигд өсөлтийг үзүүлсэн байна. Тайлант улиралд Монголбанкнаас иргэдэд шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоосны үр дүнд байгууллагын зээлийн өсөлт нэмэгдэж, банкны системийн зээлийн багц дахь иргэдийн зээлийн төвлөрлийн эрсдэл буурах хандлага ажиглагдаж байна.

Банкнуудын боловсруулах үйлдвэрлэл болон барилгын салбарт олгосон анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл хамгийн өндөр түвшинд буюу 17.8 хувь болон 17.0 хувь байгаа боловч тайлант улиралд барилга болон үл хөдлөх хөрөнгө (ипотек)-ийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад харгалзан 37.3 хувь болон 26.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд банкны систем дэх иргэдийн хэрэглээний болон цалингийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ хамгийн өндөр хэвээр буюу тухайн дэд зээлийн багцдаа харгалзан 11.9 хувь болон 10.5 хувийг бүрдүүлж байгаа нь цаашид иргэдийн зээлийн багцын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн банкнаас цалингийн зээлд хамрагдсан зээлдэгчдийн тодорхой хэсэг нь банк бус санхүүгийн байгууллагаас давхар зээл авсан байгаа нь дээрх зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж, нийт санхүүгийн салбарын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Банкнуудын эх үүсвэрийн болон үйл ажиллагааны зардал нэмэгдэх төлөвтэй байна.

Банкнудын Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 их наяд төгрөгөөр буурч, мөнгөн хөрөнгө мөн дүнгээр өссөн байгаа нь цаашид банкнуудын эх үүсвэрийн зардал нэмэгдэх төлөвтэйг илтгэж байна. Нөгөөтгээгүүр, тайлант улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкнуудын харилцах дансны үлдэгдэл 12.8 хувиар буурсан бол хадгаламжийн дансны үлдэгдэл 25.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид банкнуудын хадгаламжийн дансны төвлөрөл үргэлжлэн нэмэгдэж, эх үүсвэрийн зардал нэмэгдэхээр байна.


Тайлант улиралд банкнуудын нийт эх үүсвэр дэх гадаад валютын ханшийн нөлөөгүй өөрчлөлт нь гадаад валютын ханшийн нөлөөтэй өөрчлөлтөөс давсан (460.9 тэрбум төгрөгөөр) үзүүлэлттэй байгаа нь банкны систем дэх гадаад валютын эх үүсвэрийн төвлөрөл нэмэгдэж байгааг илтгэж, цаашид банкнуудын гадаад валютын ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй байна.

Банкны системийн цэвэр ашиг 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.5 хувиар буурч, банкнуудын зардлын өсөлт нь орлогын өсөлтөөс давсан үзүүлэлттэй байна. Үүнд банкнуудын арилжааны болон ханш, үнэлгээний тэгшитгэлийн ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108.3 тэрбум төгрөгөөр (-45.5%) буурч, хүний нөөцийн болон бусад зардал 127.3 тэрбум төгрөгөөр (16.3%) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Шигтгээ 6. Дэлхийн санхүүгийн зуучлалын шилжилт, түүний манай эдийн засагт үзүүлэх нөлөө

Дэлхийн санхүүгийн хямралаас хойш санхүүгийн системд хоёр томоохон бүтцийн өөрчлөлт гарсан. **Нэгт, хөрөнгийн урсгал хувийн сектороос улсын сектор руу шилжсэн.** Өөрөөр хэлбэл, санхүүгийн зуучлагчид хувийн секторт зээл олгох, хөрөнгө оруулахаас илүүтэйгээр засгийн газрын бонд, зээлийг түлхүү санхүүжүүлэх болсон бөгөөд засгийн газрын өр нь нийт зээлийн өсөлтийн гол хөдөлгөгч болсон. Төсвийн алдагдал болон Ковид-19 цар тахлын үеийн төсвийн тэлэлтийн бодлого нь энэ өсөлтийг улам түргэтгэв. Үр дүнд нь, засгийн газрын бондын зах зээл нь хувийн секторын зээл, бондын зах зээлээс илүү хурдтай. Манай улсын хувьд банкнаас дотоодын хувийн секторт олгосон зээлийн нийт ДНБ-д эзлэх хувь 2013 онд хамгийн их буюу 59.9%-д хүрсэн бол түүнээс хойш тасралтгүй бууран 2023 оны байдлаар ДНБ-ий 38.6%-тай тэнцэх болов (World Bank). Мөн энэ онд засгийн газар 2026, 2028 онд төлөх бондуудыг санхүүжүүлэх 500 сая ам.долларын “Century IV” бонд гаргасан бөгөөд бондын захиалга арилжаалах хэмжээнээс 8.2 дахин давж, хөрөнгө оруулагчдаас нийт 4.1 тэрбум ам.долларын захиалга иржээ (CNBC). Иймд манай улсын хувьд ч мөн санхүүгийн системд хувийн секторын зээлийн эзлэх хувь буурч, засгийн газрын бондын үүрэг нэмэгдэж байна.

Зураг 80. Засгийн газрын бонд гаргалт нь хувийн секторт олгосон зээлээс давсан.



Эх сурвалж: IMF; улсын өгөгдөл; BIS


Хоёрт, санхүүгийн зуучлал банкнаас банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ) руу шилжсэн. Засгийн газрын бондын зах зээл өргөжихтэй зэрэгцэн ББСБ-ууд тус зах зээл, мөн бусад үндсэн бондын зах зээлүүдэд⁴⁴ санхүүгийн гол зуучлагчийн үүргийг гүйцэтгэх болов. Улмаар, ББСБ-уудын нийт хөрөнгө 2009-2023 оны хооронд дэлхийн ДНБ-ий 167%-аас 224%-тай тэнцэх хэмжээнд хүрч өссөн бол банкуудын нийт хөрөнгийн өсөлт харьцангуй бага буюу

⁴⁴ Хамтын сан, тэтгэврийн сан, даатгал, баялгийн сан, эрсдэлийн (хедж) сан гэх мэт.

дэлхийн ДНБ-ий 164%-аас 177%-тай тэнцэхүйц болж өсжээ. Манай улсын хувьд ч мөн ББСБ-уудын нийт хөрөнгө 2009-2024 оны хооронд ДНБ-ий 1.5%-аас 8.9%-тай тэнцэх хэмжээнд хүрч өссөн. Харин банкуудын нийт хөрөнгийн өсөлт ДНБ-ий 65.3%-аас 89% болж өсжээ.

